

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ



СЭТҮҮЛ
ДУГААР 2024 / 4



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРОО



www.m-election.mn

GECMongolia



Монгол Улсын Сонгуулийн
ерөнхий хороо



РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Б.Цэцэгдэлгэр

Референт-хэвлэлийн төлөөлөгч

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.Ариунболд

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн ахлах мэргэжилтэн

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор

ГИШҮҮД

П.Алтанчимэг

Улс төрийн намын мэдээлэл, арга зүйн газрын референт

Ш.Сүхбаатар

Хууль зүйн доктор, судлаач

С.Оюунтуяа

"Сонгогчдын боловсрол төв" ТББ-ын гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

"Чимид сан"-ийн тэргүүн

З.Бадмаараг

Сэтгүүлч

С.Уянга

"Сонгуулийн боловсрол" клубийн удирдах зөвлөлийн дарга

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

@Бүтээлийн зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан тул олшруулахыг хориглоно.

АГУУЛГА

5
7

1. СОНГУУЛЬД СУРАЛЦАХУЙ

- Сонгуулийн үйл явцын эрх зүйн үндэс

2. ДУГААРЫН ЗОЧИН

- Д.БАТ-ЭРДЭНЭ: Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааг бэхжүүлэх, сайжруулахаар дата мэдээллийг судалгаа, шинжилгээний эргэлтэд оруулах нь чухал
- Э.ТУНГАЛАГ: Сонгуулийн нээлттэй өгөгдлийн дүрслэлийг зохиогчийг дурдах нөхцөлтэйгөөр чөлөөтэй ашиглах, нийтлэх, түгээх боломжтой
- Б.ТӨРБОЛД: Сонгуулийн эрх зүйн судалгаануудыг эргэлтэд оруулж, олон нийтэд таниулж хөгжүүлэх нь ач холбогдолтой

12

3. СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙ

- Сонгууль-Шууд ардчиллын нэг чухал хэлбэр
- Гадаад улсуудын сонгуулийн удирдлагын байгууллагын эрх зүйн байдал
- Сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх талаарх судалгаа болон бие даасан байдлыг хэмжих шалгуур үзүүлэлт

22

4. СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ

- Сонгуулийн хууль тогтоомжийн тогтвортой байдал ба сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагаа
- Сонгогчдод мэдээлэл хүргэх арга зам, идэвхжүүлэлт

27

5. ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн эргэн тойронд...
- "Сонгогчийн нээлттэй өдөрлөг, сонгох эрхийн өдөр-10.11" арга хэмжээг улс даяар зохион байгуулав

34

6. ХУУЛЬ ТОГТООМЖ

- Улс төрийн намын эрх зүйн орчин, шинэчлэл

38

7. ГАДААД ХАРИЛЦАА

- Сонгуулийн ерөнхий хороо Азийн сонгуулийн байгууллагуудын холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдлоо
- Сонгуулийн ерөнхий хорооны дарга Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбооны Ерөнхий ассамблейн чуулганд оролцов
- Америкийн Нэгдсэн Улсын 47 дахь ерөнхийлөгчийг сонгох сонгуулийг ажиглалаа
- Бүгд Найрамдах Киргиз улсад орон нутгийн сонгууль болов
- Гүрж улс сонгогчдынхоо саналыг анх удаа санал тоолох автомат төхөөрөмжөөр тооллоо

43

8. МОНГОЛЫН СОНГУУЛЬ ДЭЛХИЙД

- Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг ажигласан Олон улсын сонгууль ажиглах хорооны урьдчилсан дүгнэлт



UIN.MN
СУДАЛГААНЫ САН



1924

100

2024

Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж,
анхдугаар Үндсэн хууль баталсны

100 жилийн ойн

мэнд хургэе!



БҮГД НАЙРАМДАХ УЛСЫГ ТУНХАГЛАЖ, АНХДУГААР ҮНДСЭН ХУУЛЬ БАТАЛСНЫ 100 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭЛЭЭ

Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр орон даяар тэмдэглэлээ.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр баталсан “Үндсэн хуулиа дээдлэн залах тухай” 43 дугаар тогтоолд төрийн бүх байгууллага, Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар Үндсэн хуулиа дээдлэн залах, иргэн бүр Үндсэн хуулиа

судлан мэдэж, айл өрх бүр Үндсэн хуулиа дээдлэн залахыг уриалахаар тусгажээ.

Мөн Үндсэн хуулийн агуулга, улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөөний ойлголтыг бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын агуулгад тусган, түгээн дэлгэрүүлж, тайлбарлан таниулахыг Монгол Улсын Засгийн газар болон холбогдох бусад төрийн байгууллагад даалгасан байна.

СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС*

(агуулгын ба хэлбэрийн хууль)

Бяраагийн ЧИМИД

Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор, профессор



Хуулийг “материаллаг” (агуулгын) хууль, “процессын” (хэлбэрийн) хууль гэж хоёр хуваана. Энэ бол угтаа «хуулийг хуулиар биелүүлдэг» гэсэн үг. Юу вэ? гэвэл аливаа хүн хийгээд хуулийн этгээдийн эрх зүйн байдал, тэр дундаа эрх, үүргийг тогтоосон хуулийг агуулгын (материаллаг) хууль гэдэг. Байгууллагын тухай хууль гэхэд тэр нь зорилго, зорилт, эрх, үүрэгтэй, ямар бүрэлдэхүүн, бүтэцтэй, ямар хариуцлага хүлээх үндэслэлтэйг тодорхойлсон байдаг. Харин тэр хууль заалтыг **хэн, хэзээ, хаана, хэрхэн, ямар** хэлбэр, арга замаар биелүүлэхийг үйл явцын журмаар тодорхойлон зохицуулдаг. Жишээ нь, нам, эвсэл, иргэн өөрөө Улсын Их Хурлын гишүүнд **нэр дэвшүүлэх эрхтэй**. Энэ бол агуулгын чанартай заалт. Харин хэзээ яаж дэвшүүлэх, хэд хоногийн дотор бүртгүүлж, үнэмлэх авах, хэзээ уулзалт хийх зэргийн дэс дараалсан ажиллагааг үйл явцын журмаар тохируулна. Агуулгын хуулийг хэлбэрийн (үйл явцын) хуулиар дамжуулан хэрэгжүүлнэ гэдэг юм. Иймд ажил хийе, эрхээ эдэлье гэвэл үйл явцын журмыг сайн мэдэх хэрэгтэй. Энэхүү үйл явцын хууль (процессын журам) нь агуулгын **хуулийн амьдрах хэлбэр** болно.

- сонгох, сонгогдох эрх нь агуулга,
- сонгууль явуулах нь үйл явц,
- түүнийг хуулиар зохицуулах нь үйл явцын эрх зүйн журам гэж болно.

Сонгуулийн үйл явц бол нэг нь нөгөөгөө залгамжилсан, тодорхой дэс дараалсан үе шатуудаас бүрдэнэ. Түүний үйл явцыг хуулиар зааглаж, хугацаалж журамлана. Улсын Их

Хурлын сонгуулийн үйл явцыг дараах үе шатанд хуваан журамлажээ:

1. Сонгуулийг товлон зарлах;
2. Сонгуулийн тойрог, хэсэг байгуулах;
3. Сонгуулийн хороодыг байгуулж ажиллуулах;
4. Сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх;
5. Гишүүнд нэр дэвшүүлэх;
6. Нэр дэвшигчдийг бүртгэх;
7. Сонгогчдын нэрсийн жагсаалт гаргаж танилцуулах;
8. Сонгуулийн өмнөх сурталчилгааг зохион байгуулах;
9. Сонгогчдын санал хураах;
10. Саналыг тоолж, санал хураалтын урьдчилсан дүнг зарлах;
11. Сонгуулийн албан ёсны дүнг нэгтгэн зарлах;
12. Сонгогдогчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх гэсэн үндсэн үе шатанд хувааж журамлажээ. Сүүлчийнх нь тусдаа хуультай.

Харин сонгуулийн санал хураалтын дүнг тоолж гаргахад хууль зөрчигдсөн нөхцөл байдал тогтоогдвол тэр хэсэгт **дахин санал хураах**, аль нэг тойрогт нэр дэвшигчдийн хэн нь ч хуулиар тогтоосон хувийн санал аваагүй зэрэг хуульд заасан шалтгаан байвал тэнд **дахин сонгууль** явуулах үйл явцын үе шат ч **нэмэгдэж** болно.

* Б.Чимид. “Сонгуульд суралцахуй”. УБ 2008. 69-72 дахь тал

Улс, иргэний амьдралд сонгуулийн **ЭХЛЭЛ, ТӨГСГӨЛ** хоёулаа нэн чухал.



Эдгээр үе шатны үйл явцыг сонгууль зарлахаас шууд эхэлдэг тул энэ тухай дор онцлон авч үзье.

СОНГУУЛЬ ТОВЛОН ЗАРЛАХ

Улс, иргэний амьдралд сонгуулийн **эхлэл, төгсгөл** хоёулаа нэн чухал. Аливаа сонгуулийн цогц ажил «хууль ёсоор цагтаа эхэлж, цагтаа дуусаж бусад цаг үед ард олон амар жимэр аж төрөх ёстой». Үргэлж л сонгууль гэж бужигнаж, амар тайван амьдралынхаа хэмнэлийг байн байн алдаж, сэтгэл зовнин, хөрөнгө үрж, ажлаа хийдүүлж суухыг хэн хүсэх билээ. Түүний оронд 4 жилд нэг удаа болоод өнгөрдөг сонгуулиа товлосон хугацаанд нь төлөв төвшин явуулах, түүнд идэвхтэйхэн оролцож “болдог хүнээ” сонгогчоод төлөөлүүлэн үйлчлүүлж, хянан чиглүүлж суух нь хол дээр бус уу. Ёстой л сэтгэл амсхийж “гар газар, хөл хөсөр” амар жимэр аж төрөх боломж олддог билээ. Гэтэл нэг “сонгуулиас нөгөөг хүртэл” уг ажлыг ил далд үргэлжлүүлэн хүн ардын сэтгэл оюуныг цочроох нь хавтгайрч, тэр ч байтугай улс төрийг хямраах нь бий. Сонгуулийн тухай хуульд «37.1 нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигч ... бүртгүүлж үнэмлэх авсан өдрөөс эхлүүлнэ» гэсэн нь түүнээс өмнө кампани өрнүүлж болохгүй гэсэн утгатай. Гэтэл одоо сонгууль зарлах яагаа ч үгүй байхад нэлээд улс төрч “Шилдэг-76” гэхчлэн өөрсдийгөө дэвшүүлчхээд хэвлэл

мэдээллийн хэрэгслээр бичих, ярих, үзүүлэх нь хавтгайрчээ. Энэ бол угтаа хориотой, улсдаа хортой явдал юм. Ийм байдал гаргуулахгүйн тулд сонгуулийн кампанийг хуулиар тогтоосон эхлэх, дуусах хоёр цаг хугацааны хооронд л явуулдаг. Энэ нь сонгууль товлон зарласнаар эхэлж эцсийн дүнг албан ёсоор зарлан мэдээлснээр дуусдаг. Тийн эхлэхийг нь товлон мэдээлээгүй байхад олон түмний дотор сонгуулийн ухуулга хийх, нэр дэвшүүлэх гэж оролдох, ятгах зэрэг ямар ч үйл ажиллагаа явуулах ёсгүй.

Сонгуультай ямар ч холбоогүй гэх боловч чухамдаа л сонгуульд хамаатуулан цагаан сар, эмэгтэйчүүд, эх үрсийн баяраар зөвхөн нэр дэвшихийг хүсэгчид л бэлэг тарааж байгааг юу гэж ойлгох вэ? Үүний нөгөө туйлд сонгууль дууссаныг зарлан мэдээлсний хойно ямар нэг байдлаар аль нэг тойрог уг ажлыг үргэлжлүүлж болохгүй.

Улс төрийн нам, эсвэл нь ээлжит хоёр сонгуулийн хооронд дотооддоо зүгээр суухгүй л дээ. Харин өөр олон ажил ундарна. Юуны өмнө, өнгөрсөн сонгуульд оролцсон үйл ажиллагааныхаа алдаа, оноог цэгнэн үзэж, ирэх сонгуульд бэлтгэн оролцох хөтөлбөр тэргүүтнээ боловсруулж, хүний нөөцөө бүрдүүлэх зэргээр «дотоод» заслаа хийж, сонгууль товлон зарлахыг тэвчээрлэн хүлээж хуулиа хүндэтгэн сахина. Эл зарчмыг эс дагавал улс төрд муу нөлөө, олон түмэнд түвэг бэрхшээл учруулах болно. Сонгуулийн тухай хуулийн Улсын Их Хурлын сонгуулийн төрөл тус бүрийн эхлэх дуусгавар болгох эзэн, хугацаа журмыг тогтоосон байдаг. Сонгуулийг хугацаанд нь зарлах явдал Үндсэн хуулийн хөдөлшгүй шаардлага мөн. Түүнийг алгуурлах нь дур зоргын ажиллагаа, дарангуйлал бий болж буйн шинж тул сэрэмжилнэ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙГ ЗАРЛАХ ТУХАЙ СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 8 ДУГААР ЗҮЙЛЭЭС:

«8.1. Сонгуулийг санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал товлон зарлана.»

(Сонгуулийн тухай хууль 2005 он)

Ээлжит бус хийгээд нөхөн, дахин сонгууль зарлах хугацаа журмын тухай “Улсын Их Хурлын сонгууль” гэсэн 2 дахь хэсэгт дурдсаныг эргэж үзнэ үү¹.

Сонгуулийг товлон зарласнаар сонгуулийн үйл явц эхэлж дүнг гаргаж нийтэлтэл үргэлжлэх тул дараагийн бүлгүүдэд² дэс дараалан өгүүлэв.

1 “Сонгуульд суралцахуй” номын 57-62 дахь тал, “Сонгуулийн боловсрол” сэтгүүлийн 2023/03 дугаараас үзнэ үү.

2 “Сонгуульд суралцахуй” номын дараагийн бүлгүүдийг “Сонгуулийн боловсрол” сэтгүүлийн дараагийн дугааруудад цувралаар нийтлэх болно.

Д.БАТ-ЭРДЭНЭ:

**СОНГУУЛЬ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ҮЙЛ
АЖИЛЛАГААГ
БЭХЖҮҮЛЭХ,
САЙЖРУУЛАХААР
ДАТА МЭДЭЭЛЛИЙГ
СУДАЛГАА,
ШИНЖИЛГЭЭНИЙ
ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ
НЬ ЧУХАЛ**



Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ:

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны гол онцлог бол хэн, хэзээ юуг хийсэн байх талаар нарийвчлан тогтоосон хугацаанд явагддаг бөгөөд эдгээр нь нэг нь нөгөөгөөсөө шууд хамааралтай процесс үйл ажиллагаа байдаг. Хэрэв аль нэг үйл ажиллагааны дараалал алдагдах юм бол дараагийн үйл ажиллагаануудыг зохион байгуулах боломжгүй болох нөхцөл байдалд хүргэдэг процессын эрх зүйн харилцаа юм. Үйл ажиллагааны суурь зохион байгуулалт нь бүх төрлийн бүртгэл дээр үндэслэн явагдаж байдаг. Тухайлбал, сонгуулийн тойрог, хэсгийн бүртгэл, нам, эвслийн бүртгэл, нэр дэвшигчийн бүртгэл, сонгуулийн сурталчилгааг зохион байгуулах менежер, шадар туслагч, ухаалагч, ажиглагчийн бүртгэл зэрэг олон төрлийн бүртгэлийн үйл ажиллагааг хуулиар нарийвчлан тогтоосон хугацаанд зохион байгуулдаг.

Сонгууль бүрээр эдгээр бүх төрлийн бүртгэлээс олон төрлийн дата мэдээлэл бүхий сан үүсдэг бөгөөд энэхүү дата мэдээллийг сонгууль зохион байгуулах үйл ажиллагааг бэхжүүлэх, сайжруулах зорилго бүхий судалгаа, шинжилгээний эргэлтэд оруулах нь чухал юм.

Аливаа үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин нь тасралтгүй үргэлжлэх судалгаа, шинжилгээнд суурилсан хэрэгжих боломжтой санал, санаачлагад үндэслэн хөгжиж байдаг билээ.

Монгол Улсын хувьд сонгуулийн эрх зүй, сонгуулийн процессын эрх зүйн хөгжил нь цаг хугацааны хувьд ээлжит сонгуулийн циклтэй харилцан хамааралтайгаар тодорхой давтамжтайгаар шинэчлэгддэг онцлогтой. Гэтэл сонгуулийн ямар тогтолцоо сонгож хэрэглэж байна вэ, хэрэглэх шаардлагатай вэ гэдэгтэй зэрэгцүүлэн авч үзэх, судлах зүйл бол сонгуулийн шударга, нээлттэй зохион байгуулалт, үйл ажиллагааны ил тод байдлыг бүрэн хангаж ажиллах эрх зүйн орчин, зохион байгуулалт юм. Иймд Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн эрх зүй, сонгуулийн процессын эрх зүйн хөгжилд хувь нэмрээ оруулах зорилго бүхий судалгаа, шинжилгээний ажлыг нэмэгдүүлэх зорилгоор сонгуулийн явцад үүссэн дата мэдээллийг дүрслэл болгон хөгжүүлэн ажиллаж байна.

Э.ТУНГАЛАГ:

СОНГУУЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ДҮРСЛЭЛИЙГ ЗОХИОГЧИЙГ ДУРДАХ НӨХЦӨЛТЭЙГӨӨР ЧӨЛӨӨТЭЙ АШИГЛАХ, НИЙТЛЭХ, ТҮГЭЭХ БОЛОМЖТОЙ

Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн нээлттэй мэдээллийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй хүргэх, нээлттэй өгөгдлийн бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор “Тунгаахуй” өгөгдлийн урлантай хамтран ажилладаг. “Тунгаахуй” өгөгдлийн урланг үүсгэн байгуулагч Э.Тунгалагтай ярилцлаа.



-Өгөгдлийн дүрслэлээс мэдээлэл авахад хялбар, ойлгомжтой байдаг. Судлаачдад их чухал мэдээлэл санагддаг.

“Өгөгдлийн дүрслэл” (data visualization) нь өгөгдөл ба дизайны шийдлийг хослуулан өгөгдлийг ойлгомжтой дүрслэн харуулах замаар богино хугацаанд мэдээлэл авах боломжийг олгодог. Өгөгдлийг өгөгдлийн дүрслэл болгон хувиргаснаар их хэмжээний задгай өгөгдлийг бус, гол үр дүнг сонирхолтойгоор “харах” боломж нээгдэнэ. Өгөгдлийг

харьцуулах, өөрчлөлт, хувьслыг ажиглах, өгөгдлийн цаана нуугдсан санааг олж харахад өгөгдлийн дүрслэл тусалдаг. Зөвхөн судлаачид ч биш олон нийт мэдээллийг цэгцтэй, ойлгомжтой авах боломжтой.

-2024 оны ээлжит сонгуулиар маш олон төрлийн “өгөгдлийн дүрслэл” бүтээсэн байна. Дүрслэлүүдээрээ үзэсгэлэн гаргахад олон нийт маш их сонирхож байсан.

- Сонгуулийн ерөнхий хороо Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаарх өгөгдлийг хамгийн өргөн хүрээнд бүрдүүлж чадсан. “Тунгаахуй” өгөгдлийн урлан тэдгээр нээлттэй өгөгдөлд суурилсан дүрслэлүүдийг хөгжүүлж, сонгуулийн хүйсээр ангилсан өгөгдлийн дүрслэлийн нээлттэй сан бүтээлээ. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-ын санхүүжилттэй “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр энэхүү ажлыг хэрэгжүүлсэн юм.

Нээлттэй өгөгдлийн дүрслэл хөгжүүлсэн нь төрийн нээлттэй мэдээллийг “өгөгдлийн дүрслэл” хэлбэрээр бүтээгдэхүүн болгон хувиргаж буй хэлбэр бөгөөд өгөгдлийн бодит хэрэглээг дэмжих, эргэлтэд оруулах, хүртээмжийг



дээшлүүлэх зорилготой. Бидний бүтээсэн өгөгдлийг зохиогчийг дурдах нөхцөлтэйгөөр чөлөөтэй ашиглах, нийтлэх, түгээх (CC BY 4.0 лиценз) боломжтойгоороо онцлогтой. Сонгууль зохион байгуулах үйл явц болон үр дүнгийн талаарх нээлттэй мэдээлэл, дата өгөгдлийг олон нийтэд ойлгомжтой байдлаар танилцуулах, сонгуулийн боловсрол олгох, судалгаа, шинжилгээний эргэлтэд оруулах зорилгоор дүрслэлүүдээ m-election.mn, tungaahui.mn цахим хуудас болон мэдээллийн сайтууд, нийгмийн сүлжээгээр олон нийтэд хүргэдэг.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн зохион байгуулалт, үр дүнгийн нээлттэй мэдээлэлд суурилсан бүтээсэн 100 орчим өгөгдлийн дүрслэлийн дээжээс “Өөрчлөлтийн зүгт” хоёр удаагийн үзэсгэлэн гаргалаа.

-100 гаруй өгөгдлийн дүрслэл бүтээсэн гэлээ. Дүрслэлд ямар, ямар мэдээлэл багтсан бэ?

-Сонгуулийн нээлттэй өгөгдлийн дүрслэлийн сангаас сонгогч, нэр дэвшигч, сонгуулийн ирц, үр дүн гэх мэт сонгуулийн үйл явц дахь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцооны талаар өгөгдөлд суурилсан бодит ойлголт, мэдээлэл авах, салбарын мэргэжилтэн, бодлого боловсруулагч, судлаач, сэтгүүлчид гэх мэт олон талын оролцогч талууд өгөгдлийн дүрслэлийг хэрэглэгдэхүүн болгон чөлөөтэй ашиглах боломж нээгдэж байна.



СОНГУУЛИЙН НЭЭЛТТЭЙ
ӨГӨГДЛИЙН ДҮРСЛЭЛИЙН САН

Б.ТӨРБОЛД

СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН СУДАЛГААНУУДЫГ ЭРГЭЛТЭД ОРУУЛЖ, ОЛОН НИЙТЭД ТАНИУЛЖ ХӨГЖҮҮЛЭХ НЬ АЧ ХОЛБОГДОЛТОЙ


Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг нийтэд тайлбарлан таниулах, сонгуулийн эрх зүй, сонгуулийн процессын эрх зүйн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг нэмэгдүүлэх, мэргэшсэн судлаач бэлтгэх, сонгуулийн мэдээллийн нэгдсэн сан (www.e-election.mn)-ийн мэдээллийг судалгааны эргэлтэд оруулах, сонгогчдод сонгуулийн боловсрол олгох чиглэлээр “Легал дата” компанитай хамтран ажилладаг. “Легал дата” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн Б.Төрболдтой ярилцлаа.

-Хуульч, судлаачид сонгуулийн эрх зүйг судлах нь хэр нийтлэг юм бол?

-Зохицуулалт хийх болон хяналт тавих чиг үүргийг хараат бусаар хэрэгжүүлэх замаар ардчилсан засаглалыг бэхжүүлж шударга, зарчимч байдлыг хангах, үндсэн хуульт ардчиллыг бататгах зорилготой бие даасан байгууллагуудын нэг нь Сонгуулийн ерөнхий хороо юм. Өөрөөр хэлбэл, улс төрийн хувьд төвийг сахисан, төрийн эрх мэдлийн гурван

салаа мөчрөөс хараат бус, шударга ёсыг сахиулж, ардчилсан засаглалын чанар, тогтвортой байдлыг хангах зорилго бүхий нийтийн эрх зүйн этгээд гэж ойлгодог. Улс төрийн болоод институтын хувьд хараат бус байх нь ардчилсан тогтолцоонд хүлээх үүргээ гүйцэтгэх гол нөхцөл болдог. Энэхүү бие даасан байгууллагыг бүрдүүлэхэд юуны өмнө Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлал, үндсэн зарчмыг баримталж зохицуулах нь зүйн хэрэг юм.





Үүнд төрийн эрх мэдлийг аливаа этгээдэд төвлөрүүлэх бус, хуваарилах замаар хяналт, тэнцлийг хангах нь хэзээд баримтлах учиртай гол зарчим билээ. Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалын нэгээхэн хэсэг болох уг зарчмын хүрээнд судлаачид сонгуулийн байгууллагын тогтолцоо, бүрэн эрх, чиг үүрэг, томилгооны эрх зүйн зохицуулалтын талаар судалсан байдаг.


Сүүлийн үед залуу судлаачид Сонгуулийн эрх зүйн талаар судалгаа хийх болсон. Ийнхүү судалгаанууд хийгдэж эхлэхээр энэ салбарын эрх зүйн хөгжлийг том зургаар нь харах боломж нээгдэж байна гэж харж байна.

-Танай компани Сонгуулийн ерөнхий хороотой хамтран ажиллах Санамж бичиг байгуулсан. Хамтын ажиллагааны хүрээнд сонгуулийн эрх зүйн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдийг нэгдсэн санд оруулж байна. Ач холбогдол юу вэ?

-Судалгаа хийх нь нэг хэрэг. Харин сонгуулийн эрх зүйн судалгаануудыг эргэлтэд оруулж, энэ салбарын нээлттэй судалгааг олон нийтэд таниулж хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм. Сонгуулийн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг нийтэд тайлбарлан таниулах, сонгуулийн эрх зүй, сонгуулийн процессын эрх зүйн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг нэмэгдүүлэх, мэргэшсэн судлаач бэлтгэх, сонгуулийн мэдээллийн нэгдсэн сан (www.e-election.mn)-ийн мэдээллийг судалгааны эргэлтэд оруулах, сонгогчдод сонгуулийн боловсрол олгох чиглэлээр бид Сонгуулийн ерөнхий хороотой хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд сонгуулийн хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, судалгааны бүтээл, ном, товхимол, сэтгүүл болон лекц, хурал, хэлэлцүүлгийн видео бичлэгийг нийтэд мэдээлэх, тайлбарлан таниулах, сурталчлах зорилгоор <https://legaldata.mn/> цахим санд "Сонгуулийн эрх зүй" цэс нээж, мэдээлүүдийг эхнээс нь байршуулаад байна.

-Хэрэглэгч хэр олон байна вэ. Энэ салбарын мэдээ мэдээлэл, дата судалгааны эргэлтэд орох, судлагдах хэрэгцээ хэр их бол?

-legaldata.mn сайтад өдөрт 1000-1500 хэрэглэгч тогтмол ханддаг. Бид хамтын ажиллагааныхаа хүрээнд хууль эрх зүйн бүтээлүүдийг судалгааны эргэлтэд оруулах зорилгоор олон талт мэдээ мэдээлэл, судалгаа, хайлтын нэгдсэн систем, дата анализ, "LegalTalks" подкаст хийх зэргээр ажиллаж байна.





СОНГУУЛЬ - 2024

Эрдэм шинжилгээний ИЛТГЭЛИЙН УРАЛДААН

Сэдэв

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор жендэрийн тэгш эрхийг дэмжсэн болон бусад хуулийн зохицуулалтын үр нөлөөг тодорхой дүгнэх.
2. Сонгуулийн процессын эрх зүйд тулгамдаж буй асуудлыг бодит тоон мэдээлэлд тулгуурлан хөндөж, сайжруулах санал боловсруулах.

Бүртгүүлэх
2024.11.15-нээс 23-ны өдөр хуримал дуулианд ут QR кодыг уншуулан бүртгүүлнэ үү.

Илтгэл хүлээн авах
2024.12.10-ны өдөр илтгэл цаасаар болон цахимаар ирүүлэх

Нэгдүгээр шат
2024.12.18-ны өдөр илтгэлүүдийг хүлээн авч шалгаруулах

Хоёрдугаар шат
2024.12.20-ны өдөр илтгэлүүдийг хэлэлцүүлэх

ШАГНАЛЫН САН:

1. Өргөмжлөл, мөнгөн шагнал /3сая/, legaldata.mn цахим санг ашиглах Алтан багцын 1 жилийн эрх, Хууль дээдлэх ёс сэтгүүлд илтгэлийг нийтэлнэ.

2. Өргөмжлөл, мөнгөн шагнал /2сая/, legaldata.mn цахим санг ашиглах Алтан багцын 6 сарын эрх

3. Өргөмжлөл, мөнгөн шагнал /1сая/, legaldata.mn цахим санг ашиглах Мөнгөн багцын 6 сарын эрх




Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо



Мөн Сонгуулийн ерөнхий хороо, Хууль зүйн үндэсний хүрээлэн, "Легал дата" ХХК, "Тунгаахуй өгөгдлийн урлан" ХХК нар хамтран их, дээд сургуулийн оюутан, судлаач, мэргэжлийн албан хаагчдын дунд "Сонгууль-2024" эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан зохион байгуулахаар зарласан. Үүнтэй холбоотойгоор судлаачид хайлт хийх нь олширсныг статистик харуулж байна.

-Олон нийтийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэхэд энэ салбарын судалгаа, шинжилгээний бүтээл томоохон үүрэгтэй нь гарцаагүй. Сонгуулийн эрх зүйн нийтийн хэрэгцээнд аваачихад юу хийх хэрэгтэй бол.

-Аливаа мэдээлэл нээлттэй, хүртээмжтэй, хайлт хийхэд илэрц сайтай, ашиглахад хялбар байхад эргэлтэд орох нь амархан байх болов уу. Иргэний Үндсэн хуулиар баталгаажсан сонгох, сонгогдох эрхийн хүрээнд насанд

хүрсэн хүн бүр сонгуулийн талаарх мэдлэг, мэдээллээ сайжруулах, энэ төрлийн хууль тогтоомжийн мэдлэгээ энгийн агуулгаар хүлээн авч чадвал нийтийн хүртээл болж чадах байх гэж бодож байна.

-Сонгуулийн эрх зүйн салбарт хийгдэж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг хөгжүүлэхэд юунд хэрхэн анхаарах вэ?

- Судалгаа хийх сонирхол, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай. Тухайлбал, их, дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт Сонгуулийн эрх зүйн талаар сонгон судлах боломжтой байдлаар хичээл тусгуулах, мэргэшсэн залуу судлаачдыг бэлтгээд эхэлбэл жилээс жилд энэ салбарын судалгааны бүтээл нэмэгдэж, иргэдийн сонгуулийн боловсрол дээшлэх боломжтой гэж харж байна.

Академич Ж.Амарсанаа

СОНГУУЛЬ-ШУУД АРДЧИЛЛЫН НЭГ ЧУХАЛ ХЭЛБЭР



1. Төрийг жолоодоход иргэд оролцох асуудлыг эрт үеэс хөндөж иржээ. Суут сэтгэгч Демокрит, Платон, Аристотел нар философийн бүтээлдээ энэ талаар бичиж байжээ. Гэхдээ 18 дугаар зууны үеэс Францын соён гэгээрүүлэгч, философичид ард түмэн төрийг удирдахад оролцох шаардлага, боломжийн талаар бодит үндэслэлтэй үзэл санаа, дүгнэлтийг бодож боловсруулсан байна. Ард түмний эрх мэдлийн тухай эдгээр үзэл, номлол нь эдүгээ цагийн улсуудад, түүний дотор Монголын улс төрийн амьдралд ч тусгалаа олж, үр нөлөөгөө үзүүлсээр байна.



Ш.Л.Монтескё хууль бүтээх эрх ард түмэнд хамааралтай. Төлөөлөх ардчилал бол шууд ардчиллаас эх үүсэртэй гэжээ. Ж.Ж.Руссо ард түмэн шууд удирдаж байвал ардчилал хэрэгжих боломжтой. Хууль бол ердөө л бүх нийтийн хүсэл зоригийн илэрхийлэл юм. Ингэхээр хуульд захирагддаг ард түмэн чухамхүү түүнийг бүтээгч нь юм гэж үзэж байжээ.

Францын 1789 оны хувьсгалаар ард түмний эрхийн Тунхаглал баталж, түүндээ "Аливаа дээд эрхийн эх үндэс нь үндэстэн мөн. Ямар ч байгууллага, ямар ч хувь хүн үндэстнээс эх үүсвэргүй эрх мэдлийг эдэлж болохгүй." гэж заасан байна.

Дээрх үзэл санаа 20 дугаар зууны эхээр олон улсын харилцааны олон чухал баримт бичигт тусгалаа олсон билээ. Эдгээрээс заримыг дурдъя. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1949 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан "Хүний эрхийн түгээмэл тунхаглал"-д хэрхэн туссаныг сонирхье. Уг тунхаглалын 21 дүгээр зүйлд: "1. Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй, 2. Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй, 3. Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэхүү хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах болон саналаа чөлөөтэй гаргах явдлыг

хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хурамч бус сонгуулиар илэрлээ олно." гэжээ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1966 онд баталсан "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлд "а) төрийн хэргийг явуулахад шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох; б) сонгуулийн бүх нийтийн, тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох эрх, боломжийг эдэлнэ" гэж заасан байна.

Түүнчлэн эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай 1952 оны конвенц, эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай 1979 оны конвенцид "эмэгтэйчүүд бүх сонгууль, ард нийтийн санал хураалтад санал өгөх ба нийтээр сонгох бүх байгууллагад сонгогдох" эрхтэйг бататгасан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ." гэж тунхагласан билээ.



2. Сүүлийн гуч гаруй жилд олон орон удирдлагын ардчилсан арга, хэлбэрийг сонгон авч хэрэгжүүлж байна. Эдгээр орон эрх зүйн хувьд сонгууль, ард түмний хууль санаачлах эрх, ард нийтийн санал асуулга, санал хураалт, зөвлөлдөх санал асуулга зэрэг шууд ардчиллын хэлбэрийг Үндсэн хуульд тусган хэрэгжүүлж байна.



Төрийн эрх барих болон нутгийн удирдлагын байгууллагын сонгуульд төр, түүний байгууллагууд, иргэд, тэдгээрийн нэгдлийн хоорондын өвөрмөц онцлог бүхий харилцаа үүсч байгаа бөгөөд түүнийг сонгуулийн эрх зүйгээр зохицуулж байна.

Юуны өмнө сонгуулийн эрх зүй, сонгуулийн эрх хоёрыг зөв зааглаж ойлгох шаардлагатай.

Сонгуулийн эрх зүй нь сонгуулийг зохион байгуулах, түүнийг эрхлэн явуулах байгууллагын үйл ажиллагааны үндэс, зарчим, үе шат, оролцогчдын эрх, үүрэг, хариуцлага, баталгааг тогтоосон эрх зүйн хэм хэмжээний цогц мөн.

Энд голчлон Үндсэн хуулийн эрх зүй хамаарагдах бөгөөд захиргаа, иргэн, эрүү, зөрчил, хөдөлмөр, процессын эрх зүйн тодорхой хэм хэмжээ үйлчилж байна.

Тэгвэл сонгуулийн эрх нь иргэн сонгуульд оролцох, тодруулбал сонгох, сонгогдох төрөөс баталгаажсан эрх, боломж юм. Сонгуулийн эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг улсууд Үндсэн хуульдаа баталгаажуулсан байдаг. Улсуудын Үндсэн хуульд бүх нийтийн, тэгш, шууд, чөлөөтэй, нууц, хугацаатай, ил тод байх зэрэг зарчмыг тусгасан байна. Италийн Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлд "Насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй иргэн бүр санал өгөх эрхтэй. Санал нь хувийн, чөлөөтэй, нууц байна. Санал өгөх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн. ... Эрх зүйн чадамжгүй, эрүүгийн ял эдэлж байгаа болон хуульд заасан зохисгүй үйлдэл гаргаснаас бусад тохиолдолд санал өгөх эрхийг хязгаарлаж болохгүй." гэжээ. Португалын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд ард түмэн улс төрийн эрх мэдлээ бүх нийтийн, тэгш, шууд, нууц,

тодорхой хугацаатай санал өгч хэрэгжүүлэхээр заасан байна. Ихэнх орны Үндсэн хуульд сонгуулийн хамгийн нийтлэг заалтыг тусгасан байх бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг Үндсэн хуульд нийцүүлэн баталсан хууль, эрх зүйн бусад актаар бататгасан байдаг.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай (2019) хуульд сонгууль бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгогч бүр оролцох эрхтэй байх, сонгогч бүр сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, санал нууцаар гаргах эрхтэй гэсэн байх ба Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай (2020) хуульд мөн дээрх хуулийн зарчим адил тусгагдсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно."; Гучин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт: "Анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргана." гэж тус тус заасан байна.

Өмнө дурдсанаар Иргэний болон улс төрийн эрхийн пактад: "... тэгш эрхийн үндсэн дээр ..." санал өгөх тухай заасан билээ.

Монгол Улсын Үндсэн хууль, мөн дээр дурдсан хуулиудад "тэгш эрх"-ийн тухай заалт байхгүй. Үүнийг Үндсэн хуулийг Аравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт: "Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг

дагаж мөрдөхгүй.” гэсэн заалтыг түшиж ойлгох боломжтой.

Үндсэн хуульд заасанчлан сонгуулийн эрх сонгох, сонгогдох гэсэн хэлбэрээр хэрэгжиж байна. Сонгох эрх гэдэг нь төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагад нэр дэвшигчийн төлөө юм уу, түүний эсрэг саналаа иргэд өгөх эрх юм. Харин сонгогдох эрх нь төрийн эрх мэдлийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллагад өөрөө сонгогдох эрх билээ.

3. Сонгуулийн зарчмын талаар тодруулъя. Сонгууль нь улс төрийн үүргийн хувьд ардчилсан ба ардчилсан бус шинжтэй хэрэгжиж байна. Энэ нь тухайн оронд сонгуулийг зохион байгуулж явуулахдаа сонгуулийн эрх зүйн зарчмыг хэр баримталж байгаагаас харагдаж байна.

Олон улсын эрх зүйн баримт бичигт сонгуулийн бүх нийтийн чөлөөтэй оролцох, тэгш оролцох, сонгууль шууд ба шууд бус байх, нууцаар саналаа өгөх зарчмыг бататгасан байх бөгөөд энэ нь сонгууль ардчилсан, хууль ёсны байх үндэс болж байна.

Сонгуулийн эрх бүх нийтийн байх нь тодорхой насандаа хүрсэн, сэтгэцийн өвчингүй хүнийг сонгуулийн талаар ямарваа нэгэн алагчлал бий болгож болохгүй бөгөөд хүйс, арьсны өнгө, яс үндэс, итгэл үнэмшил, эд хөрөнгийн болон албан тушаалын байдлыг үндэслэн сонгуулийн эрхийг хасах, хязгаарлахыг хориглодог. Үүний зэрэгцээ насанд хүрээгүй хүмүүс, шүүхээс сэтгэцийн өвчтэй гэж тооцогдож, шүүхийн шийдвэрээр хорих ял эдэлж байгаа хоригдлын сонгох, сонгогдох эрхийг хязгаарласан нь буй.

Ардчилсан сонгуульд зарим эрхийг хязгаарлах асуудал бий. Жишээлбэл, Испани, Финланд, Унгар зэрэг улсад орон нутгийн сонгуульд оролцох гадаадын иргэд нь хуульд заасан хугацаагаар оршин суусан, татвар төлсөн байхыг шаарддаг байна. Нэлээд хэдэн жилийн өмнө АНУ, Англи, Канад зэрэг оронд сонгох эрхийг 21 насаар тогтоож байсныг 18 болгож өөрчилжээ.

Сонгуульд чөлөөтэй оролцох эрх нь сонгох, сонгогдох эрхээ төр хийгээд улс төрийн хүчний оролцоогүй өөрөө бие даан шийдвэрлэх боломж юм.

Сонгуулийн явцад санал өгөхөөс зайлсхийх, татгалзах явдал цөөнгүй гардаг байна. Төрийн байгууллага намын үйл ажиллагаанд үл итгэх, мөрийн хөтөлбөр, улс төрийн бодлого, байр суурийг нь хүлээн зөвшөөрөхгүй байх, шударга сонгууль явагдахад үл итгэх, нөхцөл байдал өөрчлөгдөхөд эргэлзэх нь түүний илрэл юм. Ийм ч учраас Итали, Аргентин, Бельги, Грек, Турк зэрэг улсад сонгуульд санал өгч оролцоогүйн учир ёс суртахууны хариуцлага хүлээлгэх, захиргааны журмаар торгох, тэр бүү хэл хорих ял ч оноодог байна.

Тэгш сонгуулийн зарчим нь юуны өмнө сонгогч бүр

Гэхдээ сонгох ба сонгогдох эрхийн хооронд зохих ялгаа бий. Дийлэнх улсад сонгох эрх нь 18 наснаас эхэлдэг байхад харин сонгогдох эрх өөр өөр байх жишээтэй. Тухайлбал, АНУ, Португалд ерөнхийлөгчийн сонгогдох эрх 35 нас, Монгол Улсад 45 нас (1992) байсныг 50 нас (2019) болгосон бол Италид мөн 50 насаар тогтоосон байна.



адил санал өгөх буюу нэг сонгогч-нэг санал хэрэгжихийг шаарддаг. Гэхдээ энэ зарчмын хэрэгжих хамгийн гол болзол нь сонгуулийн тойргийн сонгогчид адил буюу ойролцоо тоотой байх явдал юм. Сонгуулийн тэгш зарчим нь хуулиар нэр дэвшигчид нэрээ дэвшүүлэх, бүртгэх, сонгуулийн сурталчилгаа хийх, сонгууль явуулах, дүн гаргах зарчмаар хэрэгждэг байна.

Шууд ба шууд бус сонгуулийн тухайд гэвэл аль аль нь сонгуулийн эрх зүйн зарчим юм.

Сонгуулийн шууд байх зарчмын дагуу сонгогч нь төрийн эрх барих болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг шат дамжлагагүй шууд сонгох, тэдгээрт сонгогдох боломжтой. БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуулийн дагуу иргэд олон шаттай сонгуульд илээр саналаа өгч оролцдог байсан бол Үндсэн хуулийн 1949 оны нэмэлт, өөрчлөлтөөр шууд, нууц сонгуулийн зарчмын дагуу сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх болжээ. Парламентын доод танхим, нэг танхимтай парламентын гишүүд, зарим тохиолдолд дээд танхим (Итали, АНУ, Бразил, Болгар зэрэг) шууд сонгуулиар сонгогдож байна.

Тэгвэл шууд бус сонгуулиар ерөнхийлөгч, парламентын гишүүдийг шууд сонгодоггүй байна. Энэ нь хоёр хэлбэртэй хэрэгждэг байна. Нэг дэх нь жишээлбэл АНУ-ын ерөнхийлөгчийг сонгогчдын зөвлөлөөс сонгож байна. Нөгөө хэлбэр нь гэвэл зарим оронд ерөнхийлөгчийг парламентаасаа сонгож байна.

Олон шатат сонгуулийн хувьд гэвэл төлөөлөлийн анхан шатны байгууллагад сонгогдсон гишүүд улмаар дээд шатны байгууллагаа сонгож байна.

Нууцаар саналаа өгөх зарчмын агуулга нь хөндлөнгийн ямарваа нэгэн ажиглалт, хяналтгүйгээр хүсэл зоригоо илэрхийлэх байдлаар хэрэгжиж байна. Энэ нь аливаа сонгууль шударга хэрэгжих гол нөхцөл юм.

ГАДААД УЛСУУДЫН СОНГУУЛИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

Д.Бат-Эрдэнэ

Олон улсын сонгуулийн удирдлагын байгууллагын эрх зүйн байдлын талаар Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос улс, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улс, Бүгд Найрамдах Эстоны улсыг жишээ болгон харьцууллаа. Үүнээс Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Сонгуулийн комиссын эрх зүйн байдлыг сайн туршлага болгон дэлгэрүүллээ. Учир нь, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Кейптаун хотноо 2022 оны 10 дугаар сарын 17-ноос 22-ны өдрүүдэд Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбооны удирдах дээд байгууллага болох Ерөнхий ассамблейн V хурал болсон бөгөөд уг хурлаар Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын

Сонгуулийн комиссын дарга Мосото Моёпиа Холбооны даргаар сонгогдсон*.

Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбооны даргад нэр дэвшүүлэхэд тухайн гишүүн улс орон нь сонгуулийн удирдлагын байгууллагынхаа хараат бус бие даасан байдлыг бэхжүүлсэн, эрх зүйн орчныг бүрдүүлсэн байдал нь суурь шалгуур болдог байна. Иймд дээрх хүчин зүйлийг үндэслэн Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан байдал, бүрэлдэхүүний хараат бус байдлын эрх зүйн орчны талаар дүн шинжилгээ хийсэн юм.

Сонгуулийн байгууллагын бүрэлдэхүүний эрх зүйн байдлын харьцуулалт:

ҮЗҮҮЛЭЛТ	Монгол Улс	Бүгд Найрамдах Солонгос улс	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улс	Бүгд Найрамдах Эстоны улс
Гишүүдийн тоо	9	9	5	7
Тавигдах шаардлага	Төрийн жинхэнэ албан хаагч	Их, дээд сургуульд төрийн удирдлага, улс төрийн шинжлэх ухаан, хууль зүйн шинжлэх ухааны чиглэлээр тав ба түүнээс дээш жил дэд профессор болон түүнээс дээш зэрэгтэй ажилласан хүн;	Өмнөд Африкийн иргэн байх Улс төрийн намын идэвхтэй гишүүн биш байх	Эстони хэлний өндөр мэдлэгтэй байх
Томилгоог санал болгох субъект	Ерөнхийлөгч 2 Улсын дээд шүүх 2 Төрийн байгуулалтын байнгын хороо 5	Ерөнхийлөгч 3 Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч 3 Үндэсний ассамблей 3	Үндсэн хуулийн шүүхийн дарга 2 Хүний эрхийн комисс 2 Жендерийн тэгш байдлын комисс 2 Олон нийтийн хамгаалагч институт 2	1/ Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн томилсон анхан шатны шүүхийн шүүгч; 2/ Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн томилсон давж заалдах шатны шүүхийн шүүгч; 3/ Хууль зүйн канцлераас томилогдсон Хууль зүйн канцлерын зөвлөх; 4/ Ерөнхий аудитороос томилогдсон төрийн аудитын байгууллагын албан тушаалтан; 5/ Улсын ерөнхий прокуророос томилогдсон улсын яллагч; 6/ Рийгикогугийн Ерөнхий нарийн бичгийн даргын томилсон Канцлерийн албан тушаалтан; 7/ Төрийн нарийн бичгийн даргын томилсон Төрийн танхимын албан тушаалтан.
Нэр дэвшүүлэх процесс	Нээлттэй сонголт	Нээлттэй сонголт	Нээлттэй сонголт /Нийт 8-аас доошгүй нэр дэвшигч/	
Даргыг томилгоог санал болгох субъект	Улсын Их Хурлын дарга санал болгосноор УИХ	Гишүүд дотроосоо өөрсдөө томилно	Ерөнхийлөгч комиссын дарга, дэд даргыг комиссын гишүүдээс томилно.	Гишүүд дотроосоо өөрсдөө томилно
Бүрэн эрхийн хугацаа	6	6	7	4
Бие даасан байдал	Хараат бус	Хараат бус	Хараат бус	Хараат бус
Эх сурвалж	Сонгуулийн төв байгууллагын тухай хууль	Election commission act	Electoral commission act 51 of 1996	Riigikogu election act

* Association of World Electoral body. <http://aweb.org/eng/main/contents.do?menuNo=300006> сүүлд 2023.08.01-ний өдөр хандсан

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Сонгуулийн комисс

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс нь 1,221,037 хавтгай дөрвөлжин километр газар нутагтай ба Африк тивийн хамгийн урд хэсэгт байрладаг. Өмнөд Африк Улс газар нутгийн хэмжээгээрээ дэлхийд 24-т жагсдаг ба төрийн гүйцэтгэх, шүүх, хууль тогтоох эрх мэдэлд суурилсан гурван нийслэл хоттой. Тэдгээр хотууд нь Претория (гүйцэтгэх эрх мэдэл), Капе Таун (хууль тогтоох) болон Блумфонтейн (шүүх) юм.¹

Өмнөд Африк Улс нь Их Британийн колони улс байсан бөгөөд 1910 онд улсынхаа холбоог, 1931 онд Засгийн газраа тус тус байгуулсан. Улмаар 1961 оны тавдугаар сарын 31-нд Бүгд Найрамдах Улс болж Их Британиас албан ёсоор салан тусгаарлаж тусгаар улс болсон. Өмнөд Африк 1994 онд ардчилсан улс болсон бөгөөд одоогийн үндсэн хуулиа 1996 онд баталсан.²

Апартейдын Засгийн газрын үед Өмнөд Африк дахь сонгуулийг 1979 оны Сонгуулийн тухай хуулийн дагуу Дотоод хэргийн яам удирддаг байв.³ Ардчилалд шилжих үедээ буюу 1994 оноос сонгуулийн удирдлагыг бие даасан байгууллагад шилжүүлсэн. 1993 оны Бие даасан сонгуулийн хорооны тухай хуулиар 1994 оны 4 дүгээр сарын 26-наас 29-ний хооронд болсон анхны ардчилсан сонгуулийг удирдан явуулах бие даасан сонгуулийн хороо хэмээх түр байгууллагыг байгуулсан. Уг хороо нь арван нэгэн гишүүн, олон улсын хамтын нийгэмлэгийн төлөөлөл бус таван гишүүнийг багтаасан арван зургаан гишүүнээс бүрдэж байв.⁴

Улмаар 1996 оны тавдугаар шинэ Үндсэн хуулиа баталсан бөгөөд энэхүү Үндсэн хуулийн 9 дүгээр бүлэгт Үндсэн хуульд ардчиллыг дэмжих чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудыг тодорхойлон хуульчилсан байна.⁵ Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулийн 9 дүгээр бүлгийн 181 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Бүгд найрамдах улсад Үндсэн хуульд ардчиллыг дараах төрийн байгууллагууд бэхжүүлнэ.

- а. Олон нийтийн хамгаалагч.
- б. Өмнөд Африкийн хүний эрхийн комисс.
- в. Соёл, шашин, хэл шинжлэлийн хамтын нийгэмлэгийн эрхийг дэмжих, хамгаалах комисс.
- г. Жендэрийн тэгш байдлын комисс.
- д. Ерөнхий аудитор
- е. Сонгуулийн хороо." гэж тодорхойлон хуульчлаад улмаар 2 дугаар зүйлд "Эдгээр байгууллага нь хараат бус,



гагцхүү Үндсэн хууль, хуульд захирагдах бөгөөд хараат бусаар бүрэн эрхээ хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа аливаа хөндлөнгийн нөлөөлөлгүйгээр гүйцэтгэх үүрэгтэй.", 3-т "Төрийн бусад байгууллага нь хууль тогтоох болон бусад арга хэмжээгээр эдгээр байгууллагуудын хараат бус, шударга, нэр төр, үр дүнтэй байдлыг хангахад тусалж, хамгаална.", 4-т "Эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд ямар ч хүн, төрийн байгууллага хөндлөнгөөс оролцохыг хориглоно."⁶ ээргээр Үндсэн хуульд ардчиллыг хамгаалж, бэхжүүлэх дээрх институтын эрх зүйн байдал, хараат бус байдлыг баталгааг хуульчилсан байдаг.

Сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан байдлыг шалгах Ардчиллын төлөөх Вестминстерийн сангаас боловсруулсан шалгуур тус бүрээр Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Сонгуулийн комиссын эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж үзье.

Институтын бие даасан байдлыг шалгах шалгуурын хувьд дээр дурдсанаар сонгуулийн удирдлагын байгууллагынхаа эрх зүйн байдлыг Үндсэн хуульд ардчиллыг бэхжүүлэх үндсэн чиг үүрэгтэй, бие даасан, хараат бус институт болохыг Үндсэн хуулиараа тодорхойлон хуульчилсан. Мөн Үндсэн хуулийнхаа 191 дүгээр зүйлд "Сонгуулийн хороо гурваас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна. Гишүүдийн тоо, тэдний бүрэн эрхийн хугацааг үндэсний хууль тогтоомжоор тогтоосон байна." гэж хуульчилсан бөгөөд 1996 онд батлагдсан Сонгуулийн комиссын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Бүгд найрамдах улсын Сонгуулийн хороо нь бие даасан байх бөгөөд зөвхөн Үндсэн хууль, хуульд захирагдана.", 4 дүгээр зүйлд "Комиссын зорилго нь Үндсэн хуульд ардчиллыг

1 The World Factbook. CIA. 16 July 2017.

2 Marais, Lochner, Twala, Chitja (7 May 2020). "Bloemfontein: the rise and fall of South Africa's judicial capital". African Geographical Review. Informa UK Limited. 40 (1): 49–62.

3 Padmanabhan, Vijay (2002). "Democracy's baby blocks: South Africa's electoral commissions". New York University Law Review. 77: 1157.

4 "Independent Electoral Commission Act, No. 150 of 1993". SAFLII. 20 September 2015.

5 <https://www.gov.za/documents/constitution-republic-south-africa-1996-chapter-9-state-institutions-supporting#191>

6 <https://www.gov.za/documents/constitution-republic-south-africa-1996-chapter-9-state-institutions-supporting#181>



бэхжүүлэх, сонгуулийн ардчилсан үйл явцыг дэмжих явдал юм.” гэж тодорхойлжээ.

Сонгуулийн комиссын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1-т зааснаар Комисс таван гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн нэг нь уг хуульд заасны дагуу Ерөнхийлөгчөөс санал болгосон шүүгч байна. Харин бусад 4 нэр дэвшигчийг мөн зүйлийн 3-т зааснаар Үндсэн хуулийн шүүх, Хүний эрхийн үндэсний комисс, Жендэрийн эрх тэгш байдлын хороо болон Олон нийтийн хамгаалагч байгууллагаас тус тус нэр дэвшүүлнэ.⁷ Олон нийтийн хамгаалагч байгууллага нь Үндсэн хуулийн 181 дүгээр зүйлийн дагуу байгуулагдсан, Үндсэн хуульт ардчиллыг дэмжих, бэхжүүлэх чиг үүрэгтэй бие даасан байгууллага юм.⁸ Уг байгууллага нь төрийн захиргааны хяналтын дээд байгууллага бөгөөд төрийн аливаа үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн талаарх хууль зөрчсөн үйлдлийг шалгах, мэдээлэх, зөрчлийг арилгах арга хэмжээ авах эрхтэй байдаг.

Эндээс үзвэл Сонгуулийн комиссын таван гишүүнийг хараат бус бие даасан статустай байгууллагаас санал болгож, нэр дэвшүүлэх эрхийг хуульчилсан байна.

Сонгуулийн комиссын хуулийн 7 дугаар зүйлийн 1-т зааснаар Комиссын гишүүний бүрэн эрхийн хугацаа 7 жил байх бөгөөд энэ хугацаа нь Үндсэн хуулийн 4 дүгээр бүлгийн 49 дүгээр зүйлийн 1-т заасан парламентын бүрэн эрхийн хугацаа 5 жил байна гэж заасантай уялдуулан сонгуулийн удирдлагын байгууллагынхаа бүрэлдэхүүний бүрэн эрхийг хугацааг тодорхойлон хуульчилсан байна.

Гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох үндэслэл болон үйл ажиллагааны баталгааг Сонгуулийн комиссын хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт тодорхойлон хуульчилсан байна. Тухайлбал, хууль тогтоомж зөрчсөн болох нь тогтоогдсон, эсхүл хөдөлмөрийн чадвараа алдсан үндэслэлээр Ерөнхийлөгч чөлөөлнө.

Сонгуулийн комиссын тухай хуулийн 12 дугаар зүйлд

Комиссын Ажлын албаны эрх зүйн байдал, холбогдох харилцааг хуульчилсан бөгөөд уг зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар Ажлын албаны даргыг Хороо томилж, чөлөөлөхөөр хуульчилсан. Харин Ажлын албаны дарга нь захиргааны бусад албан хаагчдыг томилохдоо Хороонд танилцуулж, зөвшилцсөний үндсэн дээр томилох эрхийг хуульчилжээ. Эндээс дүгнэж үзвэл институтын бие даасан байдлыг шалгах шалгуур бүрт холбогдох эрх зүйн орчин, зохицуулалтууд нийцэж байна гэж үзэх үндэслэлтэй. Харин гишүүний үйл ажиллагааны баталгааны хувьд Сонгуулийн комиссын хуулийн 9 дүгээр зүйлд бүрэн эрх, хориглох үйл ажиллагааг, 10 дугаар зүйлд ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, зохицуулах эрх зүйн орчныг хуульчилсан байна. Мөн Комиссын дарга, нарийн бичгийн даргыг Ерөнхийлөгч комиссын гишүүдээс томилохоор хуульчилсан.

Шийдвэр гаргах үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах эрх зүйн орчныг дээр дурдсанаар Сонгуулийн комиссын тухай хуулийн 3 дугаар бүлэгт гагцхүү Үндсэн хууль болон бусад хуулийн дагуу үйл ажиллагаагаа хараат бусаар явуулахыг хуульчилсан. Харин төсвийн хувьд мөн хуулийн 13 дугаар зүйлд зааснаар Комисс үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай, хүрэлцэхүйц хэмжээний төсвийг парламент батлах бөгөөд уг баталсан төсвөөс гадна Комисс өөрөө гадаадын болон олон улсын байгууллагаас бүрдүүлсэн бусад санхүүгийн эх үүсвэрийг шууд захиран зарцуулах эрхтэй байна.

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Сонгуулийн комисс нь Үндсэн хуульт ардчиллыг бэхжүүлэх чиг үүрэг бүхий Үндсэн хуулийн, бие даасан байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах эрх зүйн орчныг Үндсэн хууль, Сонгуулийн комиссын тухай хуулиараа бүрдүүлсэн байна. Мөн бүрэлдэхүүнийг Үндсэн хуульт ардчиллыг бэхжүүлэх чиг үүрэг бүхий бусад бие даасан институтуудээс санал болгож, мөн бүрэн эрхийн хугацааг парламентын бүрэн эрхийн хугацаанаас урт байхаар буюу 7 жилийн хугацаатай байхаар хуульчилсан нь хараат бус байдлыг бэхжүүлэх үндсэн шаардлагад нийцсэн, сайн туршлага болж байна.



7 Electoral Commission act South Africa

8 <https://www.pprotect.org/?q=content/our-mandate>

СОНГУУЛИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ТАЛААРХ СУДАЛГАА БОЛОН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаа нь сонгуулийн үйл явцад итгэх сонгогчдын итгэл үнэмшил болоод сонгуулийн хууль ёсны байдалтай салшгүй холбоотой байдаг. Харин сонгуулийг хууль ёсны бөгөөд ардчилсан сонгуулийн зарчимд нийцүүлэн зохион байгуулахад хараат бус, бие даасан, мэргэжлийн, ил тод үйл ажиллагаа явуулах үндсэн үүрэг бүхий институц бол сонгуулийн удирдлагын байгууллага юм. Иймд уг институтийн бие даасан, хараат бус байдлыг хөгжүүлэх, түүний загварыг судалж, тодорхойлох нь дэлхийн бусад улс орны сонгуулийн удирдлагын байгууллагууд, олон улсын байгууллагууд болон эрдэмтэн судлаачдын судалгааны чухал сэдэв болж байна.

Бие даасан байдлыг илтгэх дээрх үндсэн үзүүлэлтүүд болон түүнийг бүрэлдүүлж буй бусад хүчин зүйлүүдийг багцлан нэгдүгээрт: институтийн хувьд, хоёрдугаарт: шийдвэр гаргах үйл ажиллагааны хувьд, гуравдугаарт: санхүү буюу төсвийн хувьд бие даасан байдал гэсэн гурван үндсэн хэсэгт хувааж¹, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт болгон үнэлэх үнэлгээний хүснэгтийг 2020 онд Ардчиллын төлөөх Вестминстерийн сангаас боловсруулсныг танилцуулж байна.

БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ²

№	Шалгуур үзүүлэлт	Жишээ	Хариултын эх сурвалжууд	Бие даасан байдлыг үнэлэхэд гол ач холбогдол бүхий асуултууд
 А. ИНСТИТУЦЫН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ШАЛГАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД				
1	Сонгуулийн удирдлагын байгууллагын эрх зүйн байдал	- Үндсэн хууль эсхүл хуулиар байгуулагдаж, хамгаалагддаг. - Хууль өөрчлөхөд дийлэнх олонхын санал шаардлагатай болдог	- Үндсэн хуулийн зохицуулалтууд - Хуулийн зохицуулалтууд - Сонгуулийн зохицуулалтууд	- Сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан байдлыг Үндсэн хуульд тусгасан эсэх - Сонгуулийн удирдлагын байгууллагатай холбоотой зохицуулалтууд тодорхой, хоёрдмол утгагүй эсэх - Сонгуулийн удирдлагын байгууллагын бие даасан байдлыг хангах эрх зүйн орчин бүрдсэн эсэх - Үндсэн хууль болон холбогдох бусад хуулийн өөрчлөлтүүд нь бие даасан байдалд нөлөөлсөн эсэх
2	Гишүүд болон Ажлын албаны албан хаагчдын томилгооны ил тод байдал	- Нээлттэй зарлах - Нээлттэй сонсгол - Томилоог санал болгох байгууллага - Сөрөг хүчний намууд болон иргэний нийгмийн байгууллагын санал	- Үндсэн хуулийн болон бусад хуулийн зохицуулалтууд - Сонин /радио/ бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлах - Олон нийтэд ил тод сонсгол хийх	- Ажлын байрыг боломжит хугацаанд нийтэд зарлаж байгаа эсэх - Бүх нэр дэвшигчид ижил нөхцөлтэй сонгон шалгаруулалтын процесст оролцож, уг үйл ажиллагаа нь нээлттэй явагддаг эсэх - Томилох үйл ажиллагаанд болон нэр дэвшигчийн мэргэшлийн байдалд үндэслэл бүхий эргэлзээ үүссэн үед томилгоотой холбогдуулан гомдол гаргах боломжтой эсэх, - Сонгуулийн хорооны гишүүнээр сонгогдох болон Ажлын албанд албан хаагчаар ажиллахад хязгаарлах шалгуур үзүүлэлт байдаг эсэх - Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага солигдсоны дараа сонгуулийн удирдлагын байгууллагын бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байсан эсэх

1 WFD, "Understanding and Assessing Electoral Commission Independence: a New Framework", London 2020, P. 5.

2 WFD, Westminster foundation for Democracy "Understanding and Assessing Electoral Commission Independence: a New Framework", London 2020, P. 15.

3 Бүрэн эрхийн баталгаа	- Сонгуулийн удирдлагын байгууллагын гишүүдийн бүрэн эрх - Бүрэн эрхийн хугацаа	- Эрх зүйн орчин - Парламентын эсхүл Ерөнхийлөгчийн эрх барих хугацаанаас гишүүний бүрэн эрхийн хугацаа урт байх - Огцруулах, бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох нөхцөл	- Гишүүний бүрэн эрхийн хугацаа - Бүрэн эрхийн хугацаа нь парламентын болон Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанаас илүү эсэх - Бүрэн эрхийн хугацаа нь ижил шатны үндэсний хэмжээний сонгуулийг нэгээс илүү удаа зохион байгуулах боломжтой эсэх - Бүрэлдэхүүнийг дахин томилох боломжтой эсэх, тийм бол ямар үндэслэлээр? - Бүрэлдэхүүнийг хугацаанаас нь өмнө огцруулах үндэслэл бий эсэх хэрэв тийм бол хэн огцруулах эрхтэй, үүнийг урвуулан ашиглахаас сэргийлэх эрх зүйн орчин бүрдсэн эсэх,
4 Гишүүдийн субъектив аюулгүй байдал	- Гишүүдийг заналхийлэл, халдлагаас хамгаалах - Гишүүдийн өөрсдийн аюулгүй байдлын хангах чадамж	- Гишүүн түүний эд хөрөнгө болон бусад албан хаагчдад халдсан халдлагын нотлох баримт - Сонгуулийн ажиглалтын тайлан	- Сонгуулийн удирдлагын байгууллага нь өөрийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах эрхтэй эсэх, эсхүл үүнийг төрөөс хангадаг эсэх - Практикт гишүүдийг айлган сүрдүүлэх, тэр дундаа бие махбодид нь халдах, заналхийлэх мөн нийгмийн сүлжээгээр үзэн ядах агуулга бүхий мэдээллийг түгээх оролдлогууд гарч байсан эсэх
5 Албан хаагчийг томилох, чөлөөлөх эрх	- Ажлын албаны албан хаагчийг томилох, чөлөөлөх журам - Бусад шатны сонгуулийн байгууллагын албан хаагчийг томилох, чөлөөлөх журам - Санал авах байранд ажиллах албан хаагчийг томилох, чөлөөлөх журам	- Хууль тогтоомж - Томилогдон ажиллах хүсэлтийн бүртгэл	- Сонгуулийн удирдлагын байгууллага буюу хуралдаанаар ажлын албаны албан хаагч эсхүл гүйцэтгэх удирдлагыг томилох эрхтэй эсэх - Сонгуулийн удирдлагын байгууллага гүйцэтгэх удирдлагыг томилдоггүй бол түүнийг хэн, хэрхэн түүнийг томилох вэ? Томилох үйл ажиллагаа ил тод, нээлттэй явагдах эрх зүйн орчин бүрдсэн эсэх, - Сонгуулийн удирдлагын байгууллага бүхэлдээ хүний нөөцийн хувьд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тогтолцоог бүрдсэн эсэх



Б.ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫГ ШАЛГАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

6 Шийдвэр гаргах хараат бус байдал	- Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийн талаарх мэдээлэл - Үйл ажиллагаа болон санхүүгийн нөхцөл байдлын талаар жил бүр тайлагнахыг шаардах	- Холбогдох хууль тогтоомжууд - Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээ - Холбогдох төрийн байгууллагын албан ёсны мэдээ, баримтууд	- Сонгуулийн удирдлагын байгууллага нь сонгууль зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан зохицуулалт бүхий журмын батлах эрх олгогдсон эсэх - Сонгуулийн удирдлагын байгууллагын гаргасан шийдвэрийг нийтээр дагаж мөрддөг эсэх, - Үйл ажиллагааны тайланг парламент болон холбогдох сайдад танилцуулах үүрэг хүлээдэг эсэх - Олон нийтэд тайлантай танилцах боломж нээлттэй эсэх - Тайланг нээлттэй болгоход парламент эсхүл холбогдох сайдын зөвшөөрлийг урьдчилж авах шаардлагатай эсэх
------------------------------------	--	--	--

7	Хууль тогтоомжийг өөрчлөх, боловсронгуй болгох санал гаргах эрх	- Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах санал гаргах эрх - Сонгууль зохион байгуулахтай холбоотой журам холбогдох зохицуулалтын хүрээнд нэмэлт, өөрчлөлт хийх эрх	- Холбогдох хууль тогтоомж	- Сонгуулийн удирдлагын байгууллага практикт олон улсын ажиглагчдын зөвлөмж болон өмнөх сонгуулийн туршлагаас үүдэн сонгуулийн дүрэм, журам болон процессыг өөрчлөх санал гаргаж байсан эсэх - Дээрх саналууд нь сонгуулийн хууль тогтоомжид тусгагдаж байсан эсэх
8	Сонгуулийн дүнг зарлах, мөн санал хураалтыг "хүчин төгөлдөр" эсхүл "хүчингүйд тооцох" эрх	- Сонгуулийн дүнг аль байгууллага зарлах эрхтэй вэ? - Энэ эрх зөвхөн сонгуулийн удирдлагын байгууллагад хадгалагдах уу?	- Холбогдох хууль тогтоомж	- Сонгуулийн удирдлагын байгууллага урьдчилсан болон сонгуулийн албан ёсны үр дүнг дангаараа зарлах эрхтэй эсэх - Бусад байгууллага сонгуулийн үр дүнг зарлахад саад хийх эсхүл урьдчилан сонгуулийн дүнг мэдээлэх, зарлах эрхтэй эсэх
9	Давж заалдах процесс	- Сонгуулийн комиссын шийдвэрийг давж заалдаж болох уу? - Давж заалдах процесс гэж юу вэ? - Хэн, хаана хандаж давж заалдах эрхтэй вэ?	- Хууль тогтоомж - Хэвлэл мэдээллийн мэдээ - Шүүхийн шийдвэрийн судалгаа	- Сонгуулийн удирдлагын байгууллагын гаргасан сонгуулийн албан ёсны дүн гаргасан шийдвэрүүдийг давж заалдаж болох эсэх - Давж заалдах гомдлыг хаана гаргаж байгаа - Практикт улс төрийн нам, нэр дэвшигч болон иргэний нийгмийн байгууллага шийдвэрт гомдол гаргах боломжтой эсэх мөн шүүх холбогдох байгууллага гомдлыг шударгаар хянан шийдвэрлэж буй эсэх



В. САНХҮҮ БОЛОН ТӨСВИЙН ХУВД БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ШАЛГАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

10	Төсвийн хараат бус байдал	- Өөрийн төсвийг хараат бусаар төлөвлөх эрх - Нэмэлт санхүүжилт хүсэх эрх - Сонгууль зохион байгуулах зардлын ангилал тусгайлсан эрх зүйн зохицуулалттай байдал - Цаг тухайд нь төсвийг олгох боломж	- Холбогдох хууль тогтоомж - Төсвийн хэмжээ	- Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд шаардагдах хэмжээгээр өөрийн төсвийг төсөвлөж, батлуулах боломжтой эсэх - Парламент дахь төсвийн асуудал хариуцсан хороо сонгуулийн төсөв болон гүйцэтгэлд хийсэн төрийн аудитын дүгнэлтийг хэлэлцэхэд сонгуулийн байгууллагын төлөөллийг байлцуулдаг эсэх - Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд шаардагдах худалдан авалт, ажил үйлчилгээг сонгоход ердийн тендерийн журмыг дагаж мөрдөх ёстой эсэх
11	Олон улсын байгууллагаас санхүүжилт авах эрх	- Дотоодын төрийн бус байгууллагаас буцалтгүй тусламж авах эрх - Олон улсын донор байгууллагаас буцалтгүй тусламж авах эрх	- Холбогдох хууль тогтоомж	- Сонгуулийн удирдлагын байгууллага нь Засгийн газраас бусад дотоодын эх үүсвэрээс (төрийн бус болон хувийн) санхүүжилт авч болох эсэх - Сонгуулийн удирдлагын байгууллага бие даан донор улс болон олон улсын байгууллагаас санхүүжилт хүсэх боломжтой эсэх - Практикт сонгуулийн удирдлагын байгууллага нь гадаад санхүүжилтийн эх үүсвэр хайх, авахад улс төрийн болоод бусад бэрхшээлтэй нүүр тулгардаг эсэх

---00000---



СОНГУУЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ БА СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Д.Бат-Эрдэнэ

Бид өдөр бүр сонголттой тулгарч байдаг эдгээр олон сонголтаас хүний улс төрийн эрхийн сонголт хийх чөлөөт боломж нь гагцхүү Ардчилсан засаглалын хэлбэрт байдаг. Энэ ч утгаараа сонгууль нь Ардчилсан засаглалын хэлбэрийн үнэт зүйл болдог. 1990 онд Монгол Улсад анх удаа ардчилсан сонгуулийн шинэ үе эхэлж иргэний сонгох сонгогдох эрхийн эрх зүйн орчныг баталгаажуулж, чөлөөт ардчилсан сонгууль жинхэнэ утгаараа хэрэгжиж эхэлсэн юм.

Шинжлэх ухааны Академийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгээс хийсэн “Монгол Улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо” судалгаанд манай орон сонгуулийн тогтолцоо үүсч төлөвшсөн түүхэн үйл явцыг тодорхой үе шатуудад хуваан ангилж судлахдаа 1990 оны ардчилсан сонгуулийг сонгуулийн тогтолцооны цогц шинэчлэлийн гарааны үе хэмээн онцолсон байдаг.

1992 оноос 2004 онд явагдсан Улсын Их Хурлын 4 удаагийн сонгуулийг 1992 онд баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар, 2008 онд явагдсан Улсын Их Хурлын сонгуулийг 2005 онд баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар, 2012 онд явагдсан Улсын Их Хурлын сонгуулийг 2011 онд баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар, 2016 онд явагдсан Улсын Их Хурлын сонгуулийг 2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулиар, 2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг 2019 онд баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар тус тус зохион байгуулж явуулсан. Харин Монгол Улсын Их Хурлын 2024 оны буюу энэ удаагийн ээлжит сонгууль нь Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу 2019 онд батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж анх удаа Улсын Их Хурлын 126 гишүүнийг, сонгуулийн хосолсон тогтолцоогоор зохион байгуулж явуулсан.

Монгол Улсын Их Хурлын нийт 9 удаагийн ээлжит сонгуулийг 5 удаагийн шинэчилсэн найруулга, эдгээр хуулиудад оруулсан нийт 20 удаагийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу зохион байгуулжээ.

Сонгуулийн тогтолцооны төгс хувилбар гэж байхгүй бөгөөд тухайн улс орны нийгэм, улс төр, эдийн засаг, сонгогчийн тоо, газар нутгийн хэмжээ, байршил гэх зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан улс орон бүр өөрийн орны онцлогт нийцсэн сонгуулийн тогтолцоог хэрэглэж, шаардлагатай гэж үзсэн нэмэлт өөрчлөлт хийж боловсронгуй болгож байна. Сонгуулийн мажоритар болон пропорциональ тогтолцоо нь өөрийн давуу болон сул талуудтай бөгөөд дэлхийн улс орнууд сонгуулийн тогтолцооны давуу талыг аль болох хадгалж авч үлдсэн, сул талыг багасгасан боломжит хувилбараар сонгуулиа зохион байгуулахыг эрмэлзэж байна. Энэ ардчилсан нийгмийн үнэт зүйлийн

Монгол Улсын Их Хурлын нийт



9

удаагийн ээлжит
сонгуулийг 5 удаагийн
шинэчилсэн найруулга,



20

удаагийн
нэмэлт,
өөрчлөлтийн
дагуу зохион
байгуулжээ.

нэг болох ардчилсан сонгуулийн үндсэн зарчмыг бодитоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой байдаг.

2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулах, Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох үндсэн тогтолцоо, сонгох журмыг хуульчилсан нь сонгуулийн эрх зүйн тогтвортой байдлыг хангах Үндсэн хуулийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-т "Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс өмнөх нэг жилийн хугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно." гэж тус тус хуульчилсан нь сонгуулийн хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлсэн.

Эрх зүйн орчны тодорхой, тогтвортой байдал нь сонгогчод мэдээлэл өгөх, сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг тогтвортой, өргөн хүрээнд зохион байгуулах үндсэн нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой байдаг.


Нөгөө талаар сонгуулийн удирдлагын байгууллага нь гагцхүү сонгуулийг хуулийн дагуу зохион байгуулахаас гадна уг үйл ажиллагаагаа ил тод мэдээлэх, сонгогчдыг байнга мэдээллээр хангах, сонгогчдод сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг өргөн хүрээнд, тогтмол зохион байгуулах шаардлагатай байдаг. Энэ нь ил тод байдлыг нэмэгдүүлэх бас нэгэн чухал шалгуур болдог.

Иймд сонгуулийн удирдлагын байгууллага нь сонгууль зохион байгуулах үндсэн үйл ажиллагаанаас гадна сонгуулийн хууль тогтоомж, сонгуулийн агуулга, мөн чанарын талаарх мэдээлэл, сургалт буюу сонгогчдод сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг өргөн хүрээнд, тогтмол явуулж чадаж байгаа эсэх нь бие даасан, хараат бус байдлын шалгуур болж байдаг. Энэхүү шалгуур нь харьцангуй институтын чадавхтай холбоотой юм. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д зааснаар Сонгуулийн ерөнхий хороо нь ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчилсан боловч сонгогчдод тэр дундаа залуу сонгогчдод сонгуулийн боловсрол олгох, сонгуулийн үйл явцын талаарх үнэн зөв мэдээлэл олгох үйл ажиллагааг тогтмол, өргөн хүрээнд явуулах шаардлагатай.

“

Эрх зүйн орчны тодорхой, тогтвортой байдал нь сонгогчод мэдээлэл өгөх, сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг тогтвортой, өргөн хүрээнд зохион байгуулах үндсэн нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой байдаг.

Нөгөө талаар сонгуулийн удирдлагын байгууллага нь гагцхүү сонгуулийг хуулийн дагуу зохион байгуулахаас гадна уг үйл ажиллагаагаа ил тод мэдээлэх, сонгогчдыг байнга мэдээллээр хангах, сонгогчдод сонгуулийн боловсрол олгох үйл ажиллагааг өргөн хүрээнд, тогтмол зохион байгуулах шаардлагатай байдаг. Энэ нь ил тод байдлыг нэмэгдүүлэх бас нэгэн чухал шалгуур болдог.



СОНГОГЧДОД МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ АРГА ЗАМ, ИДЭВХЖҮҮЛЭЛТ

СОНГОГЧ ГЭЖ ХЭН БЭ



- Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг;
- Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн, тухайн засаг захиргааны нэгжид байнга оршин суугчаар бүртгэгдэн оршин сууж байгаа сонгуулийн эрх бүхий иргэнийг;



МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХ

Сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр сонгох эрхтэй.

25 насанд хүрсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхтэй.

18 нас хүрсэн, тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө шилжин суурьшиж, байнга оршин суугчаар бүртгүүлсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны Хурлын Төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй.

Сонгогч саналаа нууцаар гаргах ба хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж саналаа өгөх боломжоор хангагдсан байна.

Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй.

Иргэний сонгох, сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлах, сонгогчоос саналаа чөлөөтэй өгөхөд нь хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулахыг хориглоно.



МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдал нь иргэний эрхийг хангах чухал хүчин зүйл болно.

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны гол онцлог нь хэн, хэзээ, юуг, хэрхэн хийх дараалал, цаг хугацааг нарийвчлан тогтоосон хуулийн зохицуулалттай байдаг бөгөөд сонгууль зохион байгуулах бүхий л үйл ажиллагаа нь иргэд болон сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчид, дотоодын болон гадаадын олон улсын байгууллага, ажиглагчдын хяналт, ажиглалт дор байдаг тул үйл ажиллагааны ил тод байдлыг хангах нь сонгуулийг амжилттай зохион байгуулах хамгийн чухал хүчин зүйл болдог.

Нөгөө талаар сонгууль бол бүх нийтийн байх ёстой тул сонгогчдын идэвхи оролцоог нэмэгдүүлэх чиглэлд анхаарал хандуулж, өргөн хүрээнд шаардлагатай арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлж байх нь сонгуулийн байгууллагуудын үүрэг болдог. Сонгуулийн байгууллага энэхүү үүргээ хэрэгжүүлэхдээ мэдээллийн хүртээмжтэй бөгөөд цаг үеэ олсон байдалд анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байдаг.

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны талаарх бүхий л мэдээллийг ил тод, хүртээмжтэй хүргэх нь дээр дурдснаар сонгуулийг амжилттай зохион байгуулахад чухал ач холбогдолтой юм.

Нээлттэй ил тод байдал бол шударга сонгуулийн үндэс суурь юм.

Жишээ: Санал хураалтын дүнг шууд дамжуулан үзүүлэх, ирцийн мэдээллийг цахимаар шууд дамжуулан үзүүлэх, санал авах байруудын дотоод зохион байгуулалт үйл ажиллагааны ил тод байдлыг харуулах хяналтын камерын систем гэх мэт.



СОНГУУЛИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ

Сонгуулийн ямар тогтолцоог сонгож байна вэ гэдгээс илүүтэй сонгуулийг өөрийн орны онцлогт нийцүүлэн хэрхэн яаж зохион байгуулж байгаа нь Ардчилсан сонгуулийн үндсэн зарчмыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Сонгуулийн зарчим нь Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад үндэслэнэ.

Сонгууль бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгогч бүр оролцох эрхтэй.

Сонгуулийн үндсэн зарчим: Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа нууцаар гаргана.

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд баримтлах зарчим: Сонгууль зохион байгуулах төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний албан тушаалтан, нэр дэвшигч, сонгуульд оролцогч нам, эвсэл, бусад байгууллага, түүний албан тушаалтан сонгууль зохион байгуулах, түүнд оролцохдоо дараах зарчмыг баримтална:

- 1.хууль дээдлэх;
- 2.ил тод байдлыг хангах;
- 3.шударга ёсыг сахих.

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчим нь сонгогч саналаа нууцаар гаргахад хамаарахгүй.



АРДЧИЛСАН ЧӨЛӨӨТ, ШУДАРГА СОНГУУЛЬ СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Сонгогчдын идэвхи оролцоог сайжруулах, сонгуулийн болон сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх ач холбогдлыг сонгогчдод тайлбарлан таниулах, сонгууль зохион байгуулалтын үйл ажиллагааны талаар суурь мэдээ, мэдээллийг хүргэх зэрэг сонгогчдын боловсролд зориулсан үйл ажиллагааг сонгуулийн болон сонгуулийн бус жилд өргөн цар хүрээтэйгээр, тогтмол, хүртээмжтэй хэлбэрээр явуулах шаардлагатай байдаг.





МЭДЭЭЛЛИЙН ТӨРЛҮҮД

- Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаа
- Сонгогчдын нэрийн жагсаалт
- Сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, танилцуулга
- Санал өгөхөд анхаарах зүйлс
- Санал авах байрын хаяг, байршил
- Хууль бус сурталчилгаа
- Хуурамч мэдээллийг нягтлах, түүний ач холбогдол

Мэдээллийн технологийн хөгжлийг дагаад хуурамч, хууль бус мэдээ, мэдээлэл нь хувь хүний эрх ашгаас эхлээд улс орны хэмжээнд нөлөөлөхүйц хүчтэй болж байгаа нь чөлөөт сонголтод хөндлөнгөөс нөлөөлөх эрсдэлийг дагуулж байна.

Мэдээллийн эх сурвалжийг нягталж, аливаа хуурамч мэдээ, мэдээлэлд автахгүйгээр итгэл үнэмшлээрээ чөлөөт сонголтоо хийх боломж, нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

Иймд сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд техник, технологийн хөгжлийн шийдлийг нэвтрүүлэхтэй зэрэгцэн сонгогчдын идэвх, оролцоог сайжруулах, сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхийн ач холбогдлыг сонгогчдод тайлбарлан таниулах, сонгууль зохион байгуулалтын үйл ажиллагааны талаар суурь мэдээ, мэдээллийг хүргэх зэрэг сонгогчдын боловсролд зориулсан үйл ажиллагааг сонгуулийн болон сонгуулийн бус жилд өргөн цар хүрээтэйгээр, тогтмол, хүртээмжтэй хэлбэрээр явуулах чиглэлд онцгой анхаарал хандуулах нь зөв.

Мэдээлэл хүргэх арга зам



Телевиз



Интернэт



Радио



Тээврийн хэрэгсэл



Гудамж талбайн самбар



Сонин



Хэвлэмэл материалууд



Сонгогчийн боловсролын сургалт–тогтмол, өргөн хүрээнд



ИДЭВХЖҮҮЛЭЛТ

Идэвхжүүлэлт гэж юу вэ?

Идэвхжүүлэлт нь байгууллагын имижийг бүрдүүлэх, бүтээгдэхүүн ба брэндийг хоногшуулах, борлуулалтыг удирдан чиглүүлэх зорилгоор хийгдэх маркетингийн харилцаа юм.

Төрийн байгууллагын хувьд хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ онцлогоос хамаарч тодорхой төрлийн бүтээгдэхүүн/үйлчилгээ буюу үйл ажиллагаандаа маркетингийн идэвхижүүлэлтийг ашиглах боломжтой. Төрийн байгууллагын маркетингийн чиглэлээр тусгайлан хичээлийн хөтөлбөрийг ч явуулдаг болсон.

Сонгуулийн ерөнхий хорооны хувьд өмнө дурдсанчлан Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д заасны дагуу сонгуулийн хууль тогтоомжийг иргэд сонгогчдод тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролд зориулсан сургалт, хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулах, сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны талаарх иргэдийн тогтмол мэдээ, мэдээллээр хангах зэрэг чиг үүргийг хуулиар хүлээн хэрэгжүүлж байгаа нь сонгуулийн үнэ цэн, ач холбогдлыг ухамсарлан ойлгож, сонгуульд идэвхитэй, хариуцлагатай оролцох суурь болдог. Иймд өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн идэвхижүүлэлтийн арга хэлбэрийг ашиглах боломжтой юм.

Маркетингийн харилцаа нь зар сурталчилгаа, борлуулалтын урамшуулал, олон нийтийн харилцаа, биечилсэн борлуулалт болон шууд маркетинг хэлбэрээр явагдах ба эдгээрийг идэвхжүүлэлтийн иж бүрдэл гэж нэрлэдэг.

Идэвхжүүлэлтийн үе шатууд

- 1.Нөхцөл байдлын судалгаа хийх
- 2.Идэвхжүүлэлтийн зорилго, зорилтуудыг тодорхойлох
- 3.Идэвхжүүлэлтийн арга хэрэгсэл сонгох
- 4.Хэрэглэгчдэд хүргэх илгээлтийг боловсруулах
- 5.Мэдээллийн сувгийг сонгох
- 6.Төсөв боловсруулах
- 7.Үр дүнг хянаж шинжлэх

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ЭРГЭН ТОЙРОНД...

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн ээлжит сонгуулийг Монгол Улсын Үндсэн хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр амжилттай зохион байгууллаа.


8031 МАНДАТЫН ТӨЛӨӨ 17278 НЭР ДЭВШИГЧ ӨРСӨЛДӨВ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн 2395 тойрогт 8031 мандатын төлөө 10 нам, 1 эвслээс 17010, бие даан нэр дэвшигч 268, нийт 17278 нэр дэвшигч өрсөлдсөн юм. Нэр дэвшигчдийн 5582 буюу 32.3 хувь нь эмэгтэй, 11696 буюу 67.7 хувь нь эрэгтэй бөгөөд насны хувьд 31-50 насныхан зонхилж байв. Нэр дэвшигчдийн 5522 менежер, 10878 шадар туслах, 82917 ухуулагч сонгуулийн сурталчилгаанд ажилласан бөгөөд 17042 тээврийн хэрэгсэл ашиглажээ.

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ДҮН, 2024



ИТХ-ЫН НИЙТ ТӨЛӨӨЛӨГЧ



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо
Өгөгдлийн дүрслэлийг Тунгаахуй өгөгдлийн урланд бүтээв.

СОНГОГЧДЫН 53.2 ХУВЬ НЬ САНАЛАА ӨГЛӨӨ

Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар 19,496 сонгогч санал өгөх хүсэлт гаргасан бөгөөд 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр тэдний 95.49 хувь нь саналаа өгөв.

Энэ удаагийн сонгуульд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн 2,107,296 үндсэн сонгогчоос 1,120,767 буюу 53.2 хувь нь оролцлоо. Орон нутгийн Хурлын сонгуульд сонгогч өөрийн байнга оршин суугаа хаягийн дагуу оролцдог, сонгогчийн шилжилт хийгддэггүй гэдгээрээ онцлогтой.


Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 78 дугаар зүйлд зааснаар хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийн саналын тоо тэнцсэн бол адил санал авсан нэр дэвшигчдийн дунд нэмэлт санал хураалт явуулдаг. Нэмэлт санал хураалтад эхний санал хураалтад оролцоогүй, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогч оролцож, саналаа өгдөг. Улмаар нэмэлт санал хураалтад оролцсон сонгогчдын ирц, саналын тоог эхний санал хураалтад оролцсон сонгогчдын ирц, саналын тоон дээр нэмж тооцон тухайн тойргийн санал хураалтын дүнг гаргахаар хуульчилсан байдаг.

Тиймээс саналын тоо нь тэнцсэн нийт 19 аймгийн 75 сумын 87 хэсэгт нэмэлт санал хураалт явуулахаар болсон бөгөөд аравдугаар сарын 13-ны өдөр 19 аймгийн 70 сумын 79 хэсэгт, 19-ний өдөр 7 аймгийн 8 сумын 12 хэсэгт нэмэлт санал хураалт явуулснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал хураалт амжилтай явагдаж дууслаа.

БАЙНГЫН БУС АЖИЛЛАГААТАЙ СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГАД 25621 АЛБАН ХААГЧ АЖИЛЛАВ

Сонгуулийн ерөнхий хороо Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг мэргэшсэн түвшинд зохион байгуулж, оролцогч талууд, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагад бүрэн нээлттэй байх бодлогыг баримтлан сонгуулийн хороодыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан юм. Энэ удаагийн сонгуулиар аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, хэсгийн хорооны 20601 гишүүн, мэдээллийн технологийн 169 багт 2683 даамал, иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн 2337 ажилтан, нийт 25621 төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагч болон

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ: СОНГОГЧДЫН ИРЦ





цагдаа, онцгой байдлын алба хаагчид хуулиар хүлээсэн чиг үүргээ нэр төртэй биелүүлж, иргэдийн сонгох, сонгогдох эрхийг ханган ажилласан юм.

СОНГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙГ БҮРЭН АШИГЛАЛАА

Сонгуулийн ерөнхий хороо, сонгуулийн хороод зохион байгуулалтын үйл ажиллагааг оролцогч талуудад хүндрэлгүй, төрд байгаа мэдээллийг дахин шаардахгүйгээр сонгуулийн цахим системийг бүрэн ашиглахаар зорьж ажилласан нь үр дүнгээ өглөө. Тодруулбал, Сонгуулийн байгууллагын ажлын бүтээмж, мэдээлэл солилцооны үр ашгийг нэмэгдүүлэх, ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор "Сонгуулийн мэдээллийн цахим систем e-electoin.mn"-г хөгжүүлж, Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар бүрэн ашиглалаа. Энэхүү цахим системээр байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах төрийн албан хаагчдыг бүртгэж, сургалтад хамруулан, нөөц бүрдүүлж, албан хаагчдыг томилон баталгаажуулж ажиллалаа. Мөн сонгуульд нэр дэвшигч, түүний менежер, шадар туслагч, ухуулагч, нэр дэвшигч болон нам эвслийн ажиглагчид цахим системд бүртгүүлж, чиг үүргээ хэрэгжүүлэх эрхээ цахимаар авснаар цаг хугацаа, цаасны асар их хэмнэлтийг бий болгож, төрд байгаа мэдээллийг иргэдээс дахин нэхэлгүй баталгаажуулан ажилласан нь сонгуульд оролцогч болон зохион байгуулагч талд хүндрэл учруулахгүй чухал ач холбогдолтой, үр дүнтэй ажил болов.

Сонгуулийн мэдээллийн e-electoin.mn цахим систем нь сонгуулийн процессын эрх зүйн судалгааны эх сурвалж, дата бүрдүүлэх судалгааны сан болж байгаагаараа онцлог юм.

нэр дэвшигчид

тойрог

нам, эвсэл

ирц

сонгуулийн дүн

2024 оны ИТХ-ын СОНГУУЛЬ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал(ИТХ)-ын 2024 оны ээлжит сонгууль 10-р сарын 11-ний өдөр зохион байгуулагдана.

🔍

📱

📺

1,992

Аймаг, нийслэлээр дэвшигчид

15,286

Сум, дүүргийн нэр дэвшигчид

268

Нэр дэлх нэр дэвшигч

12

Нам, эвсэл

НЭР ДЭВШИГЧИД

Та өөрийн ОРШИН СУУДАГ ХАЯГАА сонгоод ИТХ-ын тойрог болон танай тойрогт нэр дэвшиж, буй хуульсийн дайт хяналтгүй ихэрхэлтийг хараарай.

ХАЯГ СОНГОХ

Уламжлалт

Хронолтог

Сонгуулийн ерөнхий хорооны сонгуулийн мэдээллийн цахим систем e-electoin.mn-ийг эх сурвалж авна.

НАМ, ЭВСЭЛ

Монгол Ардын нам

Ардын нам

Үндэсний эвсэл

Иргэдийн зориг нэргэн нам

Шинэ нэргэн хэсэг

Эрхчлэлэгчид хамруулалт нам

Иргэдийн нэгдэлтэй нам


ХҮН нам

Уламжлалт нам

Сайн ардын нам

Ардын тэнгисийн эвсэлтэй нам

Иргэдийн Ойролцооны Нам



НЭР ДЭВШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛТЭЙ БҮРЭН ТАНИЛЦАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭВ


Сонгуулийн үйл ажиллагааны цахимжуулалтын үр дүнд бий болсон мэдээллийн санг эргэлтэд оруулахаар Сонгуулийн ерөнхий хороо нь ikon.mn мэдээллийн сайттай хамтран аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэлтэй тойрог тус бүрээр танилцах боломжийг бүрдүүлсэн. Өөрөөр хэлбэл, сонгогч оршин суух хаягаа сонгоод санал өгөх тойрог, мандатын талаар болон тухайн тойрогт нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй танилцуулгыг харах боломжтой боллоо.

СОНГОГЧДЫН ИРЦ, СОНГУУЛИЙН УРЬДЧИЛСАН ДҮНГ ШУУД ДАМЖУУЛАВ

Сонгуулийн ерөнхий хороо Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 07.00-20.00 цагийн хооронд сонгогчдын ирцийг нийслэл, дүүрэг, хороо, аймаг, сум, баг бүрээр Сонгуулийн ерөнхий хорооны болон аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны байранд шууд дамжуулан үзүүлээ.

Сонгогчдыг мэдээллээр шуурхай хангах, идэвхжүүлэх, сонгуулийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Сонгуулийн ерөнхий хороо mass.mn сайттай хамтран “Монгол Улсын сонгуулийн ерөнхий хороо” пэйж хуудсаар 14 цагийн турш





шууд дамжуулалт (live) хийсэн юм. Шууд дамжуулалтын үеэр Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Тамгын газрын дарга, Тамгын газар, Мэдээлэл, судалгаа, сургалтын төв, Мэдээллийн технологийн төвийн албан хаагчид мэдээлэл өгч байснаас гадна нийслэл, 21 аймгийн сонгуулийн хорооны дарга нар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, төрийн бус байгууллагын төлөөлөл цаг үеийн асуудлаар мэдээлэл, ярилцлага өгч, сонгогчдын асуултад тухай бүр хариулсан юм.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, 17 дугаар зүйлийн 17.3.4-т тус тус заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороод тухайн шатны сонгуулийн дүнг нэгтгэж, нийтэд албан ёсоор мэдээлдэг. Сонгуулийн хороодоос e-election.mn сайтын цахим санд ирүүлсэн урьдчилсан дүнг Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудасны дэд цэс (report.m-election.mn) - д анх удаа шууд мэдээлэв. Ингэхдээ тойрог, мандат, нэр дэвшигчдийг санал авсан байдлаар нь тойрог тус бүрээр эрэмбэлэн харуулснаар сонгогчид тухайн өдрөө сонгуулийн урьдчилсан дүнтэй танилцаж, мэдээлэл авах боломжийг бүрдүүллээ.


СОНГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ 725 ГОМДОЛ БҮРТГЭГДЖЭЭ

Цагдаагийн байгууллагад аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 725 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс 46.8 хувь нь орон нутагт, 53.1 хувь нь нийслэлд бүртгэгджээ.

Аймаг, Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүх аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбоотой 24 хэрэг маргааныг шийдвэрлэсэн байна.

Шүүхээр шийдвэрлэсэн хэрэг маргааны дийлэнхийг нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой маргаан эзэлжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэрүүд



“СОНГОГЧИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ, СОНГОХ ЭРХИЙН ӨДӨР-10.11”

АРГА ХЭМЖЭЭГ УЛС ДАЯАР ЗОХИОН БАЙГУУЛАВ

Сонгуулийн ерөнхий хороо, сонгуулийн хороод сонгуулийг нээлттэй, ил тод зохион байгуулахаас гадна сонгуулийн боловсролыг дээшлүүлэхэд онцгой анхаарлаа.

Сонгуулийн ерөнхий хороо 2024 оны 9 дүгээр сарын 13-15-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд болсон 36 дахь удаагийн “Номын баяр”-т оролцож “Сонгох эрхийн өдөр-10.11” өдөрлөг зохион байгуулан сонгуульд оролцогч талууд, олон нийт сонгогчдод мэдээ, мэдээлэл түгээн ном товхимол, гарын авлагаар ханган үйлчилсэн. Сонгуулийн хороод нийслэл, дүүрэг, аймаг, сумандаа 9 дүгээр сарын 13-наас эхлэн 29-ний өдрийг хүртэл амралтын өдрүүдэд “Сонгогчийн нээлттэй өдөрлөг-Сонгох эрхийн өдөр-10.11” арга хэмжээг улс даяар зохион байгуулав. Нээлттэй өдөрлөгийн үеэр сонгуулийн хороодын гишүүд орон нутгийн сонгуулийн онцлог, ач холбогдол, зохион байгуулалт, санал авах, тоолох үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл өгсөн.

Түүнчлэн санал тоолох автомат төхөөрөмжийн ажиллагаа, саналын хуудасны загварыг мэдээллийн технологийн багийнхан тайлбарлаж, иргэдийг сургалтын саналын хуудаст саналаа тэмдэглэж, төхөөрөмжид уншуулж, турших боломжоор хангаж, санал авах загварын байр ажиллуулсан юм.

Аймгийн сонгуулийн хороод нь сонгуулийн үйл явцтай холбогдох бүхий л мэдээллийг тухай бүр аймгийн сонгуулийн хорооны пэйж хуудас, бусад төрийн байгууллагуудын цахим хуудас, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэргээр хүргэн ажилласан. Энэ чиглэлээр Дорноговь аймгийн сонгуулийн хорооны хийж гүйцэтгэсэн ажлыг танилцуулъя.

Дорноговь аймгийн Сонгуулийн хорооны “Дорноговь аймгийн





Сонгуулийн хороо" фэйсбүүк пэйж хуудсыг тогтмол ажиллуулан иргэд, сонгогчдод мэдээлэл хүргэснээс гадна DTV, DSB 2 телевизэд сонгуулийн хорооноос нийт 9 удаа ярилцлага өгч, түүнийг нь тухайн телевизүүдийн фэйсбүүк пэйж хуудсаар түгээжээ. "Өнөөгийн Дорноговь", "Ялалт" 2 сонинд 2 удаа мэдээлэл, ярилцлага нийтлүүлж, "Dornogovipost.mn" цахим хуудас, сонгогчдод зориулсан зар мэдээг эдгээр телевиз, сонин, FM радиогоор тогтмол өгч ажиллажээ.

Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн "Сонгогч танаа" мэдээллийн цахим хөтөч, нугалбарыг сумдад яаралтай түгээх ажлыг зохион байгуулан сум, хэсгийн сонгуулийн хороод сонгогчдод 100 хувь хүргэж ажилласан. Ингэснээр сонгогчид ямар онцлогтой сонгуульд санал өгөх гэж байгаа, юун дээр анхаарах, аль хэсгийн хорооны санал авах байранд саналаа өгөхөө хэрхэн мэдэх, ямар саналын хуудсан дээр ажиллах зэрэг бусад шаардлагатай мэдээллийг авч чадсан. Хэсгийн хороодын ажилтнууд материал тараах үедээ мөн энэ талаар яриа таниулга хийж айл өрхөөр явсан болно.

Сонгогчийн нээлттэй өдөрлөгийг аймгийн төв болон 13 суманд зохион байгуулж нийт 1300 гаруй сонгогч иргэдэд үйлчилжээ. Өдөрлөгт анх удаа саналаа өгөх гэж байгаа болон нас насны сонгогчид, төрийн албан хаагчид, хөдөлмөрчид, иргэдийг өргөнөөр хамруулсан байна.



УЛС ТӨРИЙН НАМЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ШИНЭЧЛЭЛ



1990

Улс төрийн намын тухай хууль, 1990 оны БНМАУ-ын анхны улс төрийн намын тухай хууль нь нийгэм, улс төрийн шилжилтийн хууль байсан бөгөөд тус хууль 5 бүлэг, 35 зүйлтэй байв.

2005

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2005 он. Тус хууль 5 бүлэг, 25 зүйлтэй байв.

2023

Улс төрийн намын тухай / шинэчилсэн найруулга/ хууль 2023 оны 7 дугаар сарын 07-нд 7 бүлэг, 45 зүйлтэй батлагдсан. Улс төрийн намын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг мөн 2027 оны 7 дугаар сарын 07-нд баталсан бөгөөд уг хууль нь 5 зүйлээс бүрдэнэ.

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 7 дугаар сарын 07-нд баталсан. Шинэчилсэн найруулгын гол үзэл санаа нь улс төрийн намыг бодлогын институт болж төлөвшүүлэх, дотоод ардчиллыг дэмжиж бэхжүүлэх, намын санхүүжилтийн ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн.

Сонгуулийн ерөнхий хороо нь Улс төрийн намын санхүүжилт, түүнд тавих хяналтын болон Улс төрийн намын бүтэц зохион байгуулалт, мэдээллийн ил тод байдлыг хангах үндсэн хоёр чиглэлийн 18 чиг үүргийг хэрэгжүүлэхээр

Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд өөрчлөлт оров.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ

Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудаст “Намын нээлттэй мэдээлэл” цэс шинээр үүсгэж энэхүү цэсэд Монгол Улсын Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 намын мэдээллийг байршуулсан. Энэхүү мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг намын нээлттэй мэдээлэл хариуцсан ажилтантай шууд холбогдон тогтмол хамтран ажиллаж байна.

Нам цахим хуудсандаа дараах баримт бичиг, мэдээллийг ил тод, байршуулж, тухай бүр шинэчилнэ:

Нам цахим хуудсандаа дараах баримт бичиг, мэдээллийг ил тод, байршуулж, тухай бүр шинэчилнэ:

1. намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг;
2. намын дүрэм;
3. намын хөтөлбөр;
4. намын сонгуулийн мөрийн хөтөлбөр;
5. намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа газрын хаяг;
6. намын даргын ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
7. намын ерөнхий нарийн бичгийн дарга, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтны ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
8. намын удирдах дээд, төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын дарга, гишүүний ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
9. намын утасны дугаар, цахим шуудангийн хаяг;
10. намын гишүүний тоо;
11. намын болон харьяа байгууллагын санхүүгийн тайлан;
12. намын үйл ажиллагааны товч тайлан;
13. нам аймаг, сум, нийслэл, дүүрэгт салбар нэгжтэй бол тэдгээрийн нэгжийн даргын ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
14. намын бүтэц, зохион байгуулалт;
15. намын үйл ажиллагааны мэдээлэл;
16. бусад мэдээлэл.



УЛС ТӨРИЙН НАМ

Нам цахим хуудсандаа дараах баримт бичиг, мэдээллийг ил тод, байршуулж, тухай бүр шинэчилнэ:

1. намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг;
2. намын дүрэм;
3. намын хөтөлбөр;
4. намын сонгуулийн мөрийн хөтөлбөр;
5. намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа газрын хаяг;
6. намын даргын ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
7. намын ерөнхий нарийн бичгийн дарга, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтны ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
8. намын удирдах дээд, төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын дарга, гишүүний ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
9. намын утасны дугаар, цахим шуудангийн хаяг;
10. намын гишүүний тоо;
11. намын болон харьяа байгууллагын санхүүгийн тайлан;
12. намын үйл ажиллагааны товч тайлан;
13. нам аймаг, сум, нийслэл, дүүрэгт салбар нэгжтэй бол тэдгээрийн нэгжийн даргын ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
14. намын бүтэц, зохион байгуулалт;
15. намын үйл ажиллагааны мэдээлэл;
16. бусад мэдээлэл.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

1. намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг;
2. намын дүрэм;
3. намын хөтөлбөр;
4. намын сонгуулийн мөрийн хөтөлбөр;
5. намын гүйцэтгэх төв байгууллага оршин байгаа газрын хаяг;
6. намын даргын ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
7. намын ерөнхий нарийн бичгийн дарга, санхүүгийн асуудал хариуцсан удирдах ажилтны ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
8. намын удирдах дээд, төлөөллийн төв, гүйцэтгэх төв болон хяналтын байгууллагын дарга, гишүүний ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
9. намын утасны дугаар, цахим шуудангийн хаяг;
10. намын гишүүний тоо;
11. намын болон харьяа байгууллагын санхүүгийн тайлан;
12. намын үйл ажиллагааны товч тайлан;
13. Нам албан ёсоор нийтэд зарласан цахим хуудас;
14. нийгмийн сүлжээний хаяг



Нам албан ёсоор нийтэд зарласан цахим хуудас, нийгмийн сүлжээний хаягтай бол тэдгээрийг Харилцаа холбооны зохицуулах хороо, сонгуулийн төв байгууллагад бүртгүүлнэ.



УЛСЫН ДЭЭД
ШҮҮХЭД
БҮРТГЭЛТЭЙ НАМ

УУЛЗАЛТ
ХИЙСЭН НАМ

УУЛЗАЛТ ХИЙХЭЭР
ТӨЛӨВЛӨСӨН НАМ

ОГТ ХОЛБОО
БАРИХ БОЛОМЖГҮЙ НАМ

37

19

16

2

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Сонгуулийн ерөнхий хорооны Улс төрийн намын санхүүжилт, мониторингийн газар болон Улс төрийн намын мэдээлэл, арга зүйн газрын албан хаагчид улс төрийн намуудад Улс төрийн намын тухай хууль/шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан "Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх арга хэмжээг 2024 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хойш зургаан сарын дотор авч хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлэх асуудлаар улс төрийн намуудад мэдээлэл хүргүүлж, хамтарсан уулзалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа.

2024 оны 10 дугаар сараас эхлэн намуудтай нэг бүрчлэн уулзалт хийж намын дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтаа хуульд нийцүүлэх асуудал дээр хамтран ажиллаж байна.



НАМ, ЭВСЭЛД ОЛГОХООР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

Улс төрийн намын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т "Сонгуулийн төв байгууллага жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө төрийн санхүүжилт авах эрх бүхий нам бүрд төрийн санхүүжилтийн эрх үүсэх жилийн санхүүжилтийн хэмжээг энэ хуульд заасны дагуу тогтоож, нийтэд мэдээлнэ." гэж заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороо 2024 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар "Төрийн санхүүжилтийн хэмжээ тогтоох тухай" 203 тоот тогтоолыг хэлэлцэн баталлаа.

Дээрх хуульд нам, эвсэлд төрийн санхүүжилтийг 2 төрлөөр олгохоор заасан. Үүнд:

1. ЖИЛ БҮР ОЛГОХ САНХҮҮЖИЛТ:

Хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т "Нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан намд төрийн санхүүжилт олгоно.", 27.5-т "Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд дараах томъёогоор төрийн санхүүжилтийг жил бүр олгоно." гэж тус тус хуульчилсан.

$$H = /C1 \times T1/ + /C2 \times T2/$$

"Н" гэж нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн дэмжлэг авсан намд хуваарилах нийт санхүүжилтийг;

"C1" гэж Улсын Их Хурлын сонгуулиар тухайн намын авсан саналын тоог;

"C2" гэж Улсын Их Хуралд тухайн намын авсан суудлын тоог;

"T1" гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.5 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийг;

"T2" гэж нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийг.

2. ДӨРВӨН ЖИЛД НЭГ УДАА ОЛГОХ САНХҮҮЖИЛТ:

Хуулийн 27 дугаар зүйлийн 27.7-т "Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангасан намд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн тоог болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоог энэ хуулийн 27.6.5-д заасан дүнгээр үржүүлсэнтэй тэнцэх төрийн санхүүжилтийг тухайн ээлжит сонгуулийн дараагийн жил зөвхөн нэг удаа олгоно." гэж заасан.

Дээрх 2 тооцооллын дагуу нам, эвсэлд олгож болох төрийн санхүүжилтийн дээд хэмжээг хуульд заасны дагуу төлөвлөж тооцсон. Улс төрийн намын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т зааснаар Сонгуулийн ерөнхий хороо нь нам, эвслийн санхүүгийн тайланг хянасны дараа дээрх санхүүжилтийн хэмжээг эцэслэн тогтоож, олгоно.

СОНГУУЛИЙН ДАРААХ ЖИЛД НАМ, ЭВСЭЛД ОЛГОХООР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

(Улс төрийн намын тухай хуулийн §29.1, §29.2-т заасны дагуу 9 дүгээр сарын 15-наас өмнө нийтэд мэдээлнэ)

№	Нам, эвслийн нэр	Нийт санхүүжилт ₮ (\$27.5, \$27.7)	Жил бүр олгох санхүүжилтийн тооцоолол				Дөрвөн жилд нэг удаа олгох санхүүжилт				
			УИХ-ын суудлын тоо (\$27.6.3)	Санал өгсөн сонгогч (\$27.3)		Төрийн санхүүжилтийн хэмжээ ₮ (\$27.5)	Намын өөрийн орлогын доод хэмжээ ₮ (\$27.8)	Хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн тоо	Дүн ₮ (\$27.7)	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нэр дэвшүүлсэн тоо	Дүн ₮ (\$27.7)
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Монгол Ардын Нам	2,819,790,600	68	509,482	24.23	2,803,290,600		0	-	1	16,500,000
2	Ардчилсан Нам	2,173,069,800	42	438,506	20.85	2,140,069,800		0	-	2	33,000,000
3	ХҮН нам	993,666,300	8	151,111	7.19	630,666,300		20	330,000,000	2	33,000,000
4	Үндэсний эвсэл	446,146,800	4	75,196	3.58	314,146,800		8	132,000,000	0	-
5	Иргэний Зориг Ногоон Нам	455,419,800	4	73,006	3.47	306,919,800		7	115,500,000	2	33,000,000
6	Шинэ нэгдсэн эвсэл	312,450,600		69,682	3.31	229,950,600		2	33,000,000	3	49,500,000
7	Үнэн ба Зөв нам	250,083,900		40,783	1.94	134,583,900		5	82,500,000	2	33,000,000
НИЙТ ДҮН		7,450,627,800	126	1,357,766	64.56	6,559,627,800	-	42	693,000,000	12	198,000,000

Эвсэлд нэгдсэн намуудын санхүүжилтийг хуулийн §27.9-д заасны дагуу олгоно. Эвслийн гэрээнд өөрөөр заагаагүй бол §27.10-т заасны дагуу "C1" буюу сонгогчийн саналын тоонд бодогдох санхүүжилтийг тухайн эвсэлд нэгдсэн намуудад тэнцүү хувааж, "C2" буюу УИХ-д авсан суудлын тоог тухайн нэр дэвшүүлсэн намд тооцон хуваарилна.



СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО АЗИЙН СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБООНЫ **УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭР** **СОНГОГДЛОО**



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо Азийн Сонгуулийн байгууллагуудын холбооны Удирдах зөвлөлд сонгогдож, 2024-2026 онд гишүүнээр ажиллахаар боллоо.

Азийн Сонгуулийн байгууллагуудын холбооны удирдах дээд байгууллага болох Ерөнхий ассамблейн чуулган 2024 оны 9 дүгээр сарын 11-13-ны өдөр Тайваньд боллоо. Чуулганд Монгол Улс, Энэтхэг, Бангладеш, Индонез, БНСУ, Мальдив, Филиппин, Балба, Казахстан улс болон АНУ-д төвтэй Сонгуулийн системийн олон улсын хүрээлэнгийн төлөөлөгчид оролцов.

Нээлттэй, ил тод, бие даасан, шударга сонгууль зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, харилцан туршлага солилцох, сонгуультай холбоотой мэдээлэл, судалгаа явуулах зорилготой ажилладаг тус холбоонд Ази, Номхон далайн 20 гаруй орнууд гишүүнээр ажилладаг юм.

Ерөнхий Ассамблейн энэ удаагийн чуулганаар холбооны Нарийн бичгийн дарга нарын газрыг байнга үйл ажиллагаа



явуулахаар байгуулах, Орлогч дарга сонгох болон Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох зэрэг зохион байгуулалтын асуудлыг хэлэлцлээ. Улмаар Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, Бүгд Найрамдах Казахстан улсын Сонгуулийн төв комиссыг Холбооны Удирдах зөвлөлийн гишүүнээр сонголоо. Түүнчлэн Холбооны Нарийн бичгийн дарга нарын газрыг Шинэ Дели хотноо байгуулж, Бүгд Найрамдах Филиппин улсын Сонгуулийн комиссыг Орлогч даргаар сонгов.

Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир Удирдах зөвлөлийн гишүүний хувиар холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцохоо илэрхийллээ.

Азийн Сонгуулийн байгууллагуудын холбооны Ерөнхий ассамблейн чуулганы хүрээнд “Сонгуулийн шударга байдал, ташаа мэдээлэлд хариу өгөх нь” сэдэвт олон улсын семинар зохион байгуулсан бөгөөд оролцогчид сонгуулийн үеэр гардаг ташаа мэдээлэлд хэрхэн хариу өгдөг, ямар арга хэмжээ авдаг талаар туршлагаа хуваалцав.

Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир чуулганы үеэр Азийн Сонгуулийн байгууллагуудын холбооны дарга Чин Янг Литэй хоёр талын уулзалт хийж сонгууль зохион байгуулах, төлөвлөх, мэдээллийн бааз бүрдүүлэх, жендэрийн талаарх эрх зүйн таатай нөхцөл бүрдүүлэх чиглэлээр харилцан туршлага солилцох, сургалт зохион байгуулах талаар ярилцлаа.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА ДЭЛХИЙН СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙН ЧУУЛГАНД ОРОЛЦОВ

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбоо (A-WEB)-ны Ерөнхий Ассамблейн 6 дугаар чуулганд оролцлоо.

Бүгд Найрамдах Колумби Улсын Богота хотод 2024 оны 10 дугаар сарын 23-нд болсон тус чуулганаар Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбооны 2023-2024 оны үйл ажиллагаа, цаашдын зорилго, санхүүгийн тайланг хэлэлцсэн юм. Дараагийн хоёр жилд Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбоог тэргүүлэх Бүгд Найрамдах Колумби Улсын сонгуулийн байгууллагад эрх мэдэл шилжүүлэн өсөж, орлогч даргыг сонгов.

Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбооны Ерөнхий Ассамблейн 6 дугаар чуулганд 43 улсын сонгуулийн төв байгууллагуудын удирдлага тэргүүтэй 150 гаруй төлөөлөгч оролцсон юм.





АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН 47 ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧИЙГ СОНГОХ СОНГУУЛИЙГ АЖИГЛАЛАА



хэл дээр явагддаг бөгөөд сонгогч өөрийн ашиглах хэлний сонголтыг хийж санал өгдөг. Энэхүү хэлний сонголтод монгол хэлээр санал өгөх сонголт мөн байсан бөгөөд тус хотод санал өгөх эрхтэй 11 монгол иргэн эх хэлээрээ санал өгөх боломжтой байв.

Санал авах, тоолох төхөөрөмжийг хадгалах агуулах: Тус агуулахад нь сонгуулийн бүх тоног, төхөөрөмжийг хадгалах, төхөөрөмжид шаардлагатай үйлчилгээ хийх болон сонгууль бэлтгэхэд зориулагдсан зориулалтын агуулах гэдгийг танилцууллаа. Монгол Улсын хувьд сонгуулийн тоног төхөөрөмжийг бэлтгэх, хадгалах, засвар үйлчилгээ хийх стандартад нийцсэн агуулахтай болох хэрэгцээ шаардлага байсаар байна.

Тооллогын төв: Лос-Анжелес хотод сонгогч урьдчилан санал өгөх боломжтой бөгөөд урьдчилан шуудангаар санал өгсөн сонгогчдын саналыг тоолох тооллогын төвийн үйл

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, улс төрийн намын мэдээлэл, арга зүйн газрын дарга Д.Баяндүүрэн 2024 оны 10 дугаар сарын 29-нөөс 11 дүгээр сарын 3-ны хооронд Лос Анжелес хотноо Америкийн нэгдсэн улсын 47 дахь ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн үйл ажиллагааг ажиглалаа. Уг арга хэмжээнд Эстони, Армен, Мексик болон Монгол Сонгуулийн байгууллагын төлөөлөл, Колумби, Бразил улсын Судлаачид болон сонгуулийн шүүхийн байгууллагын төлөөлөл оролцов. Оролцогчид Америкийн сонгуулийн үйл ажиллагаатай танилцахаас гадна өөрсдийн орны сонгуулийн туршлага болон сонгуульд хэрэглэж буй технологийн шийдлийн талаар харилцан бие биедээ танилцууллаа.

Сонгууль ажиглах хөтөлбөрийн хүрээнд Лос Анжелес хотын урьдчилсан санал авах байр, санал тоолох төхөөрөмжийн агуулах, урьдчилан санал өгсөн саналын хуудсыг тоолох төвийн үйл ажиллагаатай танилцлаа.

Санал авах байрны үйл ажиллагаа: Лос Анжелес хот нь сонгуулийн санал авах, тоолох хамгийн сүүлийн үеийн төхөөрөмж болох санал тэмдэглэх, саналын хуудаст хэвлэх, тоолох системийг ашигладаг талаараа оролцогчдод танилцуулж байлаа. Санал авах үйл ажиллагаа нь 12 улсын



БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛСАД ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ БОЛОВ

Ч.Баттөмөр



Бүгд найрамдах Киргиз улсын орон нутгийн сонгууль 2024 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр боллоо. Уг сонгуулийг 2024 оны 8 дугаар сарын 6-ны өдөр хүчин төгөлдөр болсон Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн дагуу зохион байгуулсан юм. Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран Бүгд найрамдах Киргиз улсын Сонгуулийн төв комиссын урилгаар тус сонгуулийг ажиглалаа.

2024 оны хуулиар шинэчлэн тогтоосон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн 7 муж, 40 дүүргийн хотын 33, тосгоны 231 нийт 264 депутатыг сонгох сонгуульд нийт 4.135.039 сонгогчид оролцохоор бүртгүүлснээс 28.63 хувь нь буюу 1.183.965 сонгогч сонгуулийн 2438 хэсэгт саналаа өглөө. Сонгуульд улс төрийн 33 нам төлөөлөгчөө нэр дэвшүүлэн оролцсоноос урьдчилсан байдлаар “Жаны Куч-Новая сила” нам 29.52 хувь, “Эмгек” нам 22.13 хувь, “Адилет” нам 15.01, “Ынтымак” нам 13.94 хувь, “Эл умуту” нам 10.89, “Против всех” нам 7.13 хувь, “Улуу журт” нам 1.34 хувийн санал тус тус авчээ.

Шинэчлэн баталсан Орон нутгийн сонгуулийн тухай хуулийн онцлогоос дурдвал,



Хотын сонгуульд улс төрийн намуудын хувьд жагсаалтаар нэр дэвшигчийн сонгогдох сонгогчдын саналын босго 7 хувь байсныг 5 хувь болгон бууруулсан.



Намууд нэр дэвшүүлэхдээ тухайн орон нутгийн сонгуулийн тойрог тус бүрд ногдсон мандатын тооноос илүүгүй хүний нэр дэвшүүлнэ. Урьд нь

мандатын тооноос илүү тооны хүнийг дэвшүүлж байв.



Тосгоны депутатад нэр дэвшигчдийн хувьд 1000 сом /киргизийн мөнгөн тэмдэгт/-ын барьцаа шаарддаг байсныг болиулсан.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгогдох эрхийг өргөтгөсөн. Тухайлбал, улс төрийн нам тус бүр хотын сонгуульд нэр дэвшигчдийн жагсаалтад наад зах нь хөгжлийн бэрхшээлтэй нэг иргэний нэрийг оруулсан байх болзол тавьсан.



Сонгуулийн нэг хэсэгт байх сонгогчдын тоо нь 2500-3000 байхаар зохицуулсан.



Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчид нь эрхэлж буй албан тушаалын үүргээ түр зогсоох, эсхүл албан тушаалын үүргээс бүрмөсөн чөлөөлөгдсөн байх зэрэг шаардлагыг зааглан чангатган тусгаж өгсөн.



Төрийн болон орон нутгийн захиргаанд алба хаагч улс төрийн албан тушаалтнууд сонгуульд оролцох бол бүрэн эрхээсээ татгалзсан байхаар зохицуулсан.



Сонгуулийн хууль зөрчин аливаа нэр дэвшигч буюу намын төлөө саналаа өгсөн нь тогтоогдвол тухайн нэр дэвшигч болон намыг дараагийн сонгуульд оролцуулахгүй байхаар зохицуулсан зэрэг болно.



ГҮРЖ УЛС СОНГОГЧДЫНХОО САНАЛЫГ АНХ УДАА САНАЛ ТООЛОХ АВТОМАТ ТӨХӨӨРӨМЖӨӨР ТООЛОВ

Б.Уянга

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Д.Баяндүүрэн, гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан референт Б.Уянга нар Гүрж улсын Сонгуулийн төв хорооны урилгаар тус улсын парламентын сонгуулийн үйл ажиллагааг ажиглалаа.

Гүрж улсын нэг танхимт парламентын 150 гишүүнийг сонгох сонгуулийн санал хураалт 2024 оны 10 дугаар сарын 26-ны Бямба гаригт болсон юм. Энэ удаагийн сонгуулийг Үндсэн хуульд 2017 онд оруулсан өөрчлөлтийн дагуу хувь тэнцүүлэх буюу пропорциональ тогтолцоогоор явуулсан бөгөөд саналаа өгсөн сонгогчийн 5 хувийн санал авсан нам, эвсэлд парламентад суудал хуваарилах зохицуулалттай. Парламентын гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байдаг.

Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлтэй 3,508,294 сонгогч 3111 санал авах байр, 42 улсын 67 дипломат төлөөлөгчийн газартаа саналаа өгчээ. Санал хураалт 10 дугаар сарын 26-ны өдрийн 08:00 цагт эхэлж 20:00 цагт дууслаа. Гадаад дахь сонгогчдын тоо 95,910 байсан нь 2020 оныхоос 42 хувиар өссөн үзүүлэлт юм байна. Сонгогчийн ирц 59 хувьтай байлаа.

Парламентын сонгуульд нийт 19 нам эвсэл бүртгүүлсэн бөгөөд 18 намын хаалттай жагсаалтаар 1185 нэр дэвшигч өрсөлдсөн. Нийт нэр дэвшигчдийн 29 хувь нь эмэгтэй байв.

Энэ удаагийн сонгуулийн онцлог нь сонгогчдын 90 хувийн саналыг санал тоолох автомат төхөөрөмжөөр уншуулжээ. Харин алслагдмал санал авах байр болон гадаад улс дахь сонгогчдын саналыг уламжлалт аргаар буюу хайрцагт авч, саналын хуудсыг гар аргаар тоолсон.

Гүржийн мөрөөдөл (Georgian Dream) нам нь 2012 оноос одоог хүртэл парламентад олонх болж сонгогдож байсан бол энэ удаагийн сонгуулиар ч 53,92 хувь буюу дийлэнх саналыг авснаар ялалт байгууллаа. Харин нийт саналын 5 хувийг авах босгыг давсан сөрөг хүчний дөрвөн эвсэл парламентад суудалтай боллоо. Тэдгээр дөрвөн эвсэл нийт сонгогчийн 37,78 хувийн санал авчээ.

Гүрж Улсын парламентын сонгуулийг 68 төрийн бус байгууллагын 2602, олон улсын 51 байгууллагын 512 ажиглагч ажиглав.





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙГ АЖИГЛАСАН ОЛОН УЛСЫН СОНГУУЛЬ АЖИГЛАХ ХОРООНЫ УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ

2024 оны 6 дугаар сарын 28.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар нь 1991 онд байгуулагдсан. Тус байгууллага нь гишүүн орнуудад болж буй сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт хийх, сонгуулийн болон хүний эрхийн байгууллагад техникийн тусламж үзүүлэх, зөвлөгөө өгөх, ТББ, иргэний нийгмийн хөгжлийг дэмжих, тэдэнд зориулсан сургалт семинар зохион байгуулах зэргээр ардчиллыг хөгжүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагаа явуулдаг.

Монгол Улс 2012 онд ЕАБХАБ-ын 57 дахь гишүүн болж элсэн орсноос хойш идэвхтэй хамтран ажиллаж байна.

Ардчилсан институт, хүний эрхийн газар 2013 оноос хойш Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үйл ажиллагааг өргөн бүрэлдэхүүнтэйгээр ажиглаж, ажиглалтын тайлангаа зөвлөмжийн хамт боловсруулан манай улсад илгээснээс гадна Монгол Улсын сонгуулийн сайн туршлагыг ЕАБХАБ-ын гишүүн орнуудад танилцуулсаар ирсэн.

Мөн Ардчилсан институт, хүний эрхийн газар нь 2019 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай болон Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг боловсруулах явцад эдгээр хуулийн төсөлтэй холбоотой тодорхой санал зөвлөмжүүдийг боловсруулан олон улсын сонгуулийн сайн туршлагын хамт ирүүлсэн нь гишүүн орнуудынхаа сонгуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудалд байнга анхааран дэмжлэг үзүүлж байдгийн нэгэн жишээ юм.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институт, хүний эрхийн газраас 30 улсын 199 ажиглагч болон Европын парламентын 13 төлөөлөгч ажиглаж урьдчилсан дүгнэлтээ гаргасныг хүргэж байна.

6-р сарын 28-ны өдөр болсон Монгол Улсын Их хурлын сонгууль сайн зохион байгуулалттай болсон ч тэгш өрсөлдөх боломж хомс байсан нь өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөв. Эрх зүйн орчин ардчилсан сонгууль явуулахад хангалттай байсан боловч хүний үндсэн эрх, эрх чөлөөний талаарх олон улсын стандартад цаашид илүү нийцүүлэх шаардлагатай байна. Сонгуулийн байгууллага сонгогчдын боловсролын иж бүрэн хөтөлбөр хэрэгжүүлж, олон нийтийн итгэлийг хүлээж, мэргэжлийн түвшинд ажилласан. Өрсөлдөгчид нийгмийн сүлжээнд болон бусад хэд хэдэн хязгаарлалтаас үл хамааран

чөлөөтэй сурталчилгаа явуулж чадсан ч, сонгуулийн албан ёсны сурталчилгааны хугацаа богино байсан нь нөөц ихтэй, тогтсон намуудад давуу тал боллоо. Түүнчлэн, сонгууль угтаж цалин нэмэх гэх мэт нийгмийн халамжийн хэд хэдэн хөтөлбөр нь эрх баригч намд үлэмж давуу байдлыг бий болгов. Оролцогч талууд сонгогчдын нэрийн жагсаалт сонгогчдын бүрэн хамруулсан байдалд итгэл төгс байсан хэдий ч уурхайн талбарт ажилладаг иргэд гэх мэт сонгогч бүр санал өгөх боломжоор хангагдаж буй эсэхэд санаа зовж байсан юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өргөн хүрээнд

ажилласан ч мэдээ сурвалжлага, дүн шинжилгээ бүхий мэдээний хөтөлбөрийн хязгаарлагдмал байдал, эрх баригч намыг илүү дэмжсэн байр суурь нь сонгогч мэдээлэлд суурилан сонголтоо хийх чадварт сөргөөр нөлөөлөв. Сонгуулийн өдөр санал хураах үйл явц эмх цэгцтэй, саадгүй явагдаж, санал тоолох автоматжуулсан тооллого ил тод, шуурхай явагдаж, мэдээлсэн боловч хэд хэдэн хэсгийн хороонд саналын хуудас нэгтгэх, саналыг баталгаажуулах үйл явц хэд хэдэн хэсгийн хороонд журмыг бүрэн дагаагүй нь санал тоолох үйл явцад сөрөг нөлөө үзүүлээ.

2023 оны 5-р сард парламентыг илүү хүчирхэг, олон талт байдлыг хангасан болгох зорилгоор Үндсэн хуульд томоохон өөрчлөлт оруулж, парламентын гишүүдийн тоог 76-аас 126 болгон нэмэгдүүлж, холимог тогтолцоонд шилжсэний дараа парламентын сонгууль боллоо. Эрх баригч Монгол Ардын Нам (МАН) сүүлийн найман жилийн хугацаанд улс төрийн тавцанд ноёрхож, мөн сүүлийн хоёр удаагийн УИХ-ын сонгуулиар үнэмлэхүй олонхийг бүрдүүлж, улмаар 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар ялалт байгуулж, эрх мэдлээ улам бататгасан. Өндөр түвшний авлигын хэрэг, хөдөөгийн малчин иргэд эдийн засгийн хүндрэлтэй тулгарсан үед сонгууль болж өнгөрлөө.

Хууль, эрх зүйн орчин нь ардчилсан сонгууль явуулахад хангалттай бүрдсэн хэдий ч үндсэн эрх, эрх чөлөөг эдлүүлэхтэй холбоотой орчныг цаашид сайжруулах шаардлагатай байна. Сонгуулийн тогтолцоог өөрчилсөн Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдээс гадна 2023 онд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдээр сонгууль товлон зарласнаас хойш байгуулагдсан намуудад нэр дэвшүүлэх боломжийг олгосон, нэр дэвшигчдийн хүйсийн квотыг өсгөсөн, улс төрийн намуудын удирдах байгууллагуудад хүйсийн болон нийгмийн олон бүлгийн төлөөллийг оролцуулах шаардлага тавьж байгаа зэрэг эерэг зохицуулалтуудыг тусгасан байна. Гэхдээ АИХЭГ-аас удаа дараа өгсөн сонгох, сонгогдох эрх болон үг хэлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, сонгуулийн хэрэг маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх хугацаатай холбоотой зөвлөмжүүд орхигдсон хэвээр байна.

Улсын Их Хурлын 78 гишүүнийг сонгуулийн 13 тойргоос олныг төлөөлөх мажоритар аргаар, үлдсэн 48 гишүүнийг Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн нэг тойргоос хувь тэнцүүлэн төлөөлөх пропорциональ аргаар сонгоно. Хуулиар сонгуулийн тойрог байгуулахдаа олон хүчин зүйлийг харгалзан үзэх зохицуулалттай боловч сонгуулийн тойргуудын сонгогчдын тоо их зөрүүтэй байгаа нь саналын эрх тэгш байдлын талаарх олон улсын сайн туршлагад нийцэхгүй байна.

Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ) мэргэжлийн, ил тод байдлаар ажиллаж, өрсөлдөгчид болон ажиглагчдад нээлттэй хандсан төдийгүй, Олон улсын сонгууль ажиглах хорооны (ОУСАХ) уулзсан хүмүүсийн дийлэнх нь бүх шатны сонгууль зохион байгуулах байгууллагад итгэлтэй байгаагаа илэрхийлсэн юм. ОУСАХ нэг удаагийн СЕХ-ны хуралдааныг ажигласан боловч доод шатны сонгуулийн хорооны хуралдаануудад уригдаагүй төдийгүй хурлын тэмдэглэл нийтлэгдээгүй болно. СЕХ болон Аймаг, нийслэлийн сонгуулийн хороод (АНСХ) сонгогчийн боловсролын иж

бүрэн кампанит ажлыг цахим болон уламжлалт хэвлэл мэдээллээр зохион байгуулсан. Хуульд хяналтын тооллого хийж үр дүнг баталгаажуулах шаардлага орсноос үл хамааран сонгуулийн үр дүнг хэрхэн хуурамчаар үйлдэж болох тухай дэлгэрэнгүй тайлбар, нотолгоо байхгүй ч гэсэн машинд суурилсан санал тоолох төхөөрөмжийн үнэн зөв ажиллагааны талаар эргэлзээ төрөл бүрийн сонгуулийн оролцогч талуудад байсаар байна. Өмнө нь АИХЭГ-аас гаргасан зөвлөмжөөс үл хамааран санал тоолоход ашигладаг цахим төхөөрөмжийн хөндлөнгийн баталгаажуулалт, гэрчилгээжүүлэх шаардлагыг хуульд тусгасангүй.

5-р сарын 28-ны өдөр Улсын Бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ) 2.2 сая сонгогч бүртгэгдсэнийг зарласан. Иргэд өөрсдийн оршин суугаа хаяг дээрх нийт бүртгэгдсэн сонгогчийг цахимаар шалгах боломжтой болжээ. Ерөнхийдөө, ОУСАХ-ны ярилцсан хүмүүс сонгогчдын нэрийн жагсаалт бүх сонгогчийг хамруулсан гэдэгт итгэж буй боловч УБЕГ сонгогчийн дахин бүртгэл хийсэн талаар хураангуй мэдээлэл өгөхдөө хангалттай ил тод байгаагүйтэй холбоотой санаа зовнил байгааг ч илэрхийлсэн. ОУСАХ-ны уулзсан зарим хүмүүс өнгөрсөн хоёр жилийн хугацаанд сонгуульд нэр дэвшиж буй зарим ажил олгогч өөрийн ажилчдаа дэвшиж буй тойрог руугаа шилжүүлж, саналыг нь авахын тулд тасралтгүй шахаж байсан талаар мэдээлэв. Түүнчлэн, зарим бүлэгт хамаарах хүмүүс, ялангуяа уурхайн талбарт ажилладаг хүмүүс сонгуулийн өдөр хэрхэн санал өгөх талаарх зовнил ихэссэн байна.

Санхүүгийн болон эрх зүйн нөхцөл гэх мэт нэр дэвших эрхийг ихээхэн хязгаарласан хэд хэдэн хязгаарлалт хуульд тусгагджээ. Улс төрийн нам, эвслүүд сонгуульд оролцох сонирхлоо сонгуулийн өдрөөс 60-аас доошгүй өдрийн өмнө СЕХ-нд мэдэгдэх ёстой төдийгүй, Үндэсний Аудитын газраас (ҮАГ) мөрийн хөтөлбөр нь Засгийн газрын хөтөлбөр, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцэж буй талаар баталгаа авах ёстой. 6-р сарын 10-ны өдөр СЕХ энэ сонгуулийн аль аль өрсөлдөөнд 19 нам, 2 эвсэл 42 бие даагчид нийт 1336 нэр дэвшигчийг бүртгэсэн талаар мэдээлсэн. СЕХ нэр дэвшигчдийн бүртгэлийг журмын дагуу явуулж, ирүүлсэн материалыг засаж, залруулах боломжоор хангасан хэдий ч нэр дэвшихийг хязгаарласан хэд хэдэн шаардлага болон сонгогдох эрхэд хамаарах хэт өндөр шаардлага нь саналын хуудасны тэгш хамруулсан байдалд эргэлзээ төрүүлэв. Хөгжлийн бэрхшээлтэй 4 нэр дэвшигч бүртгэгджээ.

Ерөнхийдөө өрсөлдөгчид чөлөөтэй, хөндлөнгийн оролцоогүйгээр кампанит ажлаа явуулсан хэдий ч, кампанит ажил оролцох тэгш бололцоогоор дутагдаж байв. Кампанит ажлын үеэр сумын намын хорооны дарга амиа алдсан харамсалтай хэрэг гарсан бөгөөд тус хэрэг одоогоор шалгагдаж байна. Сонгуулийн кампанит ажлын 17 хоногийн богинохон хугацаанд хэт томсгосон тойрогт сонгогчдод хүрсэн сурталчилгаа хийхэд хэдийнээ бэхэжсэн улс төрийн намууд илэрхий давуу талтай байсан бол жижиг улс төрийн намууд сурталчилгаандаа сайн дурын ажилчид, нийгмийн сүлжээг голдуу ашиглав. Цахим сурталчилгаа



АНСХ-нд бүртгэгдсэн цахим хуудас, нийгмийн сүлжээгээр хязгаарлагдсан бол сонгуулийн албан хаагчид худал, хуурамч мэдээ тараасан, сонгогчдыг хууран мэхэлсэн сурталчилгаа хууль сахиулах байгууллагын зөвлөмжид үндэслэн тус контентыг устгах хүсэлтийг тухайн нийгмийн сүлжээ илгээх эрхтэй. Өрсөлдөгчид өөрсдийн мөрийн хөтөлбөрийг урт хугацааны хөгжлийн бодлого, төсвийн тогтвортой байдлын шаардлага зэрэг засгийн газрын хөтөлбөрүүдтэй нийцүүлэхийг хуулиар шаарддаг. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, улс төрийн олон ургалч үзлийг хязгаарлаж байна. Төрийн болон нийтийн албан хаагчдыг эрх баригч нам сонгуулийн кампанит ажилд туслахыг шаардсан нь сонгогчдын чөлөөтэй саналаа өгөх бололцоог үгүй хийж байна гэх буруутгал өргөн хүрээнд тархав. Сонгууль болохоос өмнө засгийн газар цалин нэмэх, нийгмийн халамжийг нэмэгдүүлэх гэх мэт хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлснийг төрийн албан хаагчид сурталчилж, эрх баригч намын кампанит ажилд ашиглагдаж байсан юм. Эдгээр үйлдэл нь нам, төрийн заагийг бүдгэрүүлж, эрх баригч намд хэт давуу тал олгож буй нь ЕАБХАБ-ын үүрэг амлалттай зөрчилдөж байна.

Үндсэн хуульд жендэрийн тэгш байдлыг баталгаажуулсан ч улс төрийн амьдралд, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй, жендэрийн хэвшмэл ойлголт, хязгаарлагдмал нөөц зэрэг саад байсаар байна. Саяхны хуулийн өөрчлөлт 30 хувийн хуулийн өөрчлөлт, пропорциональ жагсаалтад хүйсийн тэнцвэрт харьцааг хангаж, хуулийн квотоос гадна эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх санхүүгийн хөшүүрэг бий болгосон нь эерэг өөрчлөлт болсон. Анхан шатны сонгуулийн хороонд эмэгтэйчүүд хангалттай төлөөлөгдсөн хэдий ч, АНСХ-ны түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага төдийгүй СЕХ-ны ердөө нэг гишүүн нь эмэгтэй байна. Сонгуулийн аль аль өрсөлдөөнд бүртгэгдсэн 1336 нэр дэвшигчийн 519 нь эмэгтэйчүүд юм. Хэдийгээр тэд улс даяар идэвхтэй сурталчилгаа хийсэн боловч, эмэгтэйчүүдэд чиглэсэн улс төрийн мессеж бараг л байсангүй.

Үндэсний Аудитын газар сонгуулийн сурталчилгааны зардлыг хянах, сонгуулийн тойргийн хэмжээ, хүн ам зүйн байдалд үндэслэн зардлын дээд хэмжээг тогтоох үүрэгтэй. ОУСАХ-ны хэд хэдэн ярилцагчид сонгуулийн зардлын дээд хэмжээ хэт өндөр байгаа нь хэдийнээ бэхэжсэн,

парламентад суудалтай улс төрийн намуудад болон намаас санхүүгийн ихээхэн нөөц боломжтой нэр дэвшигчдэд давуу тал олгож буйг тэмдэглэсэн. УАГ сонгуулийн санхүүжилт, зардлыг хянах хуулиар хүлээсэн үүрэгтэй боловч, үйл ажиллагаанд мониторинг хийгээгүй нь улс төрийн намын эгэх хариуцлагад чиглэсэн хуулийн заалтын үр дүнтэй байдлыг бууруулсан юм. УАГ нь хуулийн зөрчилд хориг арга хэмжээ авах эрх мэдэлгүй, харин мэдээллийг холбогдох байгууллагууд руу шилжүүлдэг. Ерөнхийдөө сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тогтолцоонд хяналт тавих үр дүнтэй механизм, хориг арга хэмжээ хангалтгүй байна.

Харьцангуй жижиг арилжааны зах зээл бүхий хэвлэл мэдээллийн салбар олон ургалч боловч, улс төрийн харьяалал, редакцын хараат бус байдлыг бүдгэрүүлж буй эдийн засгийн нөхцөл гэх мэт сорилтууд тулгардаг. Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз (МҮОНРТ) олон нийтийн дунд харьцангуй нэр хүндтэй бөгөөд, нэр дэвшигчдэд мэтгэлцээн болон бусад хэлбэрээр эфирийн цагаа нэр дэвшигчдэд үнэгүй олгох үүргээ биелүүлсэн. Бусад олон янзын мэтгэлцээн хувийн телевизүүдээр дамжуулагдсан. Мэдээ, сурвалжилгын хязгаарлагдмал байдал, эрэн сурвалжилсан, анализ дүгнэлт бүхий мэдээлэл бараг л харагдаагүй тул сонгогчдод мэдээлэлд суурилан сонголт хийх бололцоог хангалттай олгоогүй. Сонгуулийн сурталчилгааны үеэр хийсэн хэвлэл мэдээллийн мониторингоос харахад МҮОНРТ болон хувийн хэвшлийн хэд хэдэн телевиз эрх баригч намыг илэрхий дамжуулж

байлаа. Үндсэн хуульд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан боловч худал мэрээ тараахтай холбоотой хуулийн заалтын 2020 онд дахин сэргээснээс хэд хэдэн сэтгүүлч эрүүгийн хэрэгт шалгагдаж байна. Эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилт эрэн сурвалжлах сэтгүүл зүйг боомилсноос, сэтгүүл зүй өөрийгөө цензурдэхэд хүрч, нийтийн хэлэлцүүлэг өрнөхөд сөрөг нөлөө үзүүлж байна.

Шүүхээр сонгуультай холбоотой хэрэг маргааныг шуурхай шийдвэрлэх журам байхгүй. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хуулийн хугацааг баримталдаг. Хэдий шүүх сонгуультай холбоотой маргааныг цөөн хоногийн дотор шийдвэрлэхийг эрмэлзэн ажиллаж байгаа боловч шийдвэрлэх хугацаа нь сонгуулийн цаг хугацааны хуваарьтай уялдахгүй байгаа тул зөрчигдсөн эрхийг сэргээх үр нөлөөг бууруулж байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нам, нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой нийт арван таван нэхэмжлэл ирсэн. Үүнээс таван нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзсан ба шүүхээр шийдвэрлүүлсэн арван маргааны тавынх нэхэмжлэлийн шаардлагыг ханган СЕХ-ны шийдвэрийг хүчингүй болгож, нэр дэвших боломжоор хангасан хэдий ч ихэнхийнх нь хувьд сонгуулийн сурталчилгаа эхлээд талдаа орсон байсан. Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамд заасан хуулийн хугацаа нь цаг хугацааны тохиромжтой байдал болон зөрчигдсөн эрхийг сэргээх үр нөлөөг хангаж чадахгүй байна.



Хуулиар иргэний болон олон улсын ажиглалтыг зөвшөөрдөг. Улс төрийн нам, эвслүүд мөн санал авах байранд ажиглагч томилох эрхтэй. СЕХ нийт олон улсын 259 ажиглагчид үнэмлэх олгосон бөгөөд иргэний нийгмийн 300, улс төрийн намын 29000 ажиглагчид сонгуулийн хэсгийн хороонд ажиглалт хийхээр бүртгэгдсэн талаар мэдээлсэн. Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн эвсэл сонгогчдын бүртгэл, сонгуулийн сурталчилгаа, зардал болон сонгуулийн технологийн хэрэглээ зэргийг ажиглав. Сонгуулийн өдөр, тус иргэний нийгмийн эвслээс 300 ажиглагчийг Улаанбаатар хот болон 12 аймагт илгээсэн байна.

Сонгуулийн өдөр үндсэндээ нам гүм, эмх цэгцтэй байсан бөгөөд санал хураах үйл явц том зургаараа журмын дагуу явагдсан боловч санал авах байрны зохион байгуулалт зохистой бус, санал тоолох төхөөрөмжийг буруу байрлуулсан, зарим тохиолдолд санал авах байранд хэт ачаалал үүссэн зэрэг нь сонгогчийн нууцлалт сөрөг нөлөө үзүүлээ. СЕХ ирцийн мэдээллийг өдрийн туршид үзүүлж, санал өгөх хугацаа дуусмагц, сонгуулийн үр дүнг дамжуулж эхэлсэн нь сонгуулийн ил тод байдалд чухал хувь нэмэр оруулсан. Санал хураалт дууссаны дараагаас албан ёсны үр дүн автомат төхөөрөмжөөр тоологдон СЕХ-ны төв сервер рүү дамжуулагдсан. Санал хураалт хаагдах, хяналтын тооллого хийх үйл явц хэд хэдэн сонгуулийн хэсгийн хороонд зохих журам бүрэн мөрдөгдөөгүй нь ОУСАХ-ны ажиглагчид тус үйл явцад сөрөг үнэлгээ өгөхөд хүргэсэн юм.

УРЬДЧИЛСАН ҮР ДҮН



ҮНДЭСЛЭЛ, УЛС ТӨРИЙН БАЙДАЛ

2023 оны 5-р сард Үндсэн Хуульд томоохон нэмэлт өөрчлөлт оруулсны дараа 2023 оны 12-р сарын 28-ны өдөр УИХ-ын сонгуулийн тов зарлагдсан. Уг нэмэлт өөрчлөлтөөр, парламентын бүрэлдэхүүнийг нэмэгдүүлж, парламентыг илүү хүчирхэг, олон талт болгох зорилгоор сонгуулийн холимог тогтолцоог хэрэглэх болжээ¹.

Эрх баригч Монгол Ардын Нам (МАН) сүүлийн найман

жилийн хугацаанд улс төрийн тавцанд ноёрхож, мөн сүүлийн хоёр удаагийн УИХ-ын сонгуулиар үнэмлэхүй олонхыг бүрдүүлж, улмаар 2021 оны Ерөнхийлөгчийн² сонгуулиар ялалт байгуулж, эрх мэдлээ улам бататгасан. УИХ-д суудалтай хоёр дахь том нам Ардчилсан Нам (АН) сүүлийн жилүүдэд дотоодын ноцтой хагаралтай тулж, энэ нь зарим талаар сонгууль хүртэл үргэлжилжээ.

Сүүлийн жилүүдэд авлига нь олон нийтийн дунд өрнөсөн хамгийн том сэдвүүдийн нэг байсан бөгөөд зарим өндөр албан тушаалтнууд холбогдсон талаар хэд хэдэн нэхэмжлэл гарчээ³. 2022 оны 4-р сард авлига, Засгийн газрын үр дүнгүй байдлыг эсэргүүцсэн жагсаал болов. 2022 оны 12-р сард нүүрсний экспортыг тойрсон авлигын схемийг эсэргүүцсэн илүү том хэмжээний жагсаал болжээ. Үүний хариуд эрх баригчид УИХ-ын хянан шалгах хороог байгуулж, хэд хэдэн өндөр албан тушаалтан, УИХ-ын гишүүдийг баривчилж, эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж авлигын хэргийн ялын бодлогыг чангатгажээ.

2023, 2024 онд өвөлжилт хүндэрч зуд болсон нь орон нутгийн малчин иргэд болон нийслэлийн эдийн засаг, дэд бүтцийн хувьд харьцангуй сул хэсгийн иргэдэд ихээхэн хүнд байдал учруулав. 2024 оны 4-р сард мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор УИХ нэн яаралтайгаар хэлэлцэн шинэ хууль тогтоомж баталсан. Хууль батлах ердийн журмыг тойрсон, эрх баригч намын ухуулагчид шинэ хууль тогтоомжийг ашиглан улс төрийн намаа сурталчилж буйг АИХЭГ-ын Сонгууль Ажиглах Хорооны (САХ) маш олон ярилцагчид шүүмжилсэн юм.

Оролцогч талууд шүүхийн бие даасан байдал, сэтгүүлчдэд учрах дарамтын талаар санаа зовнисон хэвээр байна.⁴ Иргэний нийгмийн байгууллагууд хязгаарлагдмал санхүүгийн болон хүний нөөц, төрийн дэмжлэг хангалтгүй, хүнд суртлаас үүдэх саад, нийтийн оролцоо сул зэрэг олон сорилттой орчинд яаж ийгээд үйл ажиллагаа явуулж байна.⁵

Ялгаварлан гадуурхалтын эсрэг хуулийн заалтууд бий хэдий ч, улс төрийн амьдралд, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй хэвээр байна. Бүрэн эрх нь дуусаж буй УИХ-д 13 эмэгтэй гишүүн (17 хувь), 22 сайдын ердөө 3 нь эмэгтэй (14 хувь), 22 засаг даргын ердөө 1 нь эмэгтэй байна. ОУСАХ-ны ярилцагчдын дийлэнхийн үзэж буйгаар жендэрийн хэвшмэл ойлголт, хязгаарлагдмал нөөц

2 2020 оны УИХ-ын сонгуульд МАН 62 суудал, АН 11 суудал, "Та бидний эвсэл", "Зөв хүн электорат эвсэл", бие даан нэр дэвшигч тус бүр нэг суудал авсан. 22 сайд бүгд, 21 Засаг даргын 14 нь МАН-аас томилогдсон.

3 2023 оны 5-р сард болсон боловсролын зээлийн сан, 2023 оны 6-р сард Улаанбаатар хотын нийтийн тээврийн 1000 автобус худалдан авалтын санхүүг буруу зарцуулсан, 2024 оны 3-р сард АНУ-ын Хууль зүйн яамнаас, ерөнхий сайд асан, УИХ-ын гишүүн Сүхбаатарын Батболд 14 сая ам доллартой (ойролцоогоор 12.9 сая евро) тэнцэх төрийн мөнгөөр Нью-Йоркт худалдаж авсан орон сууцыг хураан авах талаарх мэдэгдэл зэрэг хамаарна.

4 2023 оны Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал эрхэлсэн тусгай илтгэгчийн урьдчилсан ажиглалт; 2023 оны Дэлхийн эрх чөлөөний тайлан; Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комиссын Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний 23 дахь тайлан; Глоб Интернэшнл төвийн Монгол Улсын Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2022-2023, зэргийг үзнэ үү.

5 Өсөж, өндийж буй иргэний нийгмийн салбарыг хамгаалахын тулд эрх зүйн орчныг уялдуулах, бэхжүүлэх шаардлагатай байгаа талаар зарим оролцогч талууд мэдээлсэн.

1 Үндсэн Хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр УИХ-ын гишүүдийн тоог 76-126 болгож, сонгуулийн цэвэр мажоритар тогтолцооноос холимог тогтолцоонд шилжүүлэв.

бололцоо зэрэг нь эмэгтэйчүүдийг улс төрийн амьдралд ороход саад болдог аж.

ОУСАХ-ны уулзсан хүмүүсийг оруулаад хэд хэдэн сонгуулийн оролцогч талууд залуучуудын улс төрийн хангалтгүй оролцоо санаа зовох асуудал хэмээн тодорхойлов.⁶ Залуу сонгогчдын дунд улс төрийн намуудад сэтгэл дундуур байдал ихсэж буй хэдий ч, ардчилсан тогтолцоонд итгэх хандлага эерэг хэвээр байна. Монгол Улс улс төрийн болон иргэний оролцоогоор өндөр байр суурь эзэлдгийг тэмдэглэх нь зүйтэй.⁷



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

Монгол Улс нь ардчилсан сонгууль зохион байгуулахтай холбоотой томоохон олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон.⁸ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль, эрх зүйн орчин нь 1992 оны Үндсэн хууль, 2019 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай (МУИХСтХ), 2006 оны Сонгуулийн төв байгууллагын тухай, 2011 оны Сонгуулийн автоматжуулсан системийн тухай (дээрх хуулиудад 2023 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) болон 2023 онд шинэчлэн найруулсан Улс төрийн намын тухай хуулиас бүрдэж байна.⁹ Хууль, эрх зүйн орчин нь ардчилсан сонгууль явуулахад хангалттай бүрдсэн хэдий ч үндсэн эрх, эрх чөлөөг эдлүүлэхтэй холбоотой орчныг цаашид сайжруулах шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд сүүлд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь сонгуулийн тогтолцоог өөрчилсөн Үндсэн хуулийн өөрчлөлтийг гол төлөв тусгасан байна. Мөн сонгууль товлон зарласнаас хойш байгуулагдсан намуудад нэр дэвшүүлэх боломжийг олгосон, нэр дэвшигчдийн хүйсийн квотыг өсгөсөн эерэг өөрчлөлтүүд орсон хэдий ч сонгох эрх болон үг хэлэх эрх



чөлөөг хязгаарласан, үүний зэрэгцээ хуулийн цоорхой, тодорхой бус зохицуулалтууд хууль, эрх зүйн орчны хувьд байсаар байна.¹⁰ АИХЭГаас удаа дараа өгсөн зөвлөмжүүд орхигдсон хэвээр байна. Үүнд сонгох эрх, үг хэлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хязгаарлалт, сонгуулийн хэрэг маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх хугацаатай холбоотой өгсөн зөвлөмжүүд багтана.

2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар нийт сонгогчийн нэг ба түүнээс дээш хувийн санал авсан намд төрийн санхүүжилт олгохоор заасан зэрэг хэд хэдэн өөрчлөлтүүдийг тусгасан байна.¹¹ Хуулиар намын удирдах байгууллагууд, бодлого, үйл ажиллагаандаа хүйсийн болон нийгмийн олон бүлгийн төлөөллийг оролцуулах шаардлага тавьж байна. Мөн МУИХСтХуульд заасан хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй нэр дэвшигчдийн тоонд санхүүгийн урамшуулал олгохоор хуульчилсан нь сайшаалтай боловч улс төрийн намын бүтэц, дотоод зохион байгуулалтыг хэтэрхий нарийн зохицуулсан, мөн намын гишүүнчлэлд хязгаарлалт тавьсан байгаа нь олон улсын стандартад төдийлөн нийцэхгүй, эвлэлдэн нэгдэх

6 Монголын залуучууд (18-35 насны) нийт хүн амын 28 хувийг эзэлж байна.

7 2023 оны байдлаар Дэлхийн Залуучуудын Хөгжлийн Индексээр 183 орноос Монгол Улс 24-т эрэмбэлэгджээ. Мөн 2022 оны Судалгаа, Шинжилгээний Инсайт төвийн судалгааг үзнэ үү.

8 Үүнд, 1966 оны Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1979 оны Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, 1965 оны Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, 2003 оны Авлигын эсрэг НҮБ-ын конвенц болон 2006 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц багтана.

9 Үүнд 2015 оны Эрүүгийн хууль, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 оны Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 оны Зөрчлийн тухай хууль, 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хууль, 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон 2006 оны Авлигын эсрэг хууль мөн багтана.

10 Тухайлбал, хяналтын тооллогоор саналын тоо нь зөрүүтэй гарвал хэрхэх талаар зохицуулсан журмыг хуульд тусгаагүй.

11 Төрийн санхүүжилтийн 50 хувиас доошгүй хувийг эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийг чадавхжуулахад болон намын гишүүд, иргэдийн боловсрол, түүнчлэн бодлого боловсруулах зориулалтаар зарцуулах ёстой.



боломжийг хязгаарлаж байна.¹² Түүнчлэн уг хуульд Улсын Дээд Шүүхээс улс төрийн намыг бүртгэхээс татгалзсан тохиолдолд зөрчигдсөн эрхийг сэргээх журмыг тусгаагүй байна.¹³

Улсын Их Хурлын 78 гишүүнийг сонгуулийн 13 тойргоос олныг төлөөлөх мажоритар аргаар, үлдсэн 48 гишүүнийг Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн нэг тойргоос хувь тэнцүүлэн төлөөлөх пропорционал аргаар сонгоно.¹⁴ Сонгуулийн тойрог бүрд УИХ-ын гишүүдийг сонгогчид тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тоогоор олон нэр дэвшигчдийг сонгох системээр сонгоно. Сонгуулийн тойрог байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолд шалгуур үзүүлэлтийн талаар дурдаагүй боловч МУИХСтХуульд

12 1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн 7.6 дугаар хэсэгт гишүүн улсууд "сонгуульд оролцогчдыг хууль болон эрх бүхий байгууллагуудын өмнө эрх тэгш өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн баталгаагаар хангана" гэж заасан байдаг. "Мөн Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 22 дугаар зүйл, АИХЭГ болон Венецийн Комиссын Улс төрийн намын тухай хуулийн төсөлд өгсөн хамтарсан дүгнэлтийг харна уу.

13 2020 оны АИХЭГ болон Улс төрийн намын зохицуулалтын тухай Венецийн комиссын удирдамжийн 151- 155 дэх хэсэгт: "Улс төрийн намууд дотоод үйл ажиллагаагаа хамтран боловсруулж, санал нэгдэн баталсан намын дүрэм эсвэл сайн дурын ёс зүйн дүрмээрээ зохицуулах нь хамгийн тохиромжтой байдаг. Төрийн хяналт улс төрийн намд хамгийн бага түвшинд байх ёстой бөгөөд ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай хяналтаар л хязгаарлагдах ёстой. Дүгнэж хэлэхэд, гишүүнчлэл, намын хуралдаан, уулзалтын тоо, давтамж, орон нутаг дахь салбар нэгжүүдийн үйл ажиллагаа зэрэг улс төрийн намын үйл ажиллагаанд улс төрийн болон төрийн хяналт хэт их тавихаас зайлсхийх хэрэгтэй."

14 Мажоритар сонгуулийн тойргийн тоо нь 29-өөс 13 болж багассан

сонгуулийн тойргийг байгуулахдаа хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан байгуулахаар заасан. Арван гурван сонгуулийн тойргийн арван нэгийнх нь сонгогчдын тоо сонгогчдын дундаж тооны хязгаараас 15 хувиар хэтэрсэн байгаа ба үүнээс Улаанбаатар хотын 4 тойрог 50 хувиар хэтэрсэн үзүүлэлттэй байгаа нь саналын эрх тэгш байдлын талаарх олон улсын сайн туршлага болон АИХЭГ-аас өгсөн зөвлөмжөөс зөрж байна.¹⁵



СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

Сонгуулийг дөрвөн шат бүхий сонгуулийн байгууллага зохион байгуулна. Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ) нь байнгын ажиллагаатай, 9 гишүүнээс бүрдэх байгууллага бөгөөд ердөө нэг эмэгтэй гишүүнтэй. УИХ 5 гишүүнийг, Ерөнхийлөгч, Улсын дээд шүүх тус бүр 2 гишүүнийг санал болгосноор УИХ бүх гишүүдийг 6 жилийн хугацаагаар томилно.¹⁶ СЕХ доод шатны сонгуулийн хороодыг томилох, нэр дэвшигчдийг бүртгэх, сонгуулийн бэлтгэл хангах, сонгуулийн үр дүнг гаргах, санал тоолох автоматжуулсан системийн хэвийн ажиллагааг хангах, хэрэгжүүлэх гэх мэт сонгууль зохион байгуулахтай холбоотой өргөн хүрээний үүрэг хүлээдэг. Ерөнхийдөө СЕХ хуулийн хугацаанд нийцүүлж, мэргэжлийн байдлаар ажилладаг.

СЕХ аймаг, нийслэлийн сонгуулийн 22 хороо (АНСХ), сум, дүүргийн сонгуулийн 339 хороо (СДСХ) байгуулжээ.¹⁷ Сонгуулийн хэсгийн 2198 хороог (СХХ) 5-р сарын 14-ний дотор байгуулах ажил СЕХ-ны цахим систем нэвтрүүлэх ажлаас болж хойшилсон боловч, тэдний ажилд нөлөөлөөгүй юм.¹⁸ СДСХ, СХХ-ны түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл сайтар хангагдаж нийт албан хаагчдын 76 хувийг эзэлж буй бол АНСХ-ны түвшинд ердөө 9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. СХХ-ны гишүүд цахим сургалтыг дүүргэж, гэрчилгээ авсан байх ёстой. СДСХ СХХ-нд зориулж нэмэлтээр танхимын сургалт зохион байгуулсан нь үндсэндээ сонгуулийн өдрийн үйл явцад голлон анхаарсан байна.

15 2002 оны Венецийн комиссын Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын дүрмийн I.2.2.iv дэх хэсэгт "тогтоосон нормоос 10 хувь, онцгой тохиолдлоос бусад нөхцөлд тогтоосон нормоос 15 хувиас огт хэтрэхгүй хэмжээгээр зөрүүтэй байх"-ыг зөвлөдөг.

16 СЕХ-ны гишүүд төрийн албан хаагчид бөгөөд, улс төрийн намын гишүүд биш. СЕХ-ны одоогийн гишүүд 2020 онд томилогдсон бөгөөд, 2024 оны 1 сард чөлөөлөгдсөний 2 хүнийг нөхөн томилсон.

17 ГХЯ-ны дэргэд гадаадад оршин суугаа иргэдийн санал авахаар тусдаа комисс байгуулж, 37 улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт, 47 сонгуулийн хэсгийн хороо байгуулагдсан. Гадаадад суугаа сонгогчид зөвхөн пропорциональ өрсөлдөөнд санал өгсөн.

18 Тус системийг сонгууль зохион байгуулах албан хаагчдыг бүртгэх, цахим сургалт, сертификат олгох болон нэр дэвшигчид, иргэний нийгмийн ажиглагчдыг бүртгэхэд ашиглав.

ОУСАХ-ны дийлэнх ярилцагчид сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаанд итгэлтэй байгаагаа илэрхийлж, ил тод, алагчлахгүй ажиллагчийг онцлон тэмдэглэв. СЕХ гаргасан шийдвэр, журмуудаа өөрсдийн цахим хуудсанд байршуулж, сонгогчдын боловсрол, мэдээлэл өгөх материалуудыг хуваалцдаг.¹⁹ Гэсэн хэдий ч, СЕХ-ны болон доод шатны сонгуулийн хороодын хуралдаан олон нийтэд зарлагдаагүй. СЕХ-ны хурлын тэмдэглэл нийтэд нээлттэй боловч, доод шатны сонгуулийн хороодын хурлын тэмдэглэл нийтэл ил болсонгүй. САХ байгуулагдсанаас хойш СЕХ 6-р сарын 5-ны өдөр нэг л удаа хуралдсан бөгөөд АИХЭГ-ын САХ уригдсан юм.²⁰ ОУСАХ-ны ажиглагчид доод шатны сонгуулийн хороодын хуралдааны талаар бараг л мэдээлэл аваагүй бөгөөд, цөөн удаа хуралдаанд урихдаа цаг тулгасан урилга илгээж байлаа.

СЕХ пропорциональ, мажоритар хэсэгт ашиглах хоёр тусдаа саналын хуудас үйлдвэрлэв. Санал авах байр бүрд санал унших, тоолох, хадгалах цахим төхөөрөмжийг байрлуулсан бөгөөд, 1700- аас дээш сонгогчтой санал авах байранд дараалал үүсэхээс сэргийлж хоёр төхөөрөмж байршуулсан байна. Төхөөрөмжөөр санал тоолох үйл явцад итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд

УИХ-ын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж бүх санал авах байранд хяналтын тооллого зохион байгуулах болсон нь өмнө нь 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд хэрэгжиж байсан юм. Хуульд төхөөрөмжөөр тоолсон дүнг албан ёсны гэж заасан бөгөөд хэрэв гараар болон төхөөрөмжөөр тоолсон дүн зөрөх тохиолдолд зөрүүг хэрхэн зохицуулах, гар тооллогын үйл явцыг нарийвчлан зохицуулаагүй байна.

Зарим оролцогч талууд санал тоолох цахим төхөөрөмжийн талаар эргэлзээ буйг ОУСАХ-нд уламжилж байсан хэдий ч, өмнөх болон энэ сонгуулийн албан ёсны дүнг хэрхэн хуурамчаар үйлдэж болзошгүй талаар хангалттай тайлбарлах, нотлох баримт үзүүлж чадаагүй юм. Эдгээр эргэлзээг тайлахын тулд СЕХ-ны 6-р сарын 21-ний өдөр улс төрийн нам, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нэр дэвшигчид, ажиглагчид зэрэг оролцогч талуудын оролцоотойгоор санамсаргүй сонгосон санал тоолох төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг баталгаажуулах туршилтыг хийсэн. АИХЭГ автоматжуулсан санал тоолох төхөөрөмжийн аюулгүй, үнэн зөв байдлын талаарх эргэлзээг тайлахад өмнө нь зөвлөмж²¹ гаргаж байсан хэдий ч, хуульд төхөөрөмжийг хараат бусаар баталгаажуулах, гэрчилгээжүүлэх талаар туссангүй.

СЕХ сонгуулийн өдрийн үйл ажиллагаа, сонгуулийн тогтолцоо, саналын хуудсыг хэрхэн зөв бөглөх зэргийг тайлбарласан сонгогчдод мэдээлэл өгөх иж бүрэн кампанит

ажил хэрэгжүүлсэн. СЕХ санал өгөхтэй холбоотой үйл явцыг тайлбарласан, сонгогчдод зориулсан мэдээлэл бүхий тараах материал боловсруулж өрх бүрд түгээжээ. Мөн, АНСХ, СДСХ, СХХ-ноос сонгуулийн өдрийн үйл явцыг идэвх, санаачилгатай үзүүлж, АНСХ нийгмийн сүлжээ, цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан орон нутгийн телевизүүдтэй хамтран ажилласан. 6-р сарын 24- ний өдөр СХХ-дод санал тоолох цахим төхөөрөмжийн хэвийн ажиллагааны шалгалт амжилттай болов. Түүнчлэн, зарим АНСХ орон нутгийн ИНБ-уудтай хамтран ажиллаж эмэгтэй сонгогч, залуу сонгогчдод зориулсан мэдээлэл түгээж ажилласан.²²

Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдыг хараат бусаар саналаа өгөх боломжоор хангахын тулд СЕХ сонгуулийн тойрог бүрд аль аль саналын хуудсанд зориулсан брайль үсэг бүхий хавтас үйлдвэрлэж, санал авах байр бүрд томруулдаг шил байрлуулж, тэргэнцэртэй иргэн орох боломжоор хангасан талаар ОУСАХ-нд мэдэгдсэн. Дохионы хэлмэрч бүхий сонгогчдод мэдээлэл өгөх дүрс бичлэг олон нийтийн болон хувийн телевизээр дамжуулагдаж, СЕХ-ны цахим хуудас, нийгмийн сүлжээгээр цацагдаж байлаа.



СОНГОГЧДЫН БҮРТГЭЛ

Шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүй болсон, үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөнөөс үл хамааран шоронд ял эдэлж байгаа иргэдээс бусад 18 насанд хүрсэн иргэн бүр сонгох эрх эдэлнэ. Сонгох эрхийн эдгээр хязгаарлалтууд олон улсын өмнө хүлээсэн үүрэг АИХЭГ-ын өмнөх зөвлөмжүүдтэй харшилдаг.²³

Сонгогчдын нэрийн жагсаалтыг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас (УБЕГ) байнга шинэчилдэг үндэсний хүн амын өгөгдлийн сангаас гаргаж авдаг. Санал өгөх үед сонгогчдын цээж зураг, хурууны хээ зэрэг биеийн давхцахгүй өгөгдөл ашиглан сонгогчийг баталгаажуулна.²⁴ УИХ-ын сонгуулийн тухай хуульд сүүлд оруулсан нэмэлт,

22 Говь-Алтай, Өвөрхангай, Ховд, Увс, Дархан-Уул аймгийн сонгуулийн хороонд ажиглагдсан.

23 ЕАБХАБ-ын 1990 оны ЕАБХАБ-ын Копенхагены Баримт Бичгийн 7.3-т оролцогч улсуудыг "насанд хүрсэн иргэдэд бүх нийтийн, тэгш сонгох эрхийг хангахыг" уриалж, 24-р зүйлд, эрх, эрх чөлөөнд хязгаарлалт хийж байгаа бол "хуулийн зорилгод хатуу нийцэх ёстой" гэжээ. 2006 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын (ХБХЭТК) 12-р зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэд хуулийн өмнө ижил тэгш эрхтэйг хүлээн зөвшөөрөх тухай заасан байдаг. 29-р зүйлд, Улс орнууд "хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн эрхийг хүлээн зөвшөөрч, бусадтай адил тэгш эдлэх боломжоор хангахыг" шаарддаг. ХБХЭТК-ын 12-р зүйлийн нэг дэх хэсэгт 2022 онд өгсөн Ерөнхий санал, зөвлөмжийн 48-р догол мөрд "хүний шийдвэр гаргах чадамжид хөгжлийн бэрхшээлд нь үндэслэн саад болохыг зөвтгөх, сонгох, болон сонгогдох эрхээ хэрэгжүүлэхээс хасах үндэслэл болохгүй" гэжээ.

24 Энэ хоёрын дунд зөрүү үүссэн тохиолдолд сонгогч санал өгөх эрхгүй.

19 СЕХ-ны цахим хуудас харааны бэрхшээлтэй иргэд ашиглах боломжтой.

20 СЕХ зөвхөн албан ёсны шийдвэр гаргахын тулд ээлжит бус хуралдаан хийдэг бөгөөд үйл ажиллагааныхаа мэдээллийг хэвлэлээр мэдээлдэг.

21 Цахим санал хураалтын стандартын талаар гишүүн орнуудын сайд нарын хорооноос 2017 онд гаргасан зөвлөмжийн 33 дугаар догол мөрд "баталгаажуулах, гэрчилгээжүүлэхийн тулд цахим санал хураалтын системийн бүрэлдэхүүн(үүд) нээлттэй байх ёстой" гэж тодорхойлсныг үзнэ үү. Мөн, 38, 39-р догол мөрд аюулгүй байдалтай холбоотой гэрчилгээ болон бусад бичиг баримтыг аудитад нээлттэй байлгах талаар зөвлөмж гаргасан болно.


өөрчлөлтөөр санал авах байранд ашиглах сонгогч таних төхөөрөмжүүд нь УБЕГ-ын төв сервертэй холбогдсон байх ёстой. Ерөнхийдөө, ОУСАХ-ны ярилцсан хүмүүс сонгогчдын нэрийн жагсаалт бүх сонгогчийг хамруулсан гэдэгт итгэж буй боловч УБЕГ аймаг бүрд сонгогчийн дахин бүртгэл хийсэн талаар нарийвчилсан хураангуй мэдээлэл өгөхдөө хангалттай ил тод байгаагүйтэй холбоотой санаа зовнил байгааг ч илэрхийлсэн.

УБЕГ 4-р сарын 1-ний өдөр сонгогчдын нэрийн жагсаалтыг баталгаажуулж сонгогчдын нэрийн жагсаалтыг урьдчилсан байдлаар цахим хуудастаа байрлуулсан бөгөөд, 5-р сарын 28-ны өдөр 2,238,360 сонгогч буйг зарласан. Сонгогчийн нэрийн жагсаалтыг эцсийн байдлаар 6-р сарын 25-ны өдөр хэсгийн хороодод илгээв.²⁵ 2023 онд орсон хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу сонгогчид өөрсдийн мэдээллийг, оршин суугаа хаяг дээрх нийт бүртгэгдсэн сонгогчийг цахимаар шалгах боломжтой болжээ. Түүнчлэн, сонгогчийн бүртгэлийн өгөгдөл, мэдээллийг 6-р сарын 3-25-ны өдрүүдэд хэсгийн хороонд баталгаажуулах, зөрүүтэй мэдээллийг санал хураах өдрөөс 14 хоногийн өмнө засуулах боломжтой. Сонгуульд өрсөлдөж буй намуудын хүсэлтээр, УБЕГ 6-р сарын 8, 25-ны өдрүүдэд сонгогчдын нэрийн жагсаалтын урьдчилсан болон эцсийн хувилбарыг электрон хэлбэрээр олгожээ.

Сонгогч аль хэсгийн хороонд харьяалагдах нь сонгогчийн оршин суугаа хаягт үндэслэх бөгөөд сонгогч хаягийн бүртгэлээ санал хураах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө өөрчлөх боломжтой.²⁶ ОУСАХ-ны уулзсан зарим хүмүүс өнгөрсөн хоёр жилийн хугацаанд сонгуульд нэр дэвшиж буй зарим ажил олгогч өөрийн ажилчдаа дэвшиж буй тойрог руугаа шилжүүлж, саналыг нь авахын тулд тасралтгүй шахаж байсан талаар мэдээлэв. УБЕГ-аас өнгөрсөн саруудад 70,000 иргэний шилжих хөдөлгөөн бүртгэгдсэнээс дийлэнх нь Улаанбаатарт буй талаар мэдэгдэв.²⁷ Зарим улс төрийн намууд сонгогчдын дахин бүртгэлийн тоон задаргааг авах хүсэлт гаргасан боловч УБЕГ-аас тус мэдээллийг өгөхөөс татгалзсан нь сонгогчдын нэрийн жагсаалтын ил тод байдлыг хязгаарлаж байна.

АИХЭГ-ын САХ-ны хэд хэдэн ярилцагч сонгуулийн өдөр зарим бүлэгт хамаарах хүмүүс санал өгөх боломжтой эсэхэд санаа зовниж буйгаа илэрхийлсэн бөгөөд, ялангуяа уурхайн талбар дээр ажилладаг хүмүүс болон сонгуулийн оролцогч талууд СЕХ-нд тэдгээр иргэдийн санал авах байр руу хүргэх гэх мэт санал өгөх боломжоор хангах зохицуулалт хийж өгөх талаар хүсэлт тавьжээ. Ажил олгогчид ажилчдаа санал өгөх боломжоор хангах хуулийн үүрэгтэй.²⁸

- 25 Энэ удаагийн сонгуульд гадаадад оршин суугаа 13095 сонгогч сонгуульд оролцохоор бүртгүүлжээ.
- 26 Сонгуулийн өдөр ажиллах сонгуулийн болон цагдаагийн албан хаагчид, улсын бүртгэгч нар, мэдээлэл, технологийн ажилтнууд өөрсдийн ажиллах хэсгийн хороонд санал өгөх хүсэлтээ сонгуулийн санал авах өдрөөс 14 хоногийн өмнө гаргаж болно.
- 27 2024 оны 1-р сарын 1-ний өдрөөс 4-р сарын 29-ний өдрийн хооронд нийслэлийн хэмжээнд 42570 хүн, нийслэлээс аймгууд руу 9420 хүн, аймгаас нийслэл рүү 11389 хүн, аймгаас аймгийн хооронд 6512 хүн хаягаа шилжүүлжээ.
- 28 Биелүүлээгүй тохиолдолд иргэнийг 10000 төгрөг (ойролцоогоор 2.7 евро) хуулийн этгээдийг 100,000 төгрөгөөр (ойролцоогоор 27.4 евро) тус тус торгоно.



НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ

Сонгуулийн эрх бүхий 25 нас хүрсэн сонгогч нэр дэвшиж болно. Зохисгүй зарим хязгаарлалтын сонгуулийн хуулиас хассан ч, нэр дэвших эрхийг хязгаарласан заалтууд байсаар байна. Шүүхээр тогтоосон өр, татварын хугацаа хэтэрсэн өр, эсвэл нэр дэвшигч 51-ээс дээш хувийг нь эзэмшдэг компани хугацаа хэтэрсэн өр төлбөртэй бол нэр дэвших боломжгүй. Ял эдэлж буй болон авлига, албан тушаалын хэрэг үйлдэж байсан хүн мөн нэр дэвших боломжгүй. Түүнчлэн, төрийн болон орон нутгийн өмчит болон оролцоот хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал гэх мэт зарим ангиллын төрийн албан хаагчид сонгуулийн жилийн 1-р сарын 1-ний өдрөөс өмнө ажлаа өгөх ёстой. Эдгээр хязгаарлалтууд сонгогдох эрхийн талаар олон улсын стандарт, ЕАБХАБ-ын үүрэг амлалттай нийцэхгүй байна.²⁹

Албан ёсоор бүртгэгдэхийн тулд улс төрийн нам 801-ээс багагүй үүсгэн байгуулагчийн дэмжлэгийг авах, мөн намын дүрэм, эд хөрөнгийн жагсаалт зэрэг баримт бичгийн хамт Улсын Дээд Шүүхэд бүртгүүлэхийг хууль шаарддаг. Гэсэн хэдий ч, Улсын Дээд шүүх ОУСАХ-нд яг 801-тэй тэнцүү тооны гишүүн байх бодлоготой талаар мэдэгдсэн.³⁰ Энэ практик нь хуулийг эсрэг тайлбарлаж буй бөгөөд эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлаж байна.

Улс төрийн нам, эвслүүд сонгуульд оролцох сонирхлоо сонгуулийн өдрөөс 60-аас доошгүй өдрийн өмнө СЕХ-нд мэдэгдэх ёстой. Түүнчлэн, бүх өрсөлдөгчид сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлого³¹, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай, санхүүгийн санал нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуультай нийцэж буй эсэхийг шалгуулахаар Үндэсний Аудитын Газарт (ҮАГ) илгээх ёстой. ҮАГ өрсөлдөгч бүрд мөрийн хөтөлбөр нь хуульд нийцэж буй эсэх мэдэгдлийг сонгуулийн өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, өрсөлдөгчид СЕХ-нд ирүүлнэ.

Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн улс төрийн нам, эвслүүд 5-р сарын 14-ний өдрөөс эхлэн 7 хоногийн турш нэр

- 29 ИБУТЭОУП-ын 25-р зүйлд НҮБ-ын Хүний Эрхийн Комиссоос гаргасан ерөнхий санал, зөвлөмжийн 15-р догол мөрд "Сонгуульд нэр дэвших боломжтой хүмүүсийг боловсрол, оршин суугаа газар, удам угсаа, улс төрийн харьяалаар нь ялгаварлан гадуурхаж, эсвэл ямар нэг шалтгаангүйгээр сонгуульд өрсөлдөхөөс хасах болохгүй" гэжээ. 1990 оны ЕАБХАБ-ын Копенхагены Баримт бичгийн 7.5-р догол мөрд оролцогч улс орнууд иргэдийнхээ улс төрийн болон нийтийн албан тушаал хаших эрхийг хүндэтгэх ёстой гэжээ. Түүнчлэн, 24-р догол мөрд эрх, эрх чөлөөнд тавьж буй аливаа хязгаарлалт нь "хуулийн зорилготой хатуу нийцэж байх ёстой" гэжээ.
- 30 Хэрэв жагсаалтад 801-ээс илүү тооны нэр байвал, багасгахаар буцаагдана. Түүнчлэн, бүх хүний мэдээллийг шалгах бөгөөд, нэг л зөрүү гарвал засахаар буцаагддаг байна.
- 31 Алсын хараа 2050 гэх Засгийн газрын урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг үзнэ үү.

дэвшүүлэх ажиллагааг явуулна. Бие даан нэр дэвшигчид энэ хугацаанд нэрээ дэвшүүлэх эрхтэй бөгөөд нэр дэвшигчээр бүртгэгдэхийн тулд 801-ээс доошгүй гарын үсэг цуглуулна. Улс төрийн намаас нэр дэвшиж буй нийт нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байх бөгөөд, пропорциональ намын жагсаалтад хүйсийн харьцаа сөөлжсөн байх хуулийн шаардлагатай. Пропорциональ жагсаалтад жендэрийн тэнцвэртэй байдлыг хангасан нь ерөнхийдөө эерэг өөрчлөлт боловч, улс төрийн намууд мажоритар хэсэгт эмэгтэйчүүдээс илүү олон эрэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх боломж олгож байна.³²

Улс төрийн нам, эвслүүд тухайн тойргийн мандаттай тэнцүү тооны хүртэлх хүнийг нэр дэвшүүлж; нэг нэр дэвшигч мажоритар сонгуулийн тойрогт, эсвэл пропорциональ намын жагсаалтын аль нэгд нь нэр дэвшин болно. 6-р сарын 10-ны өдөр, СЕХ-ноос улс төрийн 19 нам, 2 эвсэл, нийт 1336 нэр дэвшигч (817 эрэгтэй, 519 эмэгтэй) мажоритар болон пропорциональ өрсөлдөөнд бүртгэсэн талаар мэдээлсэн. Бие даан нэр дэвшигч 42 хүн мажоритар өрсөлдөөнд бүртгэгджээ. 11 нэр дэвшигч бүртгэлийн шалгуурыг хангаагүй тул төрөл бүрийн шалтгаанаар бүртгэхээс татгалзсан байна.³³ Үүнээс, 5 хүн шүүхэд хандаж, шүүхийн шийдвэрээр нэр дэвшигчээр бүртгэгдсэн. СЕХ нэр дэвшигчдийг бүртгэхдээ хуулийг баримталж, шаардлагатай материалаа засах хугацааг олгож байсан хэдий ч нэр дэвшигчдэд тавигдах хэт их шаардлага нь сонгогдох эрхийг бүх нийтэд эдлүүлэхэд эргэлзээ төрүүлж байна.

Эрх зүйн орчин дахь саяхны нэмэлт, өөрчлөлтүүд улс төрийн нам хөгжлийн бэрхшээлтэй иргэн нэр дэвшүүлбэл санхүүгийн хөшүүрэг олгох байдлаар тэднийг дэмжжээ. Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбооны хэлснээр, мажоритар өрсөлдөөнд 1, пропорциональ өрсөлдөөнд 3, хөгжлийн бэрхшээлтэй нийт 4 иргэн нэр дэвшигчээр бүртгэгджээ. зохицуулжээ. ашиглаж улс төрийн нам нэр дэвшигчдээ тодруулахад хөгжлийн бэрхшээлтэй.



КАМПАНИТ АЖЛЫН ОРЧИН

Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор 6-р сарын 10-ны өдөр буюу сонгуулийн өдрөөс 18 хоногийн өмнө эхэлж, 24 цагийн өмнө дууссан. Хуульд нэр дэвшиж буй УИХ-ын гишүүн энэ хугацаанаас өмнө өөрсдийгөө сурталчлахыг зөвшөөрчээ. Уулзаж ярилцсан маш олон хүн УИХ-ын

гишүүд, Засгийн газрын өндөр албан тушаалтнууд сонгууль болохоос өмнө хэдэн сарын турш идэвхтэй кампанит ажил явуулж байсан талаар мэдэгдсэн юм. Ерөнхийдөө маш богино сурталчилгааны хугацаанд, шинээр байгуулагдсан том хэмжээний сонгуулийн тойргуудад кампанит ажил явуулахад бэхэжсэн улс төрийн намуудад ихээхэн давуу талтай байсан.

Кампанит ажлыг ихээхэн зохицуулсан шинжтэй, сонгуулийн хэсэг бүрд ашиглаж болох тээврийн хэрэгсэл, ухуулах байр, ухуулагчдын тоо зэргийг хязгаарласан. Мөн сонгууль өгөхгүй байхыг уриалах, сонгуулийн жил эхэлснээс сонгууль дуустал улс төрийн чансаа тогтоох олон нийтийн санаа бодлын судалгаа нийтлэхийг хуулиар хоригложээ. Өрсөлдөгчдийн мөрийн хөтөлбөр нь засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлого, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцэх ёстой. Эдгээр хязгаарлалт нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг чөлөөг зүй бусаар хязгаарлах, улс төрийн олон ургалч үзлийг боомилж буй бөгөөд ЕАБХАБ-ын үүрэг амлалт³⁴, олон улсын стандарттай зөрчилдөж байна.

Ерөнхийдөө өрсөлдөгчид чөлөөтэй, хөндлөнгийн оролцоогүйгээр кампанит ажлаа явуулсан хэдий ч, кампанит ажил тоглох тэгш бололцоогоор дутагдаж байв.³⁵ Кампанит ажил ерөнхийдөө нам гүм өрнөсөн ч, 6-р сарын 15-ны өдөр МАН-ын нэр дэвшигч, Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаярын сонгуулийн ухуулагч Ардчилсан намын сумын намын хорооны даргатай муудсанаас амиа алдсан харамсалтай хэрэг гарлаа. Ардчилсан нам тус аллагыг улс төрийн сэдэлтэй хэмээн буруутгаж, Ерөнхий сайд, Батлан хамгаалахын сайд нарыг огцрохыг шаардсан. Үйл явдлын дараа, Ерөнхий сайд Ардчилсан намын даргатай уулзаж эмгэнэл илэрхийлсэн байна³⁶. 6-р сарын 25-ны өдөр, Үндэсний эвслийн төв байранд хууль бус сурталчилгааны ажил явагдаж байна гэх гомдлын дагуу цагдаагийн байгууллага нэгжлэг хийв.³⁷

Улс төрийн намууд аймгийн төвүүдээр томоохон кампанит ажил явуулж, улс даяар, ялангуяа зарим бүс нутагт

34 1990 оны ЕАБХАБ-ын Копенхагены Баримт бичгийн 7.7-р догол мөрд, оролцогч улс орнууд "Хууль, төрийн бодлого нь захиргааны арга хэмжээ, хүчирхийлэл, хуулиар сүрдүүлдэггүй орчинд кампанит ажил явуулж, улс төрийн нам, нэр дэвшигчид өөрсдийн үзэл бодол, чадвараа чөлөөтэй илэрхийлэх боломжоор хангагдаж, сонгогчид айх айдасгүйгээр тэдэнтэй ярилцах, судлах боломжийг олгоно" гэжээ. 2020 онд АИХЭГ, Венецийн комиссоос гаргасан "Улс төрийн намын зохицуулалт" удирдамжийн 43-р догол мөр үзнэ үү.

35 ОУСАХ-нд АН-ын өгсөн мэдээллээр 6-р сарын 2-ны өдөр тус намын пи-арын ажилтнуудыг саатуулжээ. 6-р сарын 18-ны өдөр Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн АН сонгогчид, ухуулагчдынхаа аюулгүй байдлыг хангах үүднээс кампанит ажлын арга хэмжээнүүдээ цуцлав.

36 МАН нэр дэвшигч Сайханбаярыг татах хүсэлтийг СЕХ-нд өгсөн боловч СЕХ нэр дэвшигчийг албан ёсоор татах зохицуулалт байхгүй тул тус хүсэлтээс татгалзсан.

37 6-р сарын 25-ны өдөр peguun.mn цахим хуудасны сэтгүүлч Үндэсний Эвслийн төв байранд нэвтэрч, лайв видео хийж тус эвсэл Хятад иргэдийг хөлслөн "тролл арми" ажиллуулж байна хэмээн буруутган цагдаа дуудав. Үүний дараа СЕХ-ноос Цагдаагийн Ерөнхий Газарт хэргийн газар хөдөлшгүй нотлох баримт үгүй бол СЕХ-ны зөвшөөрөлгүйгээр нэгжлэг хийх хориотой талаар албан бичиг илгээжээ. Цагдаагийн байгууллага бүртгэгдээгүй, нийгмийн сүлжээний хуурамч хаягууд сонгуулийн үйл ажиллагаа явуулж байсан гэж мэдээлсэн бөгөөд 148 хүний ердөө 2 нь л СЕХ-нд бүртгэлтэй гэжээ.

32 Хуульд мөн 2028 оны сонгуулиас нэр дэвшигчдийн хүйсийн квотыг аль нэг хүйсийн төлөөлөл 40-өөс доошгүй байхаар тусгажээ.

33 Гурван нэр дэвшигч хугацаа хэтэрсэн татварын өртэй, гурван нэр дэвшигч бичиг баримт бүрэн бус, дөрвөн нэр дэвшигч нэр дэвшүүлснээс өөр намын гишүүнчлэлтэй, нэг нэр дэвшигч 2024 оны 1-р сарын 1-ний өдрөөс өмнө албан тушаалаас чөлөөлөгдөөгүй.

айлын хаалга тогших кампанит ажил өрнүүлээ.³⁸ Жижиг улс төрийн намууд сурталчилгаа хийхдээ нийгмийн сүлжээн илүү анхаарч цомхон кампанит ажил явуулав. Өрсөлдөгчид харилцан биесээ авлигад буруутгасан төдийгүй, эдийн засгийн хөгжил, дэдбүтэц, хүрээлэн буй орчин зэрэг томоохон сэдвүүдийг ч өргөн хэмжээнд хэлэлцсэн. МАН саяхан танилцуулсан засгийн газрын хөтөлбөрүүд, тэдгээрийн амжилтыг онцолсон бол, АН үндсэндээ эрх баригч намын үр ашиггүй засаглалыг шүүмжилж, ХҮН нам, Үндэсний эвслийн хамт нийгмийн халамжийн зардлыг хязгаарлах, зах зээлийн илүү либерал эдийн засагтай болохыг уриалав. ОУСАХ-ны хэд хэдэн ярилцагч бараа бүтээгдэхүүн, бэлэн мөнгө амлах замаар сонгогчдын саналыг худалдаж авч байгаа талаар мэдээлсэн.³⁹

Нэр дэвшигчийн хувьд албан тушаалын үүргийг нэр дэвших эрхээс тусгаарласан шаардлага үгүй, мөн албан тушаалтан төрийн нөөцийг сонгуулийн кампанит ажилдаа ашиглахаас урьдчилан сэргийлсэн хангалттай зохицуулалт хуульд байхгүй байна.⁴⁰ Нийтийн албан тушаалтнууд улс даяар идэвхтэй кампанит ажил өрнүүлж байв.⁴¹ Сонгууль болохоос өмнө засгийн газар цалин нэмэх, нийгмийн халамжийг нэмэгдүүлэх, нэг удаагийн ногдол ашиг олгох зэрэг хөтөлбөр хэрэгжүүлсэн бөгөөд, эдгээрийн төрийн албан хаагчид сурталчилж, МАН-ын кампанит ажилд

- 38 АИХЭГ-ын САХ сонгуулийн сурталчилгааны 50 арга хэмжээ ажигласнаас 31-д нь эмэгтэй илтгэгч оролцуулсан байна. Эдгээр арга хэмжээний 46 нь хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байсан бөгөөд хэдийгээр хуулиар шаарддаг боловч, ердөө нэг нь дохионы хэлмэрчтэй байсан юм.
- 39 Энэ төрлийн мэдэгдэл Дорнод, Ховд, Орхон, Өмнөговь, Улаанбаатар, Завханд мөн гарсан.
- 40 Төрийн албаны тухай хуульд төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчид улс төрийн намын үйл ажиллагаанд оролцохгүй байхыг шаарддаг. Монгол Улсын Төрийн Албаны Зөвлөлөөс 6-р сарын 10-ны өдөр сонгуультай холбоотой баримтлах ёс зүйн дүрмийг баталж, төрийн албан хаагчдыг улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх, төвийг сахих, доод албан тушаалтнаа улс төрийн үйл ажиллагаанд оруулахгүй байхыг уриалсан.
- 41 АИХЭГ-ын САХ-ны ажигласнаар Өмнөговь, Өвөрхангай, Улаанбаатар, Завханд АН-ын харьяалалтай аймаг, сумын засаг дарга нар, Улаанбаатарт АН-ын харьяалалтай засаг дарга нар сонгуулийн сурталчилгаанд идэвхтэй оролцжээ.

ашиглагдаж байсан юм.⁴² Эдгээр үйлдэл нь нам, төрийн заагийг бүдгэрүүлж, эрх баригч намд хэт давуу тал олгож буй нь ЕАБХАБ-ын үүрэг амлалттай зөрчилдөж байна.⁴³

Төрийн болон нийтийн албан хаагчдыг эрх баригч намын өмнөөс сонгуулийн кампанит ажилд туслах, кампанит ажлын арга хэмжээнд оролцохыг шаардах зэргээр дарамт хэд хэд гарсан гэх мэдээлэл ирсэн.⁴⁴ Энэ талаар ОУСАХ-ны ярилцсан хүмүүс сонгогчид ямар нэг дарамт, шахалтгүйгээр, чөлөөтэй сонголт хийхэд үлэмж нөлөөлж болзошгүй талаар санаа зовниж буйгаа хэлж байлаа.⁴⁵

Цахим сурталчилгаа зөвхөн АНСХ-нд бүртгэгдсэн цахим хуудас, нийгмийн сүлжээний хаягаар явуулахаар

- 42 1-р сард Эрдэнэс Таван Толгой төрийн өмчит хувьцаат компани 2012 оноос хойш төрсөн 893432 хүүхдэд хувьцаа олгожээ. 3-р сарын 1-ний өдрөөс Улаанбаатар хотын нийтийн тээврийн жолооч нарын цалинг нэмэгдүүлсэн. 2024 оны 3-р сарын 20-ны өдөр, тэтгэврийг 100000 төгрөгөөр (ойролцоогоор 27 евро) 2024 оны 3-р сарын 27-ны өдөр төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэв. 4-р сарын 19-ний өдөр УИХ стратегийн ач холбогдолтой уул уурхайн ордоос олох орлогын 34 хувийг төвлөрүүлэх Үндэсний Баялгийн Сангийн тухай хуулийг нэн яаралтай горимоор баталсан. 2024 оны 4-р сарын 24-ний өдөр Засгийн газар малчин өрхийг дэмжихэд зориулж 5 их наяд (1,4 тэрбум евро) төгрөгийн зээлийн хөтөлбөр танилцуулсан нь, улсын төсөвт урьдчилан тусаагүй төсвийн зардал байсан юм. Тохижилт үйлчилгээний компанийн ажилчдын цалинг 6-р сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлэх гэх мэт зардлыг Улаанбаатар хотын төсөвт 2024 онд тодотгол хийж суулгав.
- 43 1990 оны ЕАБХАБ-ын Копенхагены Баримт Бичгийн 5.4 дэх догол мөрд "төр, улс төрийн намыг тодорхой зааглах" тухай заасан. Мөн 2016 оны ЕАБХАБ, Венецийн Комисстой хамтран гаргасан Сонгуулийн үйл явцад захиргааны нөөцийг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах удирдамжийн II.B.1.1. догол мөрд "нийтийн албан тушаалтнууд албан тушаалаа ашиглан сонгуулийн сурталчилгааны зорилгоор олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, шударга бусаар өөртөө давуу тал үүсгэхийг хориглох механизмыг хуулиар тодорхой зохицуулах ёстой" гэжээ.
- 44 Төрийн албан хаагчдыг дарамталж, ажлын цагаар болж буй МАН-ын сурталчилгааны арга хэмжээнд төрийн албан хаагчдыг оролцохыг шаардаж буй талаар хэд хэдэн мэдээлэл Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Улаанбаатар, Завханд буй АИХЭГ-ын САХ-ны ажиглагчдад ирсэн.
- 45 Paragraph 7.7 of the 1990 оны ЕАБХАБ-ын Копенхагены Баримт Бичгийн 7.7 догол мөрд сонгогчид сонгуулийн өдөр чөлөөтэй, хүчирхийлэл, дарамт, сүрдүүлгээс ангид саналаа өгөх боломжоор хангагдах ёстой талаар заасан.



хязгаарлажээ. Гэсэн хэдий ч, сонгуулийн кампанит ажлыг зөвхөн бүртгэгдсэн хүмүүсээр хязгаарлах нь улс төрийн мэтгэлцээнийг хумьж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах үр дагавартай байгаа нь олон улсын стандартад нийцэхгүй байна.⁴⁶ Нийгмийн сүлжээнд нэр дэвшигчийг гүтгэх, гутаан доромжлох, худал мэдээлэл түгээх нь хуулиар хориотой. УИХ-ын Сонгуулийн тухай хуулиар Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (ХХЗХ) бусад байгууллагын хамт цахим сурталчилгаанд хяналт, мониторинг хийх үүрэг хүлээдэг. Гэвч, ХХЗХ цагдаагийн байгууллагаас ирсэн гомдол, мэдээлэлд үндэслэн хариу арга хэмжээ авч буй нь энэ сонгуулийн мониторинг үр дүнтэй хийх арга биш юм.⁴⁷

Улс төрийн ихэнх намууд сурталчилгааны гол хэсгээ Фейсбүүкээр явуулах талаар мэдэгдсэн.⁴⁸ Улс төрийн өрсөлдөгчид кампанит ажлын үйл явдлыг идэвхтэй хуваалцаж, хэвлэлийн бага хурал шууд дамжуулж, өөрсдийн Фейсбүүк хуудаснаа нэр дэвшигчдээ сурталчилж байлаа.⁴⁹ Ерөнхийдөө нийтлэгдсэн контентуудын өнгө аяс төвийг сахисан, эдийн засаг, бүс нутгийн хөгжил, нийгмийн асуудлуудад төвлөрсөн. АН, Үндэсний Эвсэл, МАН контентууд хамгийн идэвхтэй нийтэлж, хамгийн их хүнд хүрч байсан. ОУСАХ-ны ярилцсан хэд хэдэн сөрөг хүчний намууд зохион байгуулалттай Фейсбүүкээр өрнүүлсэн кампанит ажил нь худал мэдээлэл дамжуулах замаар тэдний нэр хүндэд халдаж байсан гэж мэдэгдсэн юм.

АН, МАН, Эх орон намаас бусад бүх улс төрийн нам, эвслүүд хуульд заасан квотоос илүү олон тооны эмэгтэйг нэр дэвшүүлжээ. АН, ХҮН нам, Иргэдийн Оролцооны Нэгдэл нам гэх мэт хэд хэдэн улс төрийн нам улс төрд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхийг уриалав. Эмэгтэй нэр дэвшигчид улс даяар идэвхтэй кампанит ажил өрнүүлж байсан хэдий ч, эмэгтэйчүүдэд чиглэсэн улс төрийн мессеж бараг байхгүй, эрчүүд кампанит ажилд голлох үүрэгтэй оролцсон.⁵⁰



СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДАЛ

Сонгуулийн сурталчилгааг иргэн, хуулийн этгээдээс авсан хандив болон нам, нэр дэвшигчийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжтой. ЯАГ-т бүртгэлтэй банкны дансаар бүх гүйлгээг хийх ёстой.

Иргэнээс өгөх хандивын хэмжээ арван сая төгрөгөөр (2,750 орчим евро), хуулийн этгээдийн хувьд гучин сая төгрөгөөр (8,250 орчим евро) хязгаарлагдана. Нэг сая төгрөгөөс (275 орчим евро) дээш хандив өгсөн иргэний нэр, 2 сая төгрөгөөс (550 орчим евро) дээш хандив өгсөн хуулийн этгээдийн нэрийг ЯАГ нийтлэх үүрэгтэй. Мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна. Хуулиар хандив өгөхийг хориглосон этгээдийг жагсаасан.⁵¹ Хандив өгөхийг хориглосон этгээдээс хандив авсан тохиолдолд нэр дэвшигчийн бүртгэлийг хүчингүй болгох үндэслэл болно. Гэхдээ энэ арга хэмжээг зөвхөн санал авах өдрөөс өмнө авах боломжтой ба зөрчил үүссэн даруйд л илрүүлээгүй бол үр нөлөө нь буурдаг.

ЯАГ нь сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийг хянадаг ба сонгуулийн сурталчилгааны зардлын дээд хэмжээг СЕХ-ны баталсан аргачлалаар сонгуулийн тойргийн хэмжээ, байршил, түүнчлэн өрх болон сонгогчдын тоог харгалзан тогтоодог. Энэ удаагийн сонгуулиар нам болон эвсэл нь 6.4 тэрбум (1.7 сая орчим евро) төгрөг зарцуулах боломжтой байна. Сонгуулийн тойргоос хамаарч нэр дэвшигчид 0.9 - 1.5 тэрбум (244,000-407,000 орчим евро) төгрөг зарцуулах боломжтой байна. ОУСАХ-той уулзаж ярилцсан хүмүүс зардлын дээд хэмжээ өндөр байгаа нь хангалттай эх үүсвэртэй, байгуулагдаад удсан намуудад давуу байдал бий болгож байна гэж үзсэн. Хэдий МУИХСтХуулиар ЯАГ-т сонгуулийн сурталчилгааны санхүүжилт болон зарцуулалтад бие даан болон бусад байгууллагуудтай хамтран хяналт тавих эрхийг олгосон боловч ЯАГ нь баримт мэдээлэл хайх, хяналт тавих ямар нэгэн үйл ажиллагаа явуулдаггүй байна.⁵² Үр дүнтэй хяналтын механизм байхгүй байгаа нь хуулийн зохицуулалтын үр нөлөө болон намуудын хариуцлагатай байдлыг бууруулсан байна.

АИХЭГаас өгсөн зөвлөмжийн дагуу 2020 оноос хойш УИХ-ын сонгуульд оролцогчид сонгуулийн зардлын болон хандивын тайлангаа санал авах өдрөөс 3 хоногийн өмнө ЯАГ-т хүргүүлж, ЯАГ нийтэлдэг болсон. ЯАГ 6-р сарын 26-

46 Хуульд сурталчилгааг нэр дэвшигч, шадар туслах, сонгуулийн менежер, ухуулагч нар л явуулах эрхтэй.

47 Сонгуулийн хууль зөрчсөн тохиолдолд цагдаа, тагнуулын байгууллагын зөвлөмж дээр үндэслэн ХХЗХ сонгуулийн үр дүн бүрэн гарч дуустал тухайн контентыг устгах, хязгаарлах хүсэлт гаргах боловч, нийгмийн сүлжээний платформ нь устгах, цуцлах эсэхийг шийднэ. ЯАГ нийгмийн сүлжээнд зарцуулж буй зардлыг хянаж, шалгадаггүй..

48 2024 оны 1-р сарын байдлаар Фейсбүүк 2,5 сая идэвхтэй хэрэглэгчтэй хамгийн өргөн нийгмийн сүлжээ, юм. DataReportal-д, дурдсанаар Монгол Улсад интернэтийн нэвтрэлт 83.9 хувьтай байна

49 5-р сарын 29-ний өдрөөс эхлэн сонгуулийн албан ёсны сурталчилгааны хугацаа эхэлтэл АИХЭГ-ын САХ улс төрийн нам, эвсэл, улс төрчид болон бусад оролцогч талуудын Фейсбүүкийн 25 хаягийг дагасан. Албан ёсны сурталчилгааны хугацаанд нийтдээ улс төрийн нам, эвслийн 9, нэр дэвшигчид, улс төртэй холбоотой 21 нийтдээ 32 Фейсбүүкийг дагасан.

50 АИХЭГ-ын САХ-ны ажигласан сонгуулийн сурталчилгааны 50 арга хэмжээг ажигласнаас 31 арга хэмжээнд 57 эмэгтэй илтгэгч оролцсон бол харьцуулахад эдгээр арга хэмжээнд нийт 200 эрэгтэй илтгэгч оролцсон юм. Ажигласан сонгуулийн сурталчилгааны арга хэмжээнд оролцогчид, үзэгчдийн дунджаар 56 хувь нь эмэгтэйчүүд байлаа.

51 Гадаадын иргэд, олон улсын байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, харьяалалгүй хүн, насанд хүрээгүй хүн, татварын өртэй хуулийн этгээд, үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага болон байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд.

52 ЯАГ нь аймаг бүрд салбар хэлтэстэй.

ны өдөр мажоритар өрсөлдөөнд нэр дэвшиж буй 969 нэр дэвшигчийн, үүнд 42 бие даан нэр дэвшигч, 2 эвсэл, 19 намын нэр дэвшигчдийн явцын тайланг нийтэлсэн. Нам, эвсэл санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан эцсийн тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан хүргүүлэх үүрэг хүлээдэг. УАГ нь зөрчил гарсан тохиолдолд хариуцлага тооцох эрх хэмжээгүй ба харин холбогдох эрх бүхий байгууллагууд руу шилжүүлдэг.⁵³ Сонгуулийн сурталчилгаатай холбоотой орчинд АИХЭГ-аас өмнө нь зөвлөмжүүд өгч байсан ч гэсэн хяналт тавих үр дүнтэй механизм болон анхааруулах арга хэмжээ авах зохицуулалт дутагдаж байна.⁵⁴



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс 400 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүхий олон ургалч хэвлэл мэдээллийн орчинтой. Интернэтийн өргөн хэрэглээ нь нийгмийн сүлжээний ач холбогдлыг өндөрсгөж, телевизээс гадна мэдээлэл авах үндсэн эх сурвалж болжээ. ОУСАХ-ны хэд хэдэн ярилцагчид хэвлэлийн эрх чөлөө дордож⁵⁵ байгааг тэмдэглэсэн төдийгүй бүтцийн шинжтэй олон асуудал буйг онцолж, ялангуяа хэвлэл мэдээллийн байгууллагын эдийн засгийн тогтвортой байдал хангалтгүй байгаа нь мэргэжлийн болон ёс зүйн стандарттай зөрчилдөж, олон нийтийн итгэл бага буйд нөлөөлж байгаа гэв.

Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевиз (МҮОНРТ) телевизийн 8 суваг, радио станцтай бөгөөд олон нийтийн дунд харьцангуй нэр хүндтэй. Дийлэнх хэвлэл, мэдээллийн хэрэгсэл хувийн хэвшлийнх бөгөөд хязгаарлагдмал зар, сурталчилгааны зах зээлд өрсөлдөж буй нь тэднийг эзэмшигчээсээ хараат байлгадаг. ОУСАХ-ны хэд хэдэн ярилцагчийн хэлснээр, хэвлэл мэдээллийн хэрэгслийн дийлэнх нь улс төрийн хамаарал бүхий, эзэмшигчид нь хэвлэл мэдээллийг үндсэн бизнес гэж үздэггүй, харин хэвлэл мэдээллийн хэрэгслийг өөрсдийн эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалахад улс төрийн хөшүүрэг болгож ашигладаг байна. Түүнчлэн, гэрээнд

суурилсан тогтолцоо сэтгүүлчдийн дунд өргөн ашиглагддаг бөгөөд редакцын таатай контентод төлбөр санал болгодог байна.

Үндсэн хууль үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулж, бусад хууль тогтоомж хэвлэл мэдээллийн хэрэгслийн орчныг дэлгэрэнгүй зохицуулдаг. 2017 онд гүтгэлгийг гэмт хэргээс хассан ч, худал мэдээлэл түгээхтэй холбоотой хуулийн заалт 2020 онд дахин оруулсан нь олон улсын стандарттай зөрчилдөж байна.⁵⁶ Түүнчлэн, УИХ-ын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчийг гүтгэх, нэр хүндэд нь халдах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд худал мэдээ өгөх, нийтлэхийг хориглодог. ОУСАХ-ны ярилцагчдын мэдээлснээр төрийн байгууллага, өндөр түвшний улс төрчид, төрийн албан хаагчид гомдол гаргаснаас хамгийн багадаа 7 сэтгүүлч одоогоор шалгагдаж байна.⁵⁷ Эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилт эрэн сурвалжлах сэтгүүл зүйг боомилсноос, сэтгүүл зүй өөрийгөө цензурдэхэд хүргэж, ерөнхийдөө улс төр, нийгмийн шүүмжлэлт хэлэлцүүлэг өрнөхөд сөрөг нөлөө үзүүлж байна.

УИХ-ын сонгуулийн тухай хууль, түүнтэй уялдаж гарсан ХХЗХ-ны журмуудад, сонгуулийн кампанит ажлыг өргөн нэвтрүүлгийн болон интернэтийн орчин зохион байгуулахыг зөвшөөрдөг. МҮОНТ нэр дэвшигчдэд эфирийн цагийг, мэтгэлцээний болон бусад хэлбэрээр үнэгүй олгох үүргээ биелүүлсэн. 6-р сарын 10-ны байдлаар аль аль өрсөлдөөнд нэр дэвшигчдийг оролцуулсан 55 удаагийн мэтгэлцээн зохион байгуулжээ. ХХЗХ-ны баталсан цагийн хуваарийн дагуу өдрийн гурван удаагийн мэтгэлцээнийг МҮОНТ болон радиогоор зэрэг дамжуулав. Гэсэн хэдий ч, мэтгэлцээний дийлэнх нь оргил цагаар цацагдаагүйгээс сонгогчдод мэдээлэл олгож чадсан нь эргэлзээтэй үлдсэн юм.⁵⁸ МҮОНТ-ийн мэтгэлцээнд нийт 304 хүн оролцсоны 24 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Хувийн телевизээр өдөрт 60 хүртэлх минут төлбөртэй контент дамжуулахыг зөвшөөрдөг.⁵⁹ УИХ-ын сонгуулийн тухай хуулиар мэдээллийн хөтөлбөрийн дундуур нэг өрсөлдөгчид 5 хүртэлх минут мэдээ бэлдэхээр хязгаарладаг. Өргөн нэвтрүүлгийн болон цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд

56 Эрүүгийн хуулийн 13.14-р зүйл. ИБУТЭОУП-д өгсөн 1996 оны 34-р ерөнхий санал зөвлөмжид "Улс орнууд гүтгэлгийг гэмт хэрэг гэж үзэхгүй байх асуудлыг авч үзэх ёстой бөгөөд гагцхүү хамгийн ноцтой тохиолдолд эрүүгийн хуульд оруулах эсэхийг бодолцохын зэрэгцээ, хорих ял нь хэзээ ч хамгийн зохистой шийтгэл байдаггүйг анхаарвал зохино" гэжээ.

57 2023 оны 12-р сард хамгийн алдартай цахим мэдээний сайтуудын нэг Zarig.mn-ий ерөнхий эрхлэгч худал мэдээ тараасан гэх үндэслэлээр саатуулагдсан бөгөөд 2024 оны 2-р сард суллагдсан хэдий ч гэрийн хорионд байгаа аж. Түүний хэргийн талаарх сонсгол сонгуулийн дараа 2024 оны 7-р сарын 1-ний өдөр товлогдсон бөгөөд 5 хүртэлх жилийн ялтай 4 зүйлээр буруутгаж байгаа юм.

58 Өдөрт 10:00, 14:00, 17:50 цагуудад 3 удаагийн мэтгэлцээ цацагдсан. Мэтгэлцээн бүрд 5 хүртэлх тооны зочид орох бөгөөд 6-р сарын 8-ны өдөр МҮОНТ-ийн зохион байгуулсан сугалааны дагуу ярилцах 2 сэдвийг урьдчилан тодорхойлсон 102 сэдвээс сугалж тодруулсан. 6-р сарын 26-ны өдөр буюу сүүлийн өдрийн мэтгэлцээн (6-7 оролцогчтой 5 удаагийн мэтгэлцээн) 16 цагт эхэлж 4 цаг үргэлжлэв. Хувийн хэвшлийн Тэнгэр ТВ өдөр бүр төлбөрт мэтгэлцээний хөтөлбөрүүдийг оргил цагаар (оройн 21 цагаас) дамжуулж байсан нь үзэгчдийн анхаарлыг татаж байв.

59 Нийт 125 өргөн нэвтрүүлгийн суваг, үүнээс 83 телевиз, 42 радио, мөн 245 цахим мэдээллийн хэрэгсэл улс төрийн сурталчилгаа нэвтрүүлэхээр СЕХ-нд бүртгүүлжээ.

53 Хандив өгөхийг зөвшөөрсөн хүн хандив өгсөн эсэхийг Татварын улсын байцаагч, тайлантай холбоотой асуудлаар Сангийн яам; нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудлаар Төв банк.

54 2020 оны АИХЭГ болон Венецийн комиссын хамтран гаргасан Улс төрийн намын зохицуулалтын тухай удирдамжийн 272 дахь хэсэгт: Холбогдох хууль, журмыг зөрчсөн улс төрийн намд арга хэмжээ авах ёстой бөгөөд эдгээр арга хэмжээ нь анхааруулсан шинжтэй байх ёстой. Түүнчлэн арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой байхаас гадна, тэдгээр нь ямар ч үед бодитой, үр дүнтэй, зөрчилд тохирсон байх ёстой.

55 Хил Хязгааргүй Сэтгүүлчдээс гаргадаг 2024 оны Хэвлэлийн Эрх чөлөөний индексээр 180 орноос 109-р байранд орсон нь 21 байраар ухарсан үзүүлэлт юм.

тавих хяналыг хэд хэдэн байгууллага хамтран гүйцэтгэнэ. Шударга өрсөлдөөн, Хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) хөндлөнгийн гэрээт гүйцэтгэгчээр дамжуулан контентын агуулгыг үнэлэхгүйгээр тэнцвэртэй мэдээлэл дамжуулж буй эсэхийг эфирийн цагийг хэрхэн хуваарилж буйг хянана. Харин ХХЗХ гомдол, мэдээлэлд үндэслэн мэдээний цагт зарцуулагдаж буй хугацаа, төлбөрт нэвтрүүлгийн цаг зэргийг ханана. ХХЗХ цахим болон цахим бус контентыг устгах, гэх мэт өргөн хүрээний эрх мэдлийг эдлэх боловч, ОУСАХ-нд ерөнхийдөө зөвлөх байдлаар ажиллахыг зорьж буй талаар мэдэгдсэн юм.

6-р сарын 1-ний өдрөөс АИХЭГ-ын САХ Монголын гол хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд медиа мониторинг хийж эхэлсэн.⁶⁰ Сонгуулийн кампанит ажил албан ёсоор эхлэхээс өмнө, голлох өргөн нэвтрүүлгийн сувгууд эрх баригчдын талаар мэдээллийг эерэг болон төвийг сахисан голдуу байр сууринаас өргөн хүрээнд дамжуулсан. Харин сурталчилгааны үеэр мониторинг хийсэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр МАН, АН, ХҮН нам зэрэг голлох улс төрийн намуудад төвлөрч байлаа.

ОУСАХ-ны олж илрүүлснээр МҮОНТ албан ёсны сонгуулийн кампанит ажлын үеэр МАН-ыг илэрхий дамжуулж байлаа. МҮОНТ мэдээллийн сурвалжилгын 37 хувийг МАН-д зарцуулсан бөгөөд эерэг эсвэл төвийг сахисан өнгө аястай байна. Хэвлэл мэдээллийн мониторингд хамрагдсан бусад хувийн телевизүүд ч ойролцоо хандаж байсан төдийгүй, TV9 телевиз, ерөнхийлөгч асны өмчлөлд байдаг, одоогийн Соёлын сайд хатагтай Чинбатын Номингийн хувь эзэмшдэг Монгол ТВ мэдээллийн сурвалжилгын цагийн 68 хувийг одоогийн эрх баригч МАН-д, 50 хувь нь эерэг өнгө аястай дамжуулжээ. NTV телевиз эрх баригч МАН-ын шүүмжлэх төлөвтэй байсан бол, Ийгл телевиз гол өрсөлдөгчдийн талаарх мэдээллийг харьцангуй тэнцвэртэй дамжуулсан. Мониторингд хамрагдсан 6 цахим мэдээллийн хэрэгсэл улс төр, сонгуультай холбоотой мэдээллийн үлэмж хэсгийг МАН-д зарцуулсан нь 23-42 хувийг эзэлж байна. Ихэнх хэвлэлүүд эрх баригч намын талаар эерэг, төвийг сахисан өнгө аястай мэдээлэл дамжуулсан бол, itoim.mn илүү шүүмжлэлтэй хангаж, АН-ын талаар хамгийн их (39 хувь) мэдээлэл дамжуулсан. Сөрөг хүчний намууд мониторинг хийсэн цахим хэвлэлийн хэрэгслүүдийн 12-33 хувийг эзэлсэн бөгөөд дийлэнхдээ төвийг сахисан өнгө аястай байна.

ОУСАХ-ны мониторингд хамрагдсан өргөн нэвтрүүлгийн сувгуудын мэдээний хөтөлбөрт багтсан сурвалжилга нь намуудын төлбөртэй сурталчилгаатай давхцаж байсан хэд хэдэн тохиолдлыг илрүүлсэн нь тухайн контентыг намууд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгсөн болохыг харуулж байна. Ерөнхийдөө мэдээ, сурвалжилгын хязгаарлагдмал байдал, эрэн сурвалжилсан, анализ дүгнэлт бүхий мэдээлэл бараг л харагдаагүй тул сонгогчдод мэдээлэлд суурилан сонголт

хийх бололцоог хангалттай олгоогүй.

Медиа мониторингийн хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд намын болон засгийн газрын өндөр албан тушаал хашиж буй эмэгтэйчүүдийн төлөөлөл хязгаарлагдмал байв. Мониторинг хийсэн телевизийн сувгуудад эмэгтэй нэр дэвшигчийн талаарх мэдээлэл 9-35 хувийг эзэлсэн бол, цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулсан улс төрийн болон сонгуультай холбоотой мэдээлэлд 9-15 хувийг эзлэв.



СОНГУУЛИЙН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

Сонгуулийн хороод шатлан захирах зарчмаар буюу засаг захиргааны бага нэгжийн хорооны шийдвэрт холбогдуулан дээд шатны засаг захиргааны нэгжийн хороонд гомдол гаргадаг. СЕХ-ны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын Дээд Шүүх хяналтын журмаар хянан шийдвэрлэдэг. Санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн СЕХ-ны шийдвэрт холбогдуулан иргэнээс гаргасан гомдлыг Үндсэн Хуулийн Цэц хянан шийдвэрлэдэг. Сонгуультай холбоотой зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг цагдаагийн байгууллага шалгаж дүүргийн шүүх хянан шийдвэрлэдэг. ОУСАХ-той уулзаж ярилцсан хүмүүсийн зарим нь шүүхийн хараат бус байдалд олон нийт итгэл алдарч байгаа тухай үзэл бодлоо илэрхийлсэн.⁶¹

Шүүхээр сонгуультай холбоотой хэрэг маргааныг шуурхай шийдвэрлэх журам байхгүй. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар шүүх маргааныг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд энэ хугацааг нэг удаа 10 хүртэл хоногоор сунгаж болно. Улсын Дээд Шүүхэд давж заалдсан гомдлыг 21 хоногийн хугацаанд хянан шийдвэрлэдэг. Мөн МУИХСтХуульд сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэж байгаа эрх бүхий этгээд нь тухайн гомдол, маргааныг сонгуулийн жилд багтаан шийдвэрлэнэ гэж заасан нь бусад хуулийн зүйл заалттай зөрчилдөж байна. Хэдий шүүх сонгуультай холбоотой маргааныг цөөн хоногийн дотор шийдвэрлэхийг эрмэлзэн ажиллаж байгаа ч, өмнөх АИХЭГ-аас өгсөн зөвлөмжийг үл харгалзан, сонгуулийн маргааныг шийдвэрлэх хугацаа нь

60 Үүнд, МҮОНРТ, (радио, ТВ аль аль нь) хувийн хэвшлийн Ийгл ТВ, Монгол ТВ, NTV, TV9, MN25 телевиз болон цахим мэдээний eduur.mn, gogo.mn, ikon.mn, itoim.mn, news.mn, zarig.mn зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг хамруулав. Мониторингийн хүрээнд тоон болон чанарын арга зүй ашиглан оргил цагийн ТВ-ийн мэдээллийн хөтөлбөрүүд, улс төрийн болон сонгуулийн холбогдолтой контентуудад төвлөрч өрсөлдөгчдийн болон улс төрийн этгээдүүдийн хэвлэл мэдээлэлд эзлэх цаг, хэмжээг үнэлэхийг зорьсон.

61 2023 оны Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн урьдчилсан ажиглалтуудад шүүх эрх мэдэлд итгэх итгэл байхгүй байгаа талаар болон шүүгчдийг гутаан доромжлох зорилгоор нийгмийн сүлжээг ашиглах асуудлуудыг хөндсөн байна. Зарим тохиолдолд төрийн албан тушаалтнууд хүртэл үүнд оролцдог. Авлигын эсрэг хараат бус байгууллагаас 2022 онд гаргасан Хууль сахиулах байгууллагуудын авлигын талаарх тайланд шүүх болон прокуратурын газруудыг авлигад хамгийн их автсан байгууллагуудын нэг гэж үзсэн байна.



сонгуулийн цаг хугацааны хуваарьтай уялдахгүй байна. Иймд хэрэг хянан шийдвэрлэх хугацаа нь цаг хугацааны тохиромжтой байдал болон зөрчигдсөн эрхийг сэргээх үр нөлөөг хангаж чадахгүй байна.

Сонгуулийн жил эхэлснээс хойш 6 дугаар сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд сонгуультай холбоотой нийт 786 гомдол, мэдээлэл цагдаагийн байгууллагад ирснээс зөрчлийн шинжтэй 471, гэмт хэргийн шинжтэй 315 гомдол мэдээлэл бүртгэгдсэн байна. Цагдаагийн Ерөнхий Газар нийт гомдол мэдээллийн 65 хувийг сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараасантай холбоотой гомдол мэдээлэл эзэлж байна гэж мэдээлсэн.

Сонгуулийн өмнөх хугацаанд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нам, нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой нийт арван таван нэхэмжлэл ирсэн. Үүнээс таван нэхэмжлэлийг шүүх хүлээн авахаас татгалзсан. Шүүхээр шийдвэрлүүлсэн арван маргааны тавынх нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, СЕХ-ны шийдвэрийг хүчингүй болгож, нэр дэвших боломжоор нь хангасан байна. Дээрх шийдвэрүүдийн дөрөв нь сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш гарсан байна.



ИРГЭНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧИД

Хуулиар иргэд, сонгуульд өрсөлдөж буй субъектүүдийн хууль ёсны төлөөлөл болон олон улсын байгууллагаас сонгуулийн ажиглалт хийх боломжийг хангажээ. Хуулийн зохицуулалтаар ажиглагчид нэг байгууллагаас нэг санал авах байран дээр 2-оос дээшгүй байх, ажиглалтыг төрийн албан хаагч хийхийг хориглох зэрэг хязгаарлалтууд орсон байна. Нам, эвслүүд мөн ажиглагчдаа санал авах байранд томилох боломжтой байна.



САНАЛ АВАХ ӨДӨР

Сонгуулийн өдөр үндсэндээ нам гүм, эмх цэгцтэй байсан бөгөөд санал хураах үйл явц том зургаараа журмын дагуу явагдсан боловч санал авах байрны зохион байгуулалт зохистой бус, санал тоолох төхөөрөмжийг буруу байрлуулсан, зарим тохиолдолд санал авах байранд хэт ачаалал үүссэн зэрэг нь сонгогчийн нууцлалт сөрөг нөлөө үзүүлээ. СЕХ ирцийн мэдээллийг өдрийн туршид үзүүлж, санал өгөх хугацаа дуусмагц, сонгуулийн үр дүнг дамжуулж эхэлсэн нь сонгуулийн ил тод байдалд чухал хувь нэмэр оруулсан. Сонгуулийн ирцийг 69.3 хувь залуу сонгогчдын ирц харьцангуй сул байсан талаар мэдээлэв. Албан ёсны

62 Сүлжээ нь Сонгогчдын боловсрол төв, МИДАС, Баримт шалгах төв, Бодлогод залуусын хяналт, Глоб Интернэшнл төвөөс бүрдэж байгаа ба Нээлттэй нийгэм форумтай хамтран удирдан зохион байгуулдаг.

63 Өвөрхангай, Баян-Өлгий, Хөвсгөл, Дундговь, Хэнтий, Увс (Улаангом, Өмнөговь сум), Говь-Алтай, Сэлэнгэ, Дархан.

64 СЕХ нь 21 байгууллагаас томилсон 40 улсын 259 олон улсын ажиглагчдад итгэмжлэл олгосон. Мөн СЕХ Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг гадаадын байгууллага болон дипломат төлөөлөгчийн газруудад урилга илгээж 68 олон улсын ажиглагчдад нэмж итгэмжлэл олгосон.



саналын тооллого автоматаар явагдаж мэдээллийг СЕХ-ны төв сервер рүү шууд дамжуулсан. Гэвч сонгуультай холбоотой дүрэм, журмын хэрэгжилт нь сонгуулийн хэсгийн хорооны түвшинд санал хураалт хаагдах, гар тооллого хийх үед хангалтгүй байсан ба зарим тохиолдлуудад сонгуулийн өдөртөө багтааж тоолж дуусгаагүй байна.

Санал авах байрууд яг цагтаа зарим тохиолдолд үл ялиг хочорч нээгдсэн. Сонгуулийн нээлтийн үйл ажиллагааг 75 санал хураах байранд ажиглалт хийснээс 69 байранд эерэг үнэлгээ өгсөн ба дүрэм, журмуудыг ерөнхийдөө дагаж мөрдсөн байна. Саналын хайрцгийг битүүмжлэхээс өмнө хоосон болохыг сонгуулийн хэсгийн хорооны гишүүдэд харуулаагүй 5 тохиолдол бүртгэгджээ.

ОУСАХ-ны ажиглагчид нийт ажиглалт хийсэн санал авах байрны 98 хувьд санал хураалтын явцыг эергээр дүгнэж, зохион байгуулалт сайтай, саадгүй явагдсан гэж дүгнэжээ. Ажиглалт хийсэн нийт санал авах байрны 14 хувь нь сонгогч нууцаар саналаа өгөхөд ерөөний зохион байгуулалт муутай, ялангуяа Улаанбаатар хотод санал авах байрны 10 хувь нь хэт ачаалал үүссэнээс сонгогч, сонгуулийн хэсгийн хорооны гишүүд, санал тоолох төхөөрөмж хэт ойр байсан зэрэг зүйл ажиглагдав.⁶⁵ ОУСАХ-ны ажиглалтын 22 хувьд санал авах байрны гадаа дараалал үүссэн байна. Санал авах байрны

7 хувьд санал тоолох төхөөрөмжтэй холбоотой асуудал үүссэнээс бага зэрэг саатал учрахад нөлөөлсөн байж болзошгүй.

Ажиглалтад хамрагдсан хэсгийн хороодын гишүүдийн 85 хувийг, сонгуулийн хэсгийн хорооны дарга нарын 78 хувийг эмэгтэйчүүд эзэлсэн байна. Ажиглалтын 99 хувьд нь улс төрийн нам, нэр дэвшигчийн ажиглагчид оролцсон нь ил тод байдлыг хангахад хувь нэмэр оруулсан ч, 9 хувьд санал авах байран дахь ажиглагчид сонгуулийн үйл явцыг нээлттэй ажиглах хангалттай харууц байсангүй.⁶⁶ Иргэний нийгмийн ажиглагчид санал хураах байрны 12 хувьд нь ажиллаж байсан ба эдгээрээс дийлэнх нь нийслэлд байршиж байв. ОУСАХ-ны ажиглагчид сонгуулийн санал авах байранд цагдаа байлцсан олон тохиолдол (36 хувь) байсан бөгөөд хуульд санал авах байранд цагдаа байхыг хориглоогүй ч цагдаа нар үйл явцад хөндлөнгөөс оролцсон тохиолдол цөөн тохиолдол гарсан байна.

Санал авах журмыг ерөнхийд нь мөрдөж ажилласан боловч ажиглалтын үеэр сонгогчдын 14 хувь нь хурууны хээгээ уншуулж чадаагүй байна. Сонгуулийн зохион байгуулах албан хаагчдын үзэж байгаагаар хурууны хээ нь насжилтаас шалтгаалж өөрчлөгддөг ба энэ нь голчлон ахмад сонгогчдод нөлөөлсөн бөгөөд эдгээр сонгогчдыг журмын дагуу иргэний үнэмлэхээр нь баталгаажуулжээ.

⁶⁵ Сонгогчид саналын хуудсаа ихэвчлэн дээш нь харуулан уншуулж байсан тул саналын хайрцагт ойрхон зогсож буй хүн сонгогчийн саналаа хэрхэн өгч буй харах боломжтой байлаа.

⁶⁶ Ажигласнаар АН 97, МАН-96, ХҮН нам 41, Үндэсний эвсэл 30 хувьд нь ажиглагч томилсон байна.

Санал авах байрны 6 хувьд нь гэр бүлээрээ хамтран санал өгөх зүйл явагдсан бөгөөд эдгээр нь ихэнхдээ хөдөө орон нутагт болсон байна. Ажиглалтын долоон хувьд зарим сонгогчид журмын дагуу иргэний үнэмлэхээ үзүүлэлгүй, хурууны хээгээр өөрийгөө таниулан саналаа өгчээ. Санал авах байрны 18 хувьд нь сонгогчдын нэрийн жагсаалтад ороогүй сонгогч ирж байсан тул өөр газар санал өгөх тухай зааварчилгаа авсан болохыг талаар ОУСАХ-ны ажиглагчид тэмдэглэжээ.

ОУСАХ-ны ажиглагчид сонгуулийн луйвартай холбоотой ноцтой зөрчил ажигласангүй. Зарим тохиолдолд сонгогч өөрийгөө таниулах үед улс төрийн намууд сонгогчийн зургийг харуулж буй дэлгэцийн зургийг дарж байсан юм.

Харааны бэрхшээлтэй иргэдийн оролцоог дэмжих үүднээс нийт санал авах байрны 98 хувьд нь томруулдаг шил, 93 хувьд нь брайл үсэгтэй маягт байрлуулах гэх мэт чухал арга хэмжээг авсныг онцлон тэмдэглэе. Гэсэн хэдий ч санал авах байрны ердөө 40 хувь нь хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд нэвтрэхэд тохиромжтой байсан юм.

СЕХ санал хураалтын ирцийн мэдээг олон давтамжтай танилцуулсан нь ил тод байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулсан. Ирцийн мэдээг сонгуулийн тойргоор болон аймаг, дүүргээр, сонгогчдын хүйс, насны бүлгээр ангилан мэдээлсэн. Санал хураалт хаагдахад сонгуулийн ирц

69.3 хувь гэж мэдээлсэн бөгөөд 20-24 насны залуу сонгогчдын (49.6 хувь эрэгтэй, 43.7 хувь нь эмэгтэй) ирц харьцангуй сул байв. Эмэгтэй сонгогчдын ирц, эрэгтэй сонгогчдын ирцээс 8 хувиар өндөр байлаа.

СЕХ-ны төхөөрөмжөөр санал тоолох, сонгуулийн дүнг гаргах үйл явцыг үндсэндээ эергээр үнэлж байна. Гэсэн хэдий ч, 64 ажиглалтын 18-д нь журамласан үйл явцыг ягштал биелүүлээгүй нь зарим талаар сөрөг үнэлэхэд нөлөөлөв. Сонгуулийн хэсгийн хороодын гуравны нэг нь ашиглаагүй, буруу тэмдэглэсэн саналын хуудсыг санал тоолохын өмнө төөлж, баглаагүй. Төхөөрөмжөөр санал тоолсны дараа ажигласан 32 санал авах байранд санал тоолох төхөөрөмжийн үр дүнгийн хуудсанд хэсгийн хорооны гишүүд гарын үсэг зураагүй тохиолдлууд гарсан. Түүнчлэн, санал тоолох төхөөрөмжийн үр дүнгийн хуудсыг улс төрийн намын болон нэр дэвшигчийн ажиглагчдад өгөөгүй 8 тохиолдол гарсан юм.

Төхөөрөмжөөр санал тоолох үйл явц дуусмагц хяналтын тооллогыг даруй эхлүүлээгүй 8 тохиолдол бүртгэгдсэн. Хэсгийн 23 хороонд саналын хайрцгаас саналын хуудсыг нэг нэгээр нь гаргаагүй, саналын хуудсыг байлцсан бүх хүнд харуулаагүй 29 ажиглалт тэмдэглэгдлээ. Хяналтын тооллогыг явуулахад үйл явц нь тод харагдахгүй 14 тохиолдол бүртгэгджээ.





МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Засгийн газрын 11 дүгээр байр
Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар – 15141, Монгол Улс

Санал хүсэлт хүлээн авах хаяг:
gecm@m-election.mn
(976) -51 262127

УНДГА
СОНГОЛ